

ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 02/01

Сайншанд сум

“Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл”-ийн биелэлтийг
үнэлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.15, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3, 21 дүгээр зүйлийн 21.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/05 дугаар тогтоолоор батлагдсан “Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэн биелэлтийг 91,2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2.Тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гаргасан санал, дүгнэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нутгийн удирдлагын хөгжлийн хорооны ахлагч (С.Одбаяр), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Н.АЛДАРБАЯР

442240086

ДОРНОГОВЬ АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024.11.28

Сайншанд

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Үнэлгээ
1	1.1. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ.	1.1.1. Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, стандарт шаардлагад нийцсэн орчин, соёл урлагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулна.	2021 - 2025	16.1 тэрбум төгрөг	Санхүүжилтийн хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийн хувь	Замын-Үүд сумын Соёлын ордонд шаардлагатай тоног төхөөрөмжийг "Содон сод оюу" ХХК нь нийт 1,0 тэрбум төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан. Өргөн сумын соёлын төвд "Сити лед" ХХК 99.9 сая төгрөгөөр, Даланжаргалан сумын соёлын төвд "Сүүхүнгий" ХХК 65,2 сая төгрөгөөр, Хатанбулаг сумын Соёлын төвд "Мандала про аудио" ХХК 69,7 сая төгрөгөөр, Мандах сумын Соёлын төвд "Альянстрейд" ХХК 115,3 сая төгрөгөөр тус тус тоног төхөөрөмж нийлүүлсэн. Сайхандулаан сумын Соёлын төв "Илч дулаан өсөх" компани 208,8 сая төгрөгөөр, Иххэт сумын Соёл, спортын төв "Чандмань тайж" ХХК 388,8 сая төгрөгөөр , Алтанширээ сумын Соёлын төв "Мунараконстракшн" ХХК 451,9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч гэрээний хугацаандаа 100%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж хүлээлгэн өгсөн. Саранхөхөө театрын барилгын ажлыг “Болор аграмба” ХХК гүйцэтгэж театрын барилгын суурь, зоорь, 1,2,3-р давхрын рам, хучилтын хийцүүдийн угсралт хийгдсэн. Гадна дотор ханын дүүргэлтийн тоосго, блокон ханын өрлөгийн ажил, цонх суулгах ажлууд хийгдэж байна. Барилга угсралтын ажил 65%-тай явагдаж байна.	100%

2		1.1.2. Орон нутгийн түүх соёлыг илэрхийлсэн бүтээл туурвих, соёлын биет болон биет бус оюуны үнэт өв, бүтээлийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлнэ.	2021-2025	- 65.4 сая төгрөг	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор батлагдсан "Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д Дорноговь аймгаас бүртгэгдсэн 6 үл хөдлөх дурсгал, аймгийн хамгаалалтад байдаг 14 дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хариуцуулан ажиллалаа. Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран мэргэжлийн багаар чулуун арслан, хүн чулуу хөшөөг сэргээн засварлуулж, хадгалалт хамгаалалтыг сайжрууллаа. Гадаад орчны хүчин зүйлээс үүдэн эрсдэлд өртөж буй түүх соёлын үл хөдлөх 10 дурсгалыг ангилан учирч буй нөхцөл байдлын тайлбарлан гэрэл зургийн хамтаар баримтжуулж Соёлын өвийн үндэсний төвийн Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газарт хүргүүлсэн. Замын-Үүд сумын гаальд хураагдсан 35 ширхэг баримтат өвийг сум дундын шүүхийн шийтгэврээр музейн сан хөмрөгт хүлээн авч, бүртгэсэн. Соёлын сайдын 2024 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан Археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрлийн дагуу 2 байгууллага Хатанбулаг сумын нутаг Хасар уул орчим малтлага судалгааны ажлыг зохион байгуулж, судалгааны ажилд 5.0 сая төгрөг зарцуулсан. Иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар хүргэх зорилгоор аймгийн Музейн сургалт судалгааны төвөөс Сайншанд сумын ЗДТГ-тай хамтран Сайншанд хот дахь түүхэн дурсгалт хөшөө дурсгалын тухай дэлгэрэнгүй тайлбарт "Сити тур" аяллыг зохион байгуулж ЕБС-ийн 81 сурагчийг хамруулснаас гадна тэмдэглэлт ойн өдрүүдэд зориулсан 12 удаагийн үзэсгэлэнг 24216 иргэн, тус	100%
---	--	---	-----------	-------------------	--------------------------------------	---	------

						музейгээс хэрэгжүүлдэг 7 боловсролын хөтөлбөрт 2245 хүүхэд багачуудыг хамруулж ажилласан.Тайлант онд соёлын үйлчилгээг нийтдээ 26461 хүүхэд, иргэнд хүргэн ажилласан. Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойд зориулан орон нутгийн түүх, соёлын онцлогийг илэрхийлсэн “Гэтэлгэх мөр” хөгжимт драмын жүжиг, "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжгийг шинээр туурвин 4000 гаруй үзэгчдэд толилуулсан. Монгол Улсын Төрийн өргөмжлөлт 3.Чулуунбаатар агсны нэрэмжит ерөөлч, магтаалчдын наадмыг 5 суманд соёлын биет болон биет бус оюуны үнэт өв, бүтээлийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр нийт 23 томоохон арга хэмжээ зохион байгуулж ажилласан.	
3		1.1.3. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг хэвшүүлнэ.	2021 2025	-	1,0 сая төгрөг	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Иргэд олон нийтэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулах зорилгоор Үндэсний сургагч багш, өв соёл ураг удам судлаач Д.Цогбадрах, хүний их эмч Александр нартай хамтран "Угийн бичиг-Улсын үндэс" хөтлөх номын жишиг танилцуулах, мэдээлэл өгөх сургалтыг "Монгол гэр-Соёлын орон зай" хөтөлбөрт тусган хэрэгжүүлсэн. Тус сургалтыг 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж 50 гаруй иргэнийг хамруулсан. Иххэт, Сайхандулаан, Замын-Үүд, Өргөн, Хөвсгөл сумдын Соёлын төвөөс угийн бичиг хөтлөх арга зүйн 7 удаагийн танхимын болон цахим сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй сурагч 10 залуу гэр бүлийг хамруулсан. Дэлгэрэх сумын Соёл, спортын төвөөс санаачлан Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран хэрэгжүүлсэн "Удам судраа мэдэж, угийн бичгээ хөтөлцгөөе" сарын аяны хүрээнд багийн иргэд, албан байгууллагын нийт 50 гаруй иргэдэд угийн бичиг хөтлөх 2 удаагийн цахим, 3 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан. Замын-Үүд	100%

						сумын иргэн Ганпүрэвийн гар дээр хадгалагдаж буй Боржигон овогт Сандагдоржийн угийн бичиг, Н.Баатархүүгийн гар дээр хадгалагдаж буй Хутагт боржигин овогт Өвгөний Тавхайн удмын угийн бичгийг тус тус баримтат өвд бүртгэн баримтжуулав. Тайлант онд нийт 14 удаагийн сургалтаар 300 гаруй иргэд болон 10 залуу гэр бүлд угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалт арга хэмжээг зохион байгуулж ажилласан. 2022-2024 онуудад угийн бичиг хөтлөх нийт 125 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулсан ба аймгийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 2020 онд 1804 байсан бол 2024 онд 2060 болж угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 14,2%-иар өссөн.	
4	1.2. Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	1.2.1. Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.	2021 - 2025	1,3 сая төгрөг, 20,0 сая төгрөг	Зохион байгуулсан ажлын Шинээр байгуулсан кабинетын тоо тоо	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2021 оноос ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг чанартай эзэмшүүлэхийн тулд 2023-2024 оны хичээлийн жилд 9, 12-р ангийн 1835 сурагчдын дунд монгол хэл, 6-7-р ангийн 2745 сурагчдын дунд үндэсний бичгийн хичээлээр анги хамт олны олимпиадыг зохион байгуулж, ахиц амжилтыг тооцон шилдгүүдийг шалгаруулсан. 2024 оны 9 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд “Эх хэлний өдөр” болон “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг хамтатган зохион байгуулсан. Эх хэлний өдрөөр эх хэл, түүхээрээ бахархах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор монгол хэл, бичиг, түүхийн сэдвээр хичээл бэлтгэн зааж, 541 бүлгийн 16160 суралцагчийг хамруулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/733 дугаар захирамжаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус орон нутгийн салбар зөвлөлийг мэргэжлийн байгууллагын 7 гишүүнтэй шинэчлэн байгуулсан. Төлөвлөгөөний дагуу аймгийн төрийн	90%

					албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох сорил авч, үндэсний бичгийн цахим бичвэр боловсруулах сургалтад 90 гаруй төрийн байгууллагын 380 албан хаагчийг танхимаар, 14 сумын төрийн байгууллагын 100 гаруй албан хаагчийг цахимаар тус тус хамруулсан. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс Сайншанд сумын төрийн 33 байгууллагын архив, бичиг хэргийн 34 ажилтанд монгол бичгийн цахим бичвэрийн давтан сургалт, “Хамтдаа судалъя, хөгжье” үйл ажиллагааг 22 сургууль, 33 цэцэрлэгийн 1500 гаруй багш, “Сүегэр” уран бичлэгийн уралдаанд 27 багш, 23 сурагчийн бүтээл, 6-12-р ангийн үндэсний бичгийн “Анги хамт олны олимпиад”-ыг 3 үе шаттайгаар зохион байгуулж 267 бүлгийн 7377 сурагч оролцсон. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг угтан сургууль бүр өөрийн онцлогтоо тохируулан багш, сурагч, эцэг эх, иргэдийг хамарсан 20 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. 2023 онд насан туршийн боловсролын төвийн болон нэгжийн багш нар үндсэн чиглэл болох амьдрах ухаан, гэр бүл гоо зүйн боловсрол, ёс зүйн төлөвшил, иргэний боловсрол, санхүүгийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, мэдээллийн технологийн чадвар олгох сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, үндэсний бичиг, англи хэлний сургалт, дүйцсэн хөтөлбөр, боловсрол нөхөн олгох зэрэг 201 нэр төрлийн сургалт, нөлөөллийн ажлыг төрийн албан хаагч, иргэд, сурагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийт 23373 иргэнд явуулж ажилласан. Үүнээс 0-18 насны 4840 хүүхэд, 18-55 насны 16803 иргэн, ахмад насны буюу 55-аас дээш насны 1730 иргэн хамруулжээ. Төлөвлөгөөнд 4 чиглэлийн 10 үйл ажиллагаа тусгасан ба хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна.	
--	--	--	--	--	---	--

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

5	2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	2.1.1. Сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	2021 2025	-	-	СӨБ-ын хамрагдалтын хувь	Аймгийн хэмжээнд бүртгэлтэй хүн амын тоогоор 2-5 насны 5888 хүүхэд байгаагаас 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 34 цэцэрлэгийн 176 бүлэгт 5075 хүүхэд, төмөр замын 6 цэцэрлэгийн 26 бүлэгт 651 хүүхэд, нийт 5726 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин 97,2 хувьд хүрч өмнөх оноос 4 хувиар өссөн. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт өмнөх онд 87.5 хувь байсан бол энэ хичээлийн жилд 93.1% болж хүртээмж 5.6 хувиар нэмэгдсэн. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т сургуулийн өмнөх боловсролыг 5 настай хүүхдэд заавал эзэмшүүлэхээр хуульчлан тусгасны үр дүнд 2023-2024 оны хичээлийн жилд 5 настай хүүхдийн хамрагдалт 96.3% болж өмнөх оноос 2.1 хувиар өссөн. Сургалтын үйл ажиллагаанд 33 цэцэрлэгийн 48 бэлтгэл бүлгийн 569 хүүхэд, сургууль цэцэрлэгийн 60 гаруй багш хамтран оролцсон. БСШУСС-ын 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан “Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-ын хүрээнд СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаж байгаа 5 настай 1432 хүүхдээс Боловсролын үнэлгээний төвөөс 1 дүгээр ангид элсэн суралцагчаас авдаг сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд энэ онд 1415 хүүхэд хамруулж цэцэрлэгт эзэмшсэн мэдлэг чадвараа үнэлүүлсэн. Танин мэдэхүй, нийгэмшихүй, бие бялдрын үнэлгээг нэгтгэн дүгнэхэд хангалттай үнэлэгдэж 5 настай хүүхдийн чадварыг бүрэн эзэмшсэн байна. Эцэг эхчүүд, багш, цэцэрлэгийн багш, арга зүйч нар асуулгад хамрагдан хүүхдийг олон талаас нь бодитой үнэлэхэд дэмжлэг үзүүлсэн.	100%
---	---	--	--------------	---	---	--------------------------	---	------

6		2.1.2. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмж, сурлагын чанарт суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.	2021 2025	-	55,0	Зохион байгуулсан уралдаан тэмцээний тоо Үндсэн сургалтад хамрагдсан багшийн тоо Туршлага судалсан багшийн тоо Магистр зэрэгтэй багшийн тоо Сургалтын төлбөрийн дэмжлэг хамрагдсан оюутны тоо	Аймгийн Засаг даргын 2024 оны А/756 дугаар захирамжаар 5,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд "Ур чадвар-2024" сайн хичээл-үйл ажиллагааг 2 үе шаттай зохион байгуулж, шалгарсан багш, удирдах ажилтнууд мэргэжил онол, арга зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой эрхлэгч, арга зүйч, багш нарын бүрэлдэхүүнтэй 7 төрлийн үйл ажиллагаанд мэдлэг, ур чадвараа сорин оролцож, баруун бүсийн цэцэрлэгүүд багаараа шалгарч, арга туршлагаа аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүллээ. Мөн “Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь” сэдэвт аймгийн багш нарын эрдэм шинжилгээний хурлыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2 үе шаттай зохион байгуулсан ба шалгарсан илтгэл улсын эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцсон. Аймгийн Засаг даргын 2024 оны А/755 дугаар захирамжаар 12,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, суралцагчдад монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг чанартай эзэмшүүлэх, оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор "Анги нийтийн олимпиад"-ийг 9, 12-р ангийн нийт сурагчдын дунд монгол хэл, 6-7-р ангийн нийт сурагчдын дунд монгол бичгийн хичээлээр зохион байгуулж, нийт 1098 бүлгийн 4580 суралцагчийг хамруулж, ахиц амжилт, үр дүнг тооцон шилдгүүдийг шалгаруулсан. Мөн сурагчдын хоцрогдлыг арилгах, гүйцэтгэлийн үнэлгээнд ахиц гарган, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 1-12-р ангид дизайн технологи, англи хэл, орос хэл, эрүүл мэнд, математик, физик, бага анги монгол хэл, математик, хүн ба байгаль, үндэсний бичиг судлагдахуунаар “Анги хамт олны олимпиад”-ыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, давхардсан тоогоор 1098 бүлгийн	100%
---	--	--	--------------	---	------	--	--	------

						57111 сурагч хамрагдаж гүйцэтгэл 3,7 %-н ахицтай, судлагдахуун бүрийн гүйцэтгэлийн хувь 1.5%-18.9% -иар ахисан үзүүлэлттэй байна.		
7		2.1.3. Монголын түүх, хэл, соёл, ёс заншлаа мэддэг, эх орноороо бахархдаг төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэнэ.	2021 2025	-	-	Хутагтын нутгаар Торгон хил сэдэвт үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн тоо	2023-2024 оны хичээлийн жилд “Орон нутгийн онцлогт хөтөлбөр”-өөр Замын-Үүд сумын 1-р сургууль, "Үлэмж тэнгэр" болон Зүүнбаянгийн сургуулиуд “Торгон хил-Эх орон” сэдвийн хүрээнд 658 сурагч, 110 багш, ажилчид болон 56 эцэг эх, иргэд нийт 824 хүнийг хамруулан зохион байгуулсан. Мөн өсвөр үе, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 336 дугаар ангитай хамтран “Хутагтын нутгаар-Торгон хил” арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээгээр цэргийн ангийн үйл ажиллагаа болон Монгол цэргийн түүх, соёл, үнэт зүйлстэй танилцуулж, хугацаат цэргийн алба хаагчдын дунд сургалт, ярилцлага зохион байгуулж, 245 хүүхэд, залуучуудыг хамруулсан.	100%
8		2.1.4. Боловсролын салбарт ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	10,7 тэрбум төгрөг	Шинээр баригдсан барилгын гүйцэтгэлийн хувь Их завсар хийгдсэн сургуулийн гүйцэтгэлийн хувь	Хөвсгөл сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварын тендерийг 2024 оны 03 сард зарлан, "Чонод Девеловдминт" ХХК шалгарч, гэрээ байгуулан, засварын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн, улсын комисс хүлээн авсан. Сайншанд сумын 10-р цэцэрлэгийн гадна дулаалгын фасадын 190.0 сая төгрөгийн засварын ажлын тендерт "Дэлгэрэх баян хүлэг" ХХ, Замын-Үүд сумын 2-р цэцэрлэгийн гадна фасад, цонх, шалны 331.8 сая төгрөгийн засварын ажилд "Миний Сайншанд" ХХК шалгарч, гүйцэтгэсэн. Замын-Үүд сумын 4-р цэцэрлэгийн дотор засвар, цэвэр бохир усны шугамын 305.9 сая төгрөгийн засварын ажлын тендерт "Миний Сайншанд" ХХК шалгарч, гүйцэтгэн, улсын комисс хүлээн авсан. Сайншанд сумын 12-р цэцэрлэгийн дотор засал, гадна фасадын 380.2 сая төгрөгийн засварын ажлын	100%

						тендерт "Дэнжийн цамхаг" ХХК шалгаран, гүйцэтгэсэн. Дээрх засварын ажилд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1.3 тэрбум төгрөгийн төсөв зарцуулсан. 2021-2024 онд Боловсролын салбарт улс, орон нутгийн төсвийн 19,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 3 сургуулийг шинээр ашиглалтад оруулан, 17 сургууль, 17 цэцэрлэг, 4 дотуур байранд засвар хийж, боловсролын салбарын давхардсан тоогоор 49 байгууллагад 296 нэр төрлийн 1457 ширхэг тоног төхөөрөмжөөр ханган ажиллалаа.	
9		2.1.5. Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.	2021 2025	-	-	Гал тогооны тоног төхөөрөмж сайжруулсан сургуулийн тоо Ундны усны шүүлтүүрээр хангагдсан сургуулийн тоо "Үдийн хоол" хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 16 сургууль нь үдийн хоолоо бие даан хэрэгжүүлж байна. Мөн Иххэт, Хөвсгөл сумын сургуулиуд нь 6-9 дугаар ангийн 112 сурагчдад үдийн хоол хөтөлбөрийг эцэг, эхийн дэмжлэгтэйгээр туршин нэвтрүүлж 1-5-р ангийн 7868 сурагчийг бүрэн хамруулсан. Нийт 21 сургуулиас 4 сургууль нь хоолны үйлчилгээг заалаар, 17 сургууль нь анги танхимаар үйлчилгээ үзүүлж, бие даан ажиллуулж буй сургуулиудад 49 тогооч болон бусад ажилтнууд хоол үйлдвэрлэл үйлчилгээг явуулсан. Аймгийн Тогоочдын холбоо, ХХААГазартай хамтран сургууль, цэцэрлэгийн тогооч нарын түвшин ахиулах сургалт, шалгалтыг зохион байлгуулсан. Уг сургалт, шалгалтад 21 хүн хамрагдаж, V түвшин 2, IV түвшин 6, III түвшин 10, II түвшин 3 хүн өгсөн. Тогооч нарыг чадавхжуулах сургалтыг онол, дадлагын хичээл хосолсон хэлбэрээр зохион байгуулж, харилцан туршлага судлах уулзалт зохион байгуулсан. Уг сургалтад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 60 хүн хамрагдсан.	100%

						Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/233 дугаар захирамжаар Сайншанд, Замын-Үүд сумдын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт 32 объектод “Үдийн хоол”, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний чанар, аюулгүй байдал, стандартын хэрэгжилт, сургууль орчмын хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээний 6 объектод стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан. Ерөнхий боловсролын 22 сургууль, 33 цэцэрлэг буюу нийт 55 байгууллагууд 64 ширхэг ундны усны шүүлтүүртэй бөгөөд Зүүнбаян багийн Ерөнхий боловсролын сургуульд 2 ширхэг ус цэвэршүүлэгчийг Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтын газраас олгосон. Бүх сургууль, цэцэрлэгийн анги танхимууд цэвэр ус уух нөхцөлөөр бүрэн хангагдсан. Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн хангалт 2020 онд 50,0 хувьтай байсан ба 2024 онд 65,0 хувьтай байна.	
10		2.1.6. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамир, соёлын танхимыг стандартын тоног төхөөрөмжөөр хангаж, соёл, бие бялдрын өв тэгш хөгжилтэй иргэдийг бэлтгэнэ.	2021 2025	-	-	Тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоо Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайг шинэчлэх ажлын тендерийг зарласан. Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн эзэмшлийн талбайд нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажлын тендерийг 2024 оны 08 дугаар сарын 08-нд зарлан, 09 дүгээр сарын 04-нд "Сутай Жинст" ХХК шалгаран гэрээ байгуулан, 10 сарын 05-нд ажил эхэлж бүх цутгалт хийж боржуур суулгах ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 50% байна. Ерөнхий боловсролын сургуулиудын урлаг, биеийн тамирын танхимд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалт 2020 онд 60 хувьтай байсан бол 2024 онд 90 хувь хангагдсан.	90%

11		2.1.7. Цахим сургалтыг хөгжүүлэхэд багш нарын оролцоог дэмжиж, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.	2021 - 2025	100,0 төгрөг сая	Нийлүүлсэн компьютерийн тоо	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх, төлөвлөгөө батлах тухай” А/353 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Сургалтын цахим систем нэвтрүүлэх, зардал батлах тухай” А/312 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилээс ЕБС-ийн 3-4 дүгээр ангид Эдүтэн цахим системд аймгийн 21 сургуулийн 104 бүлгийн 3200 суралцагч, Англи хэлний Pearson хөтөлбөрт 119 бүлгийн 3758 суралцагч хамрагдсан. 2024-2025 оны хичээлийн жил Eduten цахим системд Дорноговь аймгийн төрийн өмчийн 21 сургуулийн 1-5 дугаар ангийн 260 бүлгийн 7900 суралцагч, Англи хэлний Pearson хөтөлбөрт 19 сургуулийн 5-7, туршилтаар Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн 3-10, Сайншанд сумын 2 дугаар сургуулийн 3-7 дугаар ангийн 6059 сурагчид хамрагдаж математик, гадаад хэл, технологийн ур чадвараа хөгжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулийн математикийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанарыг сайжруулах зорилгоор цахим системийн хэрэгжилтэд мониторинг хийн, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүйд дэмжлэг үзүүлэх зорилгоор, БЕГ-ын мониторингийн баг, Боловсролын газартай хамтран 2024оны 10 сарын 08-22нд Сайншанд, Дэлгэрэх, Алтанширээ, Өргөн, Эрдэнэ сумдын сургуульд ажиллалаа. Үйл ажиллагааны явцад сургууль бүр дотоод сүлжээ, интернэт орчин бүхий цахим ангийг байгуулж, кабинетын системээр хичээллэх орчин нөхцөлийг хангасан байдалтай танилцлаа. Тус үйл ажиллагаанд 9 сургуулийн 30 удирдах ажилтан, 80 багш хамрагдлаа.	100%
----	--	--	-------------	------------------	-----------------------------	--	------

							Аймгийн 21 сургуулиас цахим кабинет байгуулсан 13, интернэтийн дотоод сүлжээг сайжруулсан 21 сургууль байна. Цахим системд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх онд 6778 байсан бол 13959 болж 2 дахин нэмэгдсэн байна. Боловсролын ерөнхий газраас хэрэгжүүлж буй сургуулийн менежментийн хөтөлбөрт 8 сургууль, Шинэ Монгол сургуулиас хэрэгжүүлж буй "Сургуулийн менежмент"-ийн хөтөлбөрт 16 сургууль цахимаар хамрагдсан.	
12		2.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийг стандартад нийцсэн орц гарц, ариун цэврийн байгууламжтай болгож, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана.	2021 - 2025	50,0 төгрөг	сая	Сайжруулсан орчин нөхцөлийн гүйцэтгэлийн хувь ХБХ-ийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах, спортоор дамжуулан хөгжүүлэх, авьяас чадварыг зорилгоор Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн захирал, эрхлэгч биеийн тамирын багш, нийгмийн ажилтан, эмч, эцэг эх, асран хамгаалагч нарт “Family health forum” сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад эцэг эх, асран хамгаалагч, боловсролын байгууллагын 65 төлөөлөл, 17 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд оролцсон бөгөөд тус сургалтын үеэр Монголын Тусгай Олимпын хорооноос хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамруулах, спортын тэмцээн уралдаан, арга хэмжээг хамтран зохион байгуулах оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн хүүхдүүдтэй хамт спортоор хичээллүүлэх, тэдний дэмжин тоглогчийг бэлтгэх, талаар Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуультай “Хамтарсан сургууль”-ийн санамж бичиг байгуулан тусгай олимпын төрөл болох шалны хоккей, боче зэрэг спортоор хичээллэх сонирхолтой хүүхдийг бүртгэсэн. Эдгээр хүүхэдтэй ажиллах багшийг 6 дугаар сард Тусгай олимпийн хороонд бэлтгэсэн бөгөөд 4 хүүхдийг бочегийн сургалтад хамруулж байна.	100%

						Сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдах хувь суурь түвшнээс 6 хувиар ахиж 76 хувьд хүрсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээт хөтөлбөрийн хичээлийн танхимыг байгуулж, сургалтыг мэргэжлийн 2 багш хичээллүүлж, системд бүртгэлтэй 24 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас танхимаар 16 хүүхэд суралцаж байна. Энэ нь өмнөх оноос бүртгэл 4 хүүхдээр, танхимаар суралцагч 2 хүүхдээр нэмэгдсэн. Аймгийн хэмжээнд 288 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 172 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж, ЕБС-д 100, СӨБ-д 44, насан туршийн суралцахуйн төвд 16, эрүүлжин хөгжих төвд хамрагдаж байгаа 12 хүүхэд нь суралцахад хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна.	
13		2.1.9. Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийг политехникийн коллеж болгох ажлыг эхлүүлж, их, дээд сургуулиудын үйл ажиллагааг дэмжинэ.	2021 - 2025	-	Политехникийн коллежийн тоо Мэргэжлийн тоо	Аймгийн МСҮТ нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 20211003 дугаар бүхий 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/68 дугаар тушаалаар Политехник коллеж болон өргөжсөн. Политехник коллеж нь ХААИС, ҮТИС, Техник технологийн дээд сургуультай хамтран ажиллаж багш, оюутнуудаа суралцуулах гэрээ байгуулсан. Политехникийн коллежийн 39 багшийн 11 багш магистр зэрэгтэй байгаа нь өмнөх оноос 3 хувиар өссөн. Политехникийн коллежид 2024-2025 оны хичээлийн жилд 16 мэргэжлийн чиглэлээр 36 бүлэгт 783 суралцагч суралцаж байна. 2023-2024 оны	100%

					хичээлийн жилд 277 суралцагч төгссөнөөс 110 төгсөгч мэргэжлээрээ ажиллаж, 69 төгсөгч бусад ажил, 24 төгсөгч мэргэжил дээшлүүлэн, 17 төгсөгч хугацаат цэргийн албанд татагдсан байна. Нийт төгсөгчдийн 179 буюу 64.4 хувь нь ажлын байраар хангагдсан. Монгол Солонгосын политехник коллежид зохион байгуулагдсан “Монгол ур чадвар” мэргэжлийн ур чадварын уралдаанд Политехникийн коллежийн авто машин засварчин мэргэжлийн 2 багш, авто машин засварчин мэргэжлийн 5 суралцагчийн хамт амжилттай оролцсон. Политехник коллежийн захирлын нэрэмжит мэргэжлийн ур чадварын уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, тус тэмцээнд автомашины засварчин, гагнуурчин, барилгын цахилгаан, хэвлэл график дизайн, тогооч, бэлэг дурсгалын зүйл урлаач, барилын өрөг угсрагч, барилгын засал чимэглэлийн мэргэжлийн 1-2 курсийн нийт 120 суралцагч хамрагдсан.	
14		2.1.10. Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэж, суралцах орчин бүрдүүлнэ.	2021 2025	- -	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо Аймгийн Засаг даргын 2024 оны А/166 дугаар захирамжаар аймгийн хэмжээний насан туршийн боловсролын нэгжийн багш нарыг чадавхжуулах, гэр бүлийн боловсролын үндэсний сургагч багш бэлтгэх зорилгоор модуль сургалтыг зохион байгуулахад зориулж 7,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, нийт 20 багшийг сургагч багшаар бэлтгэсэн. Гар урлалын 7 төрлөөр 208 иргэн, иргэний боловсролын 5 төрлийн сургалтад 603 иргэн хамрагдсан. Үндэсний бичгийн анхан болон ахисан шатны сургалтыг 7 байгууллагын 115 албан хаагч, 71 иргэнд, цахим бичвэрийн сургалтыг 4 байгууллагын 29 албан хаагч, 8 иргэнд, 22 төрийн байгууллагын 22 архив бичиг хэргийн ажилтныг хамруулж “Босоо бичиг бидний бахархал” цахим хаягаар цахим хичээл, уралдааныг тогтмол зохион байгуулж 38000	100%

						хүнд түгээсэн. "Тунгаамал" үндэсний бичгийн аварга шалгаруулах хамт олны уралдааныг насанд хүрэгчид болон сурагчдад нийт 10 удаа зохион байгуулж, 25 байгууллагын 180 албан хаагч, 11 ЕБС-ийн 180 сурагчдыг оролцуулсан. Мөн Алтанширээ, Даланжаргалан, Өргөн сумын малчин өрхөд хүрч үйлчлэн, санал хүсэлтийг хүлээн авсан. Тойролтоор 160 өрхийн 328 иргэнтэй уулзалт хийж, нийт 25 арга хэмжээг зохион байгуулж, 3357 иргэнд үйлчилсэн. Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх, иргэд олон нийтэд таниулах зорилгоор 25 төрлийн арга хэмжээг танхим болон цахим хэлбэрийн хосолсон аргаар зохион байгуулж, нийт 34584 иргэнд хүрч ажилласан.	
15		2.1.11. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжинэ.	2021 2025	-	2,0 төгрөг сая	Эрдэм шинжилгээний ажлын тоо "Ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтан хутагтын дагнасан судалгаа эрхэлдэг эрдэм шинжилгээний ажилтнууд, судлаачдыг оролцуулсан "Ноён хутагтын өв: өнгөрсөн, одоо, ирээдүй" Олон улсын эрдэм шинжилгээний хурал"-ыг зохион байгуулж, 5 орны 35 эрдэмтэн судлаач оролцсон. Мөн "Адистэд хурсан гайхамшиг" тусгай үзэсгэлэн гаргаж ноён хутагтын музейн 130-аад үзмэр, эд өлгийн зүйлс дэлгэн олны хүртээл болгосон. Аймгийн Засаг даргын 2024 оны А/259 захирамжаар 11,4 сая төгрөгийг шийдвэрлэн, "Зорилгын хүч-5" сургалт, үйл ажиллагааг зорилгын хуудас бөглүүлэх, танхимын сургалт зохион байгуулах, анги хамт олны бүтээлч ажил өрнүүлэх, дэвжээ тэмцээн зэрэг шинэлэг байдлаар зохион байгуулж, 10 сургуулийн элсэлтийн шалгалт өгөх 12-р ангийн 27 бүлгийн 711 суралцагчийг хамруулсан. "Зорилгын-Хүч-5" үйл ажиллагааны хүрээнд 10 судлагдахуунаар мэргэжлийн зэрэгтэй 35 багш удирдан 278 цагийн сургалт хийж, давхардсан тоогоор 3128 суралцагчийг хамрууллаа. Шилдэг	90%

						илтгэл шалгаруулах “Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь” сэдэвт аймгийн багш нарын эрдэм шинжилгээний хурлыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2 үе шаттай зохион байгуулж 24 сургууль, цэцэрлэгийн багш, заах аргын нэгдэл, багш нарын хамтарсан багууд оролцож, СӨБ-ын байгууллага болон ЕБ-ын сургууль тус тус шилдгүүдээ шалгаруулсан. Үүнд: Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургууль, Замын-Үүд сумын 2-р сургууль, Алтанширээ сумын сургуулийн багш нарын жил эрдэм шинжилгээний ажил эхний 3 байрт шалгарсан. Шалгарсан багш нараас улсын шилдэг илтгэл шалгаруулах уралдаанд “Ментор эцэг эхээр дамжуулан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх боломж” сэдэвт илтгэлийг “Дорноговь аймгийн баг” тавьж амжилттай оролцсон.	
16	2.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр эрт илрүүлэгийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	12,8 сая төгрөг	ЭМСС-д хамрагдсан хүний тоо, үзлэгт хамрагдсан хүний Төлөвлөгөө хэрэгжилтийн хувь Идэвхтэй тандалтанд хамрагдсан хүний тоо	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж тайлант онуудад 914 сургалт сурталчилгаанд 26300 хүн хамруулснаар, иргэдийн мэдлэг хандлага, идэвх оролцоо нэмэгдсэн. Тайлант хугацаанд вакцины бүрэн тунгийн хамралтыг 88,2%-д хүргэж, 118,0 сая төгрөгийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж нийлүүлснээр хангалтыг 100%, ЭМБ бүр 1-2 вакциатортай болж хүний нөөцийн хангалтыг 100%-д хүргэсэн. В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд сурталчилснаар 2412 хүнийг хамруулж, 2021-2024 онд тархвар судлалын заалтаар элэгний В вирустэй эхээс төрсөн 51 нярайд В гепатитын иммуноглобулин эмчилгээг хийж, хяналтандаа авснаар хүүхдүүдэд халдвар илрээгүй. Эрт илрүүлэг үзлэгийг тогтмол зохион байгуулснаар 10000 хүн амд ногдох сүрьеэ 4,5 болж, 2020 оны мөн үеэс 3,9 промилоор буурсан байна.	100%

					БЗДХ илрүүлэх үзлэг, шинжилгээнд нийт 6435 хүнийг хамруулж, шинээр 229 БЗДХ-ыг илрүүлснээс жирэмсэн 21 эмэгтэйг хяналтад авч, 100% эрүүлжүүлэв. “Сайн дурын зөвлөгөө шинжилгээний төв”-үүд нийт 970 хүнд үйлчилж, шинжилгээнд 335 хүнийг хамруулж, БЗДХ-ын 111 өвчлөлийг шинээр илрүүлж, 100% эрүүлжүүлжээ. БЗДХ 10000 хүн амд 32.0 болж 2020 оны мөн үеэс 17.4-өөр буурч, нийт халдварт өвчин 10000 хүн амд 99.0 болж 2020 оны мөн үеэс 18.4-өөр нэмэгдсэн нь АЗӨ нэмэгдсэнтэй холбоотой байна “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд иргэдийг идэвхтэй амьдралын хэв маягт хэвшүүлж эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 12821 удаагийн аян, өдөрлөг, уралдаан тэмцээн, сургалт, сурталчилгааг зохион байгуулж, давхардсан тоогоор 204 байгууллагын 136124 албан хаагчид, иргэд хамрагдаж, 1989 төрлийн 94221 зөвлөмж тараан, цахимд 16987 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулж, 227541 хандалт авснаар иргэдийн ЭМБ дээшилсэн. Арга хэмжээний хүрээнд жил бүр аймгийн аварга шалгаруулах “Ажлын байрны дасгал”, “Хийн дасгал”, “Эмч спорт”, “Флаш моб”, “Цахим алхалт” зэрэг тэмцээнийг зохион байгуулж сүүлийн 4 жилийн хугацаанд нийт 171 багийн 2425 тамирчин оролцсон нь жил бүр 8-12 багийн 273 тамирчин нэмэгдсний үр дүнд хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг хүний тоо 13605 болж биеийн жингээ бууруулах, дархлаагаа дэмжих иргэдийн идэвх оролцоо, хандлага нэмэгдсэн. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөө сүүлийн 4 жилийн хугацаанд 92.1% -тай хэрэгжсэн нь жилд дунджаар 2.1%-иар нэмэгдэж, жил ирэх бүр хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн тоо	
--	--	--	--	--	---	--

						нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж байна.	
17		2.2.2. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулан, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжин, орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	Лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	Сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийг биохими, цус, шээсний хагас автомат анализатортай болгох, эмч нарыг дүгнэлт гаргах чадварыг дээшлүүлэх, лабораторийн шинжилгээний нэр төрөл, хүртээмжийг сайжруулах зорилгоор 2021-2024 онуудад нийтдээ 176,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдүүлснээр хангалт 88.8%-д хүрч, 2020 оноос 29.7%-иар нэмэгджээ. 2024 оны байдлаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд лабораторийн хөргөгч, электрон жин, ус нэрэгчээр 100% хангагдаж, гематологийн анализатор 2020 онд 0% байснаас 2024 онд 69.2 буюу 9 сум аппаратаар хангадаж сум орон нутагтаа оношлуулж эмчлүүлэх боломжийг бүрдүүлжээ. Лабораторийн эмч, мэргэжилтнүүдэд "ISO 15189:2015 стандарт, магадлан итгэмжлэл, лабораторийн өнөөгийн байдал" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 45 лаборант нарыг хамруулан, чадавхжуулж, гадаад, дотоод хяналтад 61,5% нь хамрагджээ. Нэгдсэн эмнэлгүүд мэргэшсэн тусламж үйлчилгээний багцын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломж нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч 2024 онд орон нутаг, хандив тусламж, салбарын хөрөнгө оруулалтаар Замын-Үүд Нэгдсэн эмнэлэгт эмгэг судлал, цусны салбар төвийн ТТ болон бусад шаардлагатай нийт 38 төрлийн 722,1 сая, аймгийн нэгдсэн эмнэлэг 13 төрлийн 70.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. 2020-2024 онуудад орон нутаг, хандив тусламж, салбарын хөрөнгө оруулалтаар 4.3 тэрбум төгрөгийн 299 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж	100%

					шинээр нийлүүлснээр тоног төхөөрөмжийн хангалт 86.5% болж 2020 оноос 3.5%-иар нэмэгджээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 546,4 сая төгрөгөөр 9 автомашин Хандив тусламжийн хөрөнгө оруулалтаар 803,5 сая төгрөгөөр 15 автомашин нийт 33 автомашины парк шинэчлэл хийгдэж хангалт лавлагаа шатлалд 90%, анхан шатны ЭМТ- 88% -тайгаар тусламж үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг хангасан. Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж 2020-2024 онд 1,960,4 сая төгрөгийн 325 ширхэг тоног төхөөрөмжөөр нэмэгдсэнээр ТТ хангалт анхан шатлалд 91,6%, лавлагаа шатлалд 98%-д хүрч, 7,6-14.4%-иар нэмэгдүүлэв. ЭМБ-д 100% хүчилтөрөгч өтгөрүүлэгч, монитор, тарианы шахуурга, 69.2% нь дефибрилятортой болсноор амилуулах болон лавшруулсан тусламж үйлчилгээг үзүүлэх чадавх бэлэн байдлыг сайжрууллаа. Эрүүл мэндийн 11 нэр төрлийн тусламж үйлчилгээг орон нутагт нэвтрүүлж, анхан шатлалын эмнэлгүүдийг 100% мобайл технологиор ханган, лабораторийн 18-22 төрлийн шинжилгээг хийдэг болсноор иргэдийн лавлагаа шатлалын эмнэлэг рүү явах урсгал 20 хувиар буурснаас гадна эрүүл мэндийн салбарын гол үзүүлэлт болох хүн амын дундаж наслалт 2020 оноос 0,9-р нэмэгдэж, 72.9 болсон.	
18	2.2.3. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд мэндийн мэдээллийн нэгдсэн бүрдүүлж, оношилгоо, эрүүл сан	2021 - 2025	31,5	Цахим санд байгаа мэдээллийн тоо Мобайл технологи нэвтрүүлсэн АШЭМБ-ын тоо,	Алслагдсан хүн ам, хөдөөгийн малчид иргэд хаана байгаагаас үл хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2019-2022 онд 13 сумд ЭМЯ, ОНХС-ийн 237,2 сая төгрөгийн, 2023 онд ОНХС-ын 43,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мобайл технологийг 3 өрхөд нийлүүлснээр аймгийн хэмжээнд анхан шатны ЭМБ-уудад 100% Мобайл технологи нэвтэрсэн. Мөн ЭМЯ-ны 136,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар анхан	100%

		эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгал, эм зүйн тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ.			шатны эмнэлгүүдэд 100% уушгины багтаамжийг тодорхойлох спирометрийн багажаар хангасан. Тайлант хугацаанд мобайл үзлэгт 32116 хүнийг хамруулж, 21312 шинжилгээ хийж, 3619 өвчлөл шинээр илрүүлж, дээд шатлалд 1182 хүн илгээж, 3145 хүний эмчилгээний асуудлыг шийдэж, 12 хавдар эрт шатанд нь илрүүлж, зүрх судасны эмгэгтэй 165 хүнийг зайн оношилгооны дамжуулалтаар оношилж, 312 хүнийг арьсны төвтэй холбогдож, эмчилгээг заалгаснаар хөдөөгийн малчид жилдээ нэг удаа оношилгоо шинжилгээг орон нутагтаа хийлгэх боломж бүрдсэн. Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд үйл ажиллагааны хүрээнд салбарын мэдээллийн хүртээмж нэмэгдэн, ил тод байдлыг хангаж мэдээллийн цахим сан үүсгэн хадгалж байна. Үүнд: Hinfo V3.0 статистик мэдээллийн программыг хэрэглэж төр хувийн хэвшлийн 55 байгууллага давхардсан тоогоор 444621, лавлагаа шатлалын 2 нэгдсэн эмнэлэг "E-Health" программд 419507, анхан болон лавлагаа шатлалын 19 ЭМБ дархлаажуулалтын цахим мэдээллийн санд өссөн дүнгээр 6781 хүүхдийн мэдээллүүдийг тус тус бүртгэсэн байна. Аймгийн хэмжээнд цахим 3 санд давхардсан тоогоор 913734 хүний мэдээлэл бүртгэгдсэн ба цаашид цахимжилтыг сайжруулан боловсронгуй болгож, мэдээлэл солилцох, хөрвүүлэлт алдаагүй байх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 11-р тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн сангийн тоог 39 болгож өмнөх оноос 3-аар нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 151 ерөнхий нэршлийн, 651 эмийн жагсаалтын дагуу www.Health.gov.mn программаар
--	--	---	--	--	---

						төрийн өмчийн 19 эрүүл мэндийн байгууллагын 218 эмч хөнгөлөлттэй эм бичих эрхийн дагуу 41731 иргэнд цахим жор бичиж, эрх бүхий 39 эмийн сан 1.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн. 2024 оны 10 дугаар сарын байдлаар тусламж үйлчилгээ авсан хүний тоо 8362 иргэнээр, санхүүжилт 500.4 сая төгрөг буюу 64.8%-иар тус тус нэмэгдсэн. Мөн 2024 онд 12 эмчид цахим жор бичих эрхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар руу саналыг хүргүүлснээр, хөнгөлөлттэй жор бичих эмчийн тоо нэмэгдсэн.	
19		2.2.4. Эрүүл мэндийн ажилтны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, өндөр хөгжилтэй улс орон болон дотоодын сургалтад хамруулж тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжоор хангана.	2021 - 2025	-	Сургалтад хамрагдсан хүний тоо Хүний нөөцийн хангалтын хувь	Эрүүл мэндийн салбарын “Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийг 4 зорилт 17 заалтаар 92.7 хувьтай хэрэгжүүлж 2020 оноос 0,8%-иар өсжээ. Үүнд: орон нутгийн удирдлагуудтай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулж, анхан шатны ЭМБ-ын 45 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд төрийн албан хаагчийн орон сууцанд түрээсийн төлбөргүй амьдрах боломж бүрдсэн нь 2020 оноос 21-ээр нэмэгджээ. АЗДТГ-аас “Хөдөөгийн сэргэлт” “Төрийн албан хаагчийг орон сууцжуулах” зэрэг хөтөлбөрөөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт шилжин ирсэн 8 эмч, ажилтныг орон сууцжуулж, анхан шатны ЭМБ-ын 15 эмч мэргэжилтнийг байрны түрээсээс чөлөөлж, түрээслээд өмчлөх 14 квотыг эмч, сувилагч, туслах ажилтнуудыг хамруулан тус бүр 2 өрөө байр олгож, 1 эмчид байрны урьдчилгаа болгон 19 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Замын-үүд сумын нэгдсэн эмнэлэг 18 айлын орон сууцыг шинэчлэн засварлаж албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулав. Гэр бүлээрээ ажиллаж байгаа эмчийг малжуулах, өвлийн идшээр хангах, газар олгох, сургалтын төлбөрөөс чөлөөлөх зэрэг нийгмийн	100%

					хамгааллыг үзүүлж, гэрээгээр 5 суманд ажиллах 8 эмч мэргэжилтэнд тус бүр 3-5 сая төгрөгний мөнгөн тэтгэмж, сургалтын төлбөр олгон нийт 65,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан нь 2020 онтой харьцуулбал 2 дахин нэмэгджээ. “Ээлтэй Замын-үүд” хөтөлбөрийн хүрээнд Нэгдсэн эмнэлэг, өрхийн ЭМТ-ийн нийт 150 ажилтанд сар бүр 100,0 төгрөг, Өргөн сум 100,0 төгрөгийг 5 сувилагчид, Мишээлт-Мана ӨЭМТ үндсэн цалингийн 20%-иар 7 сувилагчийг 1 удаа урамшуулах зэргээр нийгмийн хамгааллыг дэмжин ажиллав. Төрийн дээд одон медаль, салбар, бусад шагналаар 2021-2024 онд нийт 213 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг шагнаж урамшуулсан нь 2020 оноос 175-р нэмэгдэв.Үүнд: УИХ гишүүд 790 хүнд 79,0 сая төгрөг, ЭМС-ын тушаалаар цар тахлын үеийн урамшуулал 960,9 сая төгрөг, ЭМ-ийн тухай хуулиар 492 эмч эмнэлгийн мэргэжилтэнд 3097,8 сая төгрөг, улирлын үр дүнгийн урамшуулал 3552 хүнд 2197,1 сая төгрөг олгосон нь 2020 онтой харьцуулахад 1,7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг 95,2%-тай хэрэгжүүлж 2021-2024 онуудад эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 90, танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 8864, ЭМБ-ын дотоодын сургалтад давхардсан тоогоор 7343 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлэв. Аймгийн хэмжээнд 2021-2024 онуудад нийт 37 эмч эмнэлгийн мэргэжилтэнг хөрш зэргэлдээ, өндөр хөгжилтэй гадаадын улс оронд суралцуулж,	
--	--	--	--	--	---	--

						суралцсан эмч мэргэжилтнүүд 2020 оноос 37 хүнээр нэмэгдүүлсэн.	
20		2.2.5. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	2021 - 2025	2665.9 сая 522,4 сая 45.4 сая 173.6 сая	Гүйцэтгэлийн хувь	Эрүүл мэндийн салбарт улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 эмнэлэг шинээр ашиглалтад оруулж, 9 эрүүл мэндийн төвд их засвар, өргөтгөл хийлээ. 2023-2024 онд 7 эмнэлэг, 8 эмийн санд шинээр тусгай зөвшөөрөл олгож, эрүүл мэндийн байгууллагын тоог 12.9%-иар нэмэгдүүлсэн. Төмөр замын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг ойртуулах, нэгдсэн эмнэлгийн төв хэсгийн төвлөрлийг бууруулах зорилгоор 2024 онд “Нэгдсэн эмнэлгийн салбар амбулатори-2” – ийг Сайншанд сумын төмөр замын хэсэгт нээж, ачаалал ихтэй шүд, мэдрэл, хүүхдийн кабинетуудыг ажиллуулсан. "Дэээрэт" ОУ-ын Энэрлийн байгууллагын 136 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр"Эрэгтэйчүүдийн кабинет"-ийг шинээр нээн, тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлсэн нь иргэдийн хүлээгдэл чирэгдлийг 16,9%-иар бууруулж он нутгийн төсвийн 1,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Ханги хилийн боомтод эмнэлгийн 5 ортой барилга шинээр барьж, 2024 оноос үйл ажиллагааг эхлүүлснээр хилийн боомтын албан хаагч, аж ахуй нэгжийн ажилчид, бүс нутгийн малчин иргэд, хөдөлгөөнт хүн ам зэрэг нийт 1000 гаруй хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх боломж бүрдсэн. Тайлант онд ЗҮНЭ-т ОНХС-ийн 250,0 сая төгрөгөөр “Цусны төв”, улсын төсвийн 500,0 сая төгрөгөөр “Эмгэг судлалын төв”-ийг байгуулж, АНЭ-ийн хавдрын тасагт моно, полихими эмчилгээ, хэвлийн диализ эмчилгээг нэвтрүүлж, нэгдсэн эмнэлгүүдэд молекул биологийн лаборатори	100%

						байгуулснаар лавлагаа шатлалын тусламжийн чанарт ахиц гарсан. Мөн анхан шатлалд 100% мобайл технологи нэвтэрч, 76,9% нь цус, шээс, биохмийн анализаторийн аппараттай болж анхан шатлалын оношилгооны чадавх сайжирснаар хөдөөгийн иргэд орон нутагтаа шинжилгээ, оношилгоонд орж, дээд шатлалруу урсах урсгал буурлаа. Хувийн хэвшлийн клиник эмнэлгүүдийн тоо 12,9%-иар нэмэгдэж, орон нутагт хийгддэггүй оношилгоо, шинжилгээ эмчилгээг хийдэг болсноор иргэдийн УБ хот руу явах чирэгдэл буурсан.	
21	2.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	2.3.1. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлнэ.	2021 - 2025	-	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь Гүйцэтгэлийн хувь Эцэг эхийн зөвлөлтэй байгууллагын тоо	Аймгийн хэмжээнд 91 эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаа явуулж, хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Гэр бүлдээ бичих захидал” арга хэмжээ, “Гэр бүлдээ зарцуулах цаг хугацаа үнэ цэнэ”, “Хүүхдийн эрх үүрэг”, “Давсаа хасъя” зэрэг сургалт нөлөөллийн арга хэмжээнд 807 иргэнийг хамруулсан. Сайншанд сумын 32 төрийн байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн 66 гишүүдийг оролцуулан Өсвөр насны охид, хөвгүүдэд тулгарч буй асуудал, цахим орчны зөв зохистой хэрэглээ, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үүргийн талаарх мэдээллээр хангах, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх зорилгоор уулзалт арга хэмжээ зохион байгуулсан. Энэхүү ажлын үр дүнд өсвөр насны хүүхдийн онцлог, тулгамдаж буй асуудлын талаар байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл нэгдсэн ойлголттой болсон. Сумд, агентлагууд хүүхдийнх нь төрсөн өдрөөр нэг өдрийн цалинтай чөлөө олгож хэвшсэн ба 0-3 насны хүүхэдтэй ажилтан, албан хаагчдыг богиносгосон цагаар ажиллуулсан. Тайлант онд 4	90%

					эцэг эхийн зөвлөл бүрэлдэхүүнээ шинэчлэн байгуулж, 2 эцэг эхийн зөвлөл шинээр байгуулагдсан. Нийт 91 эцэг, эхийн зөвлөл үйл ажиллагаагаа эрхлэн явуулж, 28 төрлийн арга хэмжээ зохион байгуулсан. 2020 оноос хойш эцэг, эхийн зөвлөлийн тоо 26.4 хувиар өссөн. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд тус байгууллагын хяналтад 3 зорилтын 20 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Тус хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгаалал чиглэлээр зохион байгуулагдсан Монгол Улсын төрийн шагналт, ардын жүжигчин, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит “Өсвөрийн бүжигчдийн улсын XVI” наадам, Яргуй урлагийн наадам, Дорноговь робот-2023, “Шинэ эхлэл” хүүхдийн спортын лигийн тэмцээн, Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг нөлөөллийн арга хэмжээ, Жаргалан хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, Хүүхдийн ордны дотоод засвар, үйлчилгээ зэрэг 40 гаруй үйл ажиллагаанд 1,170,5 сая төгрөгийн төсөв санхүүг шийдвэрлэн санхүүжүүлсэн. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/647 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд “Хайр хязгааргүй-ялгаагүй” нөлөөллийн аяны хүрээнд 30 удаагийн сургалтад 13000 орчим иргэдийг хамруулан, Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр 11 төрлийн зөвлөмжийг 14 сум, 35 байгууллагын цахим, орон нутгийн 2 телевиз,	
--	--	--	--	--	--	--

						2 сайтад 4 удаагийн ярилцлагаар иргэд олон нийтэд хүргэсэн.	
22		2.3.2. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах болон гэр бүлийн орчин нөхцөлийг сайжруулна.	2021 2025	- -	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	"Олон улсын гэр бүлийн өдөр", "Олон улсын охидын өдөр", "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр", "Олон улсын аавуудын өдөр", "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" зэрэг тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд "Нэгдүгээрт хүүхэд", "Гэр бүлийн дундах эерэг харилцааг нэмэгдүүлэх", "Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхийн ач тус", "Өсвөр насны хүүхдийн төлөвшил" зэрэг 56 үйл ажиллагаа, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хосуудын харилцан ойлголцол, бат бэх байдлыг дэмжих, амьдрах ухаан, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлүүдээр төрийн байгууллагын албан хаагч болон иргэд рүү чиглэсэн 100 гаруй удаагийн сургалт зохион байгуулсан. Нийтдээ 150 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаа, сургалтыг зохион байгуулсан. Гэр бүлийн орчин нөхцөлийн судалгааг Сайншанд сумын 8 багийн эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, хагас, бүтэн өнчин хүүхэдтэй нийт 150 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг хийсэн. Уг үнэлгээгээр цахилгааны аюулгүй байдал, хүнс тэжээлийн нөөц, галын аюулгүй байдал бохирын нүх зэрэг үнэлгээгээр дүгнэн эрсдэлтэй гарсан нийт 33 өрхөд 3 сая төгрөгийн хүнсний дэмжлэг үзүүлсэн. Мөн 46 удаагийн цуврал хүүхэд хүмүүжлийн эерэг аргын зөвлөмж постер, 6 төрлийн подкаст, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай болон гэр бүлийн тогтвортой байдлын үндэс, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэрэг 15 төрлийн танилцуулгыг бэлтгэн байршуулж, иргэд олон нийтэд тогтмол хүргэсэн. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн хүрээнд хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг, гэр	90%

						бүлийн хүчирхийлэл, “Асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүмүүжлийн эерэг арга, угийн бичиг хөтлөхийн ач тусын талаар Сайншанд сумын 1500 гаруй иргэдэд мэдээлэл өгсөн. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Эрдэнэ сумын Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн, алба хаагч нарт эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг оролцоо, хүүхдийн хөгжил, оролцоо, гэр бүлийн харилцаа, харилцаанд нөлөөлөх хүчин зүйлс зэрэг сэдвээр сургалт мэдээлэл хүргэж албан хаагчид, хугацаат цэргүүдэд бүлгийн ярилцлага хийн, гэр бүлийн хосуудад хосын карт ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн Шүүхийн Тамгын газартай хамтран гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын сэтгэл зүйчийн уулзалтыг зохион байгуулан, 12 гэр бүлийг мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзуулсан. Гэр бүлийн асуудлаар маргаантай 6 өрхөд шинжээчийн дүгнэлтийг гарган Шүүхэд хүргүүлэн ажилласан. Энэ онд гэрлэхийн өмнөх боловсрол олгох зорилгоор шинээр гэр бүлээ батлуулсан 14 хосод гэр бүлийн тухай хууль, жендерийн тэгш байдлын талаар зөвлөгөө өгсөн.	
23		2.3.3. Нийгмийн харилцаан дахь залуучуудын хөгжил оролцоог сайжруулж, бүтээлч санал	2021 - 2025	-	Дэмжсэн саналын тоо	“Ирээдүйн эзэд-2023” аян, “Мэргэжил сонголтоо хийсэн үү?, сургалт, “Хичээлийн жилийн анхны уулзалт” зэрэг 5 удаагийн арга хэмжээ, сургалт зохион байгуулж Сайншанд сумын ЕБС-ийн 10-12 дугаар ангийн нийт 1180 сурагчдыг хамруулж энэ талын мэдээлэл, зөвлөгөө өгч, нөлөөллийн үйл	90%

		санаачилгыг дэмжинэ.			ажиллагаа зохион байгуулсан. “Сайн дурын ажлын сарын аяны хаалт”, “Нэг хамт олон-Нэг сайн дурын ажил” 3 төрөлт уралдаант аяныг зарлаж, 14 сумын өсвөр үе, залуучуудыг хамруулсан. Уг ажлын хүрээнд сайн дурын ажил гэж юу вэ? эшлэлийн уралдаанд 150 хүүхэд, Сайн дурын ажлын action зургийн уралдаан, Reel уралдаанд нийт 43 байгууллага хамт олон оролцож 884 сайн дурын идэвхтэн хамрагдаж 3419 хүнд хүрсэн. Мөн “Зүүн азийн залуучуудын наадам”, “Данзанравжаагийн 220 жилийн ойн баяр наадам”, “Гайхамшигт бямба гараг” мод тарих аялал, “Хамрын хийд-2023” дугуйн уралдаан, “Намайг хамгаал” нөлөөллийн аян зэрэг 10 үйл ажиллагаанд 159 өсвөрийн сайн дурынхан хамрагдсан. Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр “Залуучуудын бодлогын хэлэлцүүлэг”, “Оролцоно төлөөлнө”, “Эмэгтэйчүүдийн манлайлал”, “Охидын өдөр” зэрэг 5 сургалт, “Залуусаа сонсох өдөр”, “Z generation interview”, “Иргэний мэдэх эрхийн сургалт”, “Залуусын дуу хоолой” хэлэлцүүлэг зэрэг 6 арга хэмжээнд нийт 709 өсвөр үе, залуучуудыг хамруулж тэдний дуу хоолой, үзэл бодлыг сонсож орон нутгийн удирдлагуудад хүргүүлж ажилласан. Мөн залуучуудаас гарсан “Залуучуудын хөтөлбөр боловсруулах” санаачилгыг дэмжин хөтөлбөрийн төслийг боловсруулан ажиллаж байна. Нийт 32 сургалт, 30 арга хэмжээнд 8512 өсвөр үе, залуучууд хамрагдсан. Сайншанд сумын ЕБ-ын 5-р сургуулийн ахлах ангийн сурагч Э.Хулангийн 3 аймгийн эко чуулган зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх хүсэлтийн дагуу Тогтвортой хөгжлийн 13 дахь зорилт болох Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах Цаг уурын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх талаар арга хэмжээ авах зорилтын хүрээнд Дорноговь, Төв, Говьсүмбэр
--	--	----------------------	--	--	--

						аймгийн сурагчдын төлөөллүүдийн санаачилгаар байгаль орчин, тогтвортой хөгжлийн мэдлэг мэдээлэл олгох, бүх түвшний шийдвэр гаргах явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн оролцоотойгоор аливаа шийдвэр тогтоолуудыг байгальд ээлтэй байх шаардлагыг хангахад хувь нэмэр оруулах зорилгоор “YOUTH POWER GTD” Байгальд ээлтэй залуусын чуулган зохион байгуулсан.	
24		2.3.4. Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэн хяналт тавьж, хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээг сайжруулна.	2021 2025	-	Зохион байгуулсан хэмжээний Хамрагдсан иргэдийн тоо	арга тоо Хүүхдийн эрхийг дээдлэх, хамгаалах зорилгоор “Хүүхэд эрхэм хэрэглэгч”, “Хүүхдийн эрх, үүрэг, хамгаалал, хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцоо”, “Гэрэлт ирээдүйд бүү гар хүр”, “Намайг хамгаал”, “Хамтдаа шалгая, хамгаалъя”, “Хайр хязгааргүй ялгаагүй”, “Хүүхэд хамгааллын тухай хуулийн танилцуулга”, “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” зэрэг сэдвээр 32 төрлийн видео контент, 45 төрлийн гарын авлага, шторкийг түгээж давхардсан тоогоор 29,560 иргэнд түгээсэн. Сар бүрийн эхний 7 хоногийн 3 дахь өдрийг “Хүүхдээ сонсох” өдөр болгон, сурагчдын санал бодлыг хүлээн авч, хүүхэд хамгааллын асуудал болон сургууль, дотуур байрын орчинд хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт зэрэг 308 үйл ажиллагаанд 63120 хүнийг хамруулан ажилласан. Сэтгэл зүйн боловсролд анхаарах зорилгоор ХГБХХГазрын сэтгэл зүйч Сайншанд сумын түр хамгаалах байранд байрласан нийт 10 хүүхэд, насанд хүрсэн 1 иргэн, сэтгэл зүйн зөвлөгөө авахаар хандсан 14 иргэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 12 хүүхдэд тест, асуулга, проектив тест, ярилцлага хийх, темперамент тодорхойлох, зан үйлийн тодролыг тодорхойлох зэрэг хэлбэрээр ажилласан.	90%

						Алтанширээ сум 38 эцэг эхийг хамруулан “Гэр бүлийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 5 байгууллага хүүхдийн өрөөг шинээр тохижуулсан. ХГБХХГазрын мэргэжилтнүүд болон Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудын зүгээс насанд хүрээгүй 31, насанд хүрсэн 1, 3 гэр бүлд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх, сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээг үзүүлсэн. Сэтгэл зүйчийн зөвлөгөө өгөх өрөөг тохижуулахад шаардагдах 11,2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төслийг хүргүүлж шийдвэрлэсэн. "Намайг хамгаал", "Хайр хязгааргүй ялгаагүй", "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй", "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр" "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ-2024", "Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогч хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах, хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх" чиг үүргийн хүрээнд хууль зүйн хорооны хяналтад 17 хүүхэд авснаас, бэлгийн хүчирхийллийн 2, Үл хайхрах хүчирхийллийн 4, Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 11 хүүхдийн асуудлыг шийдвэрлэж, хариу арга хэмжээг авч, харьяа байгууллагуудад холбон зуучилсан. 2024 онд бэлгийн хүчирхийллийн 1 дуудлага мэдээлэл хүүхдийн тусламжийн 108 утсанд ирснийг бүртгэн, хэргийг шалган шийдвэрлүүлэхээр Цагдаагийн газарт хүргүүлсэн. Насанд хүрээгүй хүүхэд холбогдсон зөрчил шалган шийдвэрлэх 39, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх 9 хэргийн нийт 48 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, эрх ашгийг хамгаалан ажилласнаар өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийн тоо 22 хувиар буурсан үзүүлэлттэй байна.		
25		2.4.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн	2021 2025	-	-	Төлөвлөгөөний хэрэгжилт	“Хүнсний аюулгүй байдал” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж, 14 сумын хүнсний худалдааны 65 объект, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 34, ЕБС-	70%

	2.4. Эрүүл баталгаат орчныг бий болгоно.	үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлэн, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.				ийн хоол үйлдвэрлэлийн 41, үйлдвэрийн 14 нийт 154 объектыг төлөвлөгөөт бус шалгалтад хамруулж, 16 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулан 521 иргэн, ААН-ийн төлөөллийг оролцуулан мэдээлэл өгч, 8 төрлийн зөвлөмж боршур тараасан. Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн салбарын хууль тогтоомжийг худалдаа, үйчилгээ эрхлэгчдэд таниулах зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран 27 удаагийн сургалт сурталчилгааг зохион байгуулан давхардсан тоогоор 1125 худалдаа үйлчилгээ эрхлэгч, 148 эцэг эхийн төлөөлөл, ЕБС-ийн 975 суралцагчийг хамрууллаа. Хяналт шалгалтын явцад 36 зөвлөмж, 24 гарын авлага, сэрэмжлүүлэг, 45 постер, 2 шторкыг байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулсан. Мэргэжлийн байгууллагаас гаргасан хоол, хүнсний зохистой, соёлтой хэрэглээний талаар боршур, шторкыг байгууллагын цахим хуудас, орон нутгийн олон нийтийн сүлжээгээр ард иргэдэд сурталчлан таниулсан. Мөн аймгийн ЗДТГ, “Эрхэт төгс эрдэм” ТББ-тай хамтран 14 суманд үйл ажиллагаа явуулдаг хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, буудлын үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 220 гаруй ААН, иргэний төлөөллийг хамруулан “Зочлох үйлчилгээний стандарт”, “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээ” сэдэвт сургалтыг 2023, 2024 онд тус тус зохион байгуулсан. Салбарын ерөнхий байцаагчдын баталсан 25 удирдамжийн хүрээнд давхардсан тоогоор нийт 1182 объект /585 аж ахуй нэгж, 597 иргэн/-ийн хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 3790 зөрчил дутагдлыг илрүүлж 1712 буюу 45,17%-ыг арилгуулан, зөрчил ихээр илэрсэн	
--	---	--	--	--	--	--	--

						102 иргэн, аж ахуй нэгжид илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1067 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага 103-г хүргүүлж албан шаардлагын биелэлт 39,1%, 56 иргэн, аж ахуй нэгжид 589 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмж 56-ийг хүргүүлж, чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүн худалдсан, холбогдох хууль, дүрэм, журам, стандарт мөрдөөгүй 16 аж ахуй нэгжид 47,5 сая, 30 иргэнд 13,0 сая нийт 46 иргэн, аж ахуй нэгжид 59 сая 800 мянган төгрөгийн торгууль шийтгэл ноогдуулж, чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй, хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн болон гарал үүсэл тодорхойгүй Хятад хэл дээр бичигдсэн шошготой 527 нэр төрлийн 6820 ширхэг 59,83 кг 14.487.620 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч сумдын Засаг даргын дэргэдэх захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг улсын орлого болгох, устгах орон тооны бус зөвлөлд шилжүүлж устгалд оруулсан.	
26		2.4.2. Хот, суурин газруудад үерийн ус зайлуулах сувагчиллыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Сувагчлалын урт	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388 төслөөр хэрэгжсэн “Дорноговь аймгийн Цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх А1.2.2-2021/84 дугаартай гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу 640.6 сая төгрөгийн санхүүжилтээр “Дорноговь аймгийн Сайншанд сумын үерийн хамгаалалтын барилга байгууламж, замын ус зайлуулах шугамын ажил”-ыг 2022 онд “Компорт импекс” ХХК гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд Сайншанд сумын 1, 6-р багийн нутаг дэвсгэрт 520 м урттай борооны ус зайлуулах шугам хоолой, 380 м урттай үерийн хамгаалалтын суваг хийгдсэн. Тайлант хугацаанд Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр төв цэнгэлдэх хүрээлэн орчимд	90%

						1.3 км шуудуу, 150 м үерийн усны авто замын суваг, авто замын доорх ус зайлуулах хоолойг байгуулах ажлыг орон нутагт барилга бүтээн байгуулалт хийж буй аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хамтран гүйцэтгэсэн. 2024 онд орон нутгийн төсвийн 101.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Асрамжийн газрын үерийн усны далан хийх ажлыг "Сутайн жинст" ХХК гүйцэтгэж 7-р сард ашиглалтад оруулсан. Сайншанд сумын хэмжээнд үерийн ус зайлуулах инженерийн байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 299.9 сая төгрөгийн өртгөөр "Гидродизайн инноваци" ХХК гүйцэтгэж байна. Дэвсгэр зураг боловсруулах, суурь судалгааны ажил хийгдэж байна. Орон нутгийн үерийн усны далан, шуудуу, сувагчлалыг 2020 онтой харьцуулахад 2550 м-ээр нэмэгдүүлсэн.	
27	2.5. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.	2.5.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021 2025	- -	Төлөвлөгөөний хэрэгжилт	Аймгийн ХАБЭА-н зөвлөл ХАБЭА сарын аяны хүрээнд АҮЭХ, АОЭХ-той хамтран аж ахуй нэгж байгууллагын дарга, ХАБЭА-н ажилтнууд, төрийн албан хаагчид, агентлагийн удирдлагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөрийн тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор 6 удаагийн сургалтыг зохион байгуулж 306 төрийн албан хаагч, 121 аж ахуй нэгж байгууллагын 935 ажилтныг чадавхжуулсан. Мөн сарын аяны хүрээнд орон нутгийн төсвийн 2.4 төгрөгийг төсөвлөн МҮЭХ-ны сургагч багш урьж орон нутагт барилгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 28 ААНБ-ын төлөөллүүд, 73 төрийн албан хаагчийг хамруулан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Аймгийн ХАБЭА-н зөвлөл 2021-2024 онуудад "Хөдөлмөрийн харилцаанд хамтын гэрээ,	90%

						хэлэлцээрийн гүйцэтгэх үүрэг, хэрэгжилт, Хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт”, “ХАБЭА-н удирдлагын тогтолцоо, MNS ISO 45001:2018 стандартын талаарх ойлголт, чадамжийг гүнзгийрүүлэх, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад тус стандартыг нэвтрүүлж эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, “ХАБЭА-н тухай хууль, салбар зөвлөлийн чиг үүрэг, тулгарч буй асуудал” зэрэг нийт 100 гаруй сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж давхардсан тоогоор 8000 гаруй хүнийг хамруулсан.	
28		2.5.2. Орон нутгийн бүтээн байгуулалттай уялдуулан эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Зуучлагдсан ажлын байрны тоо Шинэ ажлын байрны тоо	Хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн систем ejob платформд орон нутгийн хэмжээнд шинээр бий болсон 951 шинэ ажлын байрыг бүртгэсэн бөгөөд байнгын 647, улирлын 75, түр 229 бүртгэлтэй байгаагаас тайлант хугацаанд шинээр бий болсон ажлын байранд 328 иргэн ажилд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс бий болсон ажлыг байрны бүртгэл 25.3%, зуучлагдсан иргэдийн тоо 169-өөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн хувийн бирж байгуулан ажиллах хүсэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласнаар “Хутагт мөрөн” ХХК-ийн дэргэдэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн агент нь 2024 оны 03 сараас “Залуучуудын хөдөлмөр зуучлалын төв” хөдөлмөрийн хувийн бирж байгуулан үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр ажил хайгчаар 200 иргэнийг бүртгэж, 33 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 1 иргэнийг зуучлан ажилласан байна. Ажилгүйдлийн түвшин 2023 оны эцэст 3,6 болж 2020 оноос 0,5 функтээр буурсан ба 2024 оны хагас жилийн байдлаар ажилгүйдлийн түвшин улсын дундажаас 1.8 функтээр доогуур, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 8.0 функтээр дээгүүр гэсэн үзүүлэлттэй байна.	90%

						Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд мэргэжил олгох сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн саналыг docs.google.com ашиглан цахим хэлбэрээр авч нийт 8 төрлийн мэргэжлээр 316 иргэн хамрагдах хүсэлт гаргасан. Тайлант хугацаанд “Баян нэгүл” ХХК-ийн дэргэдэх сургалтын төв, “Дарь овооны эзэд” ТББ-ын дэргэдэх сургалтын байгууллагаар дамжуулан хамгийн олон иргэн бүртгүүлсэн буюу иргэдийн хэрэгцээ шаардлага ихтэй “Нярав”, “Оёдол” мэргэжлээр ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй 42 иргэн, эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны сургалтыг “Сонор” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж "Бичиг хэрэг-Архив" мэргэжлээр, ажилгүй, ажил хайж буй 20 иргэнийг тус тус хамруулан чадавхжуулсан бөгөөд 11 иргэн ажлын байранд зуучлагдаж, 4 иргэн оёдлын чиглэлээр, 1 иргэн бусад чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхэлж байна.	
29		2.5.3. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн нэгдсэн сантай болно.	2021 - 2025	-	Мэдээллийн сангийн тоо	Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “ЕJOB” платформыг 2023 оны 01 сарын 01-нээс нэвтрүүлж хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн нэгдсэн санг бий болгон ажиллаж байна. Тус платформыг танилцуулах, ашиглалтыг сайжруулах зорилгоор "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулагдсан Цахимд хэвшье уриатай #Digital_First_D1 арга хэмжээнд, Хөгжлийн Шийдэл ТББ-н хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрөөс зохион байгуулсан ЭНТРЕПРЕНЕР ЭМЭГТЭЙЧҮҮД IV ФОРУМ-д оролцогч 100 гаруй эмэгтэйчүүдэд танилцуулахаас гадна тус системд бүртгүүлэх зааварчилгааг бэлтгэн байгууллагын цахим хаягт	90%

						байршуулж, ажил хайгч иргэд, ажил олгогч байгууллагуудад 2 төрлийн гарын авлагыг түгээн мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байна. 2024 оны 3-р улирлын байдлаар өдрийн байдлаар Ejob цахим системд 1343 ажлын байрны захиалга, 951 шинээр бий болсон ажлын байр, 760 ажил хайгч шинээр бүртгэгдсэнээс 718 иргэн ажлын байранд зуучлагдсан. Цахим системд бүртгэгдсэн мэдээллийн тоо 3772 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 826 -аар нэмэгдсэн бөгөөд шинэ ажлын байр 5-аар, ажилд зуучлагдсан иргэдийн тоо 11 иргэнээр нэмэгдсэн байна.				
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА										
30	3.1. Нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлж, нийгмийн халамжийг оновчтой болгоно.	3.1.1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж ил тод болгон, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөнө.	2021-2025	-	Төлөвлөгөөний хэрэгжилт	Жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор нийгмийн даатгалын сангийн ирэх оны төсөв, дараа онуудын төсөөллийг боловсруулж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж ажилласан. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг тайлант онуудад бүрэн биелүүлж ажилласан.	100%			
						Он		Төлөвлөгөө ө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Гүйцэтгэлийн хувь
						2021		37812140,59	44240204.5	117,1
						2022		48240623,2	48260896,8	100,04
						2023		64453811.2	63739376.0	99,19
						2024.09		56770452,3	58719220,46	103,4
						Он		Төлөвлөгөө ө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Гүйцэтгэлийн хувь

						<table><tr><td>2021</td><td>50940147,8</td><td>54862101,3</td><td>107,7</td></tr><tr><td>2022</td><td>70364017,9</td><td>69608221,2</td><td>98,7</td></tr><tr><td>2023</td><td>87719329.7</td><td>83894076.6</td><td>95,6</td></tr><tr><td>2024.09</td><td>82745275,3</td><td>83183293,2</td><td>100,5</td></tr><tr><td></td><td></td><td></td><td></td></tr></table> 2021 онд 711 ажил олгогчийн 19567 албан журмын даатгуулагч хамруулж, 3608 сайн дурын даатгуулагч хамруулсан. 2022 онд 757 ажил олгогчийн 20529 албан журмын даатгуулагч хамруулж, 3593 сайн дурын даатгуулагч хамруулсан бол 2023 онд 837 ажил олгогчийн 22355 албан журмын даатгуулагч хамруулж, 3276 сайн дурын даатгуулагч хамруулсан байна. 2024 онд 876 ажил олгогчийг хамруулсан нь өмнөх оноос 4,6 хувиар, 2021 оноос 18,5-аар нэмэгдсэн байна. 2024 онд 3985 сайн дурын даатгуулагч хамруулсан нь өмнөх оноос 21,6 хувиар, 2021 оноос 10,4 хувиар нэмэгдсэн.	2021	50940147,8	54862101,3	107,7	2022	70364017,9	69608221,2	98,7	2023	87719329.7	83894076.6	95,6	2024.09	82745275,3	83183293,2	100,5					
2021	50940147,8	54862101,3	107,7																								
2022	70364017,9	69608221,2	98,7																								
2023	87719329.7	83894076.6	95,6																								
2024.09	82745275,3	83183293,2	100,5																								
31		3.1.2. “Цахим нийгмийн даатгал” арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын үйл ажиллагааг үе шаттайгаар бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно.	2021 2025	-	-	үйлчилгээний тоо	2024 онд -ITZONE ХХК 2019-2023 онд хөгжүүлсэн НД-ын мэдээллийн шинэ системийг 2024 оны 1 дүгээр сараас эхлэн үе шаттайгаар нэвтрүүлж, цахим үйлчилгээний www.portal.ndaatgal.mn хаягаар орж үйлчилгээг авах боломжтой болсон. www.portal.ndaatgal.mn –ээр нийгмийн даатгалын тэтгэмжийн хүсэлт, ажил олгогчийн тайлан илгээх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт авах, сайн дурын даатгалд даатгуулах зэрэг үйлчилгээг авах бөгөөд цахим үйлчилгээний тухай 45 удаагийн мэдээллээр 3419 иргэнд хүргэж ажилласнаар 2024 оны 3-р улирлын байдлаар ажилгүйдлийн тэтгэмжийн 428 хүсэлт, хөдөлмөрийн	100%																			

					чадвар алдалтын эмнэлгийн хуудас 2429, жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудас 1074 хүсэлт, ажил олгогчийн тодорхойлолт, цахим нийгмийн даатгалын тайлан 876 цахимаар хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 2022 онд 2878 иргэн, 2023 онд 3902 иргэн, 2024 оны 9 сарын байдлаар 4807 иргэн, хуулийн этгээдэд цахим үйлчилгээг хүргэсэн. Нийгмийн даатгалын 34 үйлчилгээнээс 26 үйлчилгээг цахимжуулж 8,3 хувиар өссөн. Мөн e-mongolia цахим системд 12 үйлчилгээг холбож, 1276 цахим лавлагаа, дэвтрийг олгож, 4441 цахимаар ирсэн тэтгэмж авах өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, олголтыг хийж ажиллалаа. Энэ нь өмнөх онд цахим лавлагаа 1321, тэтгэмж авах өргөдөл 692 ирсэнтэй харьцуулбал 184 хувийн өсөлттэй болж, иргэдийн төрийн цахим үйлчилгээний хэрэглээ нэмэгдсэн.	
32	3.1.3. Нийгмийн халамжийн болон нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ил тод чирэгдэлгүй болгоно.	2021 - 2025	670,0	Гүйцэтгэлээр	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/04 тоот тушаалаар Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны маягт аргачлал шинэчлэгдэн батлагдаж аймгийн 478 өрхөөс судалгаа авах жагсаалт гарч, өрхийг 100 хувь хамруулж, өрхийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулсан. Уг судалгааны урьдчилсан дүнд үндэслэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/97 тоот тушаалаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, иргэнийг тодорхойлох босго оноог 401,2 болон түүнээс доош оноогоор тогтоосон. Нийгмийн халамжийн үйлчилгээ нь 2020 оноос эхлэн үе шаттайгаар цахим системд шилжсэн бөгөөд 2024 оны 3-р улирлын байдлаар нийгмийн	90%

						халамжийн 64 нэр төрлийн үйлчилгээний хүсэлтийг цахим системээр, 11 үйлчилгээг emongolia аппликейшнээр хүлээн нийт үйлчилгээний 91,6 хувийг цахимжуулсан бөгөөд үйлчилгээнд хамрагдахаар 9979 иргэн хүсэлт гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 26574 хүүхдэд 26,605.9 сая төгрөг, бусад тэтгэвэр тэтгэмжид давхардсан тоогоор 25084 иргэнд 13,231.7 сая төгрөг улсын төсвөөс, 44 иргэнд 56,4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус олгосон нь өмнөх оны мөн үеэс тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо 1775-аар, зарцуулсан мөнгөн дүн 1,937.1 сая төгрөгөөр emongolia аппликейшнд шилжүүлсэн үйлчилгээний тоо 7-оор нэмэгдсэн байна. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны мэдээллийн санд бүртгэлтэй, доод түвшинд эрэмбэлэгдсэн 1429 өрхөөс 135 өрхийн 281 том хүн, 332 хүүхдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд нийгмийн халамжийн сангаас 71,5 сая төгрөгийг олгосон нь өмнө оны мөн үеэс үйлчилгээ авч байгаа өрх 7.5%, иргэний тоо 7.9%-иар тус тус буурсан байна.	
33	3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлогын хэрэгжилтийг хангана.	3.2.1. Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн, стандартын шаардлага хангасан орон сууцны төсөл хэрэгжүүлэх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.	2021 - 2025	ОНХС-222.3 сая.төг ОНТ-192.0 сая. төг	Ашиглалтад орсон орон сууц, айлын тоо	Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлогын хүрээнд Сайншанд сумын 7-р багт "Мандах наран-5" хорооллын 1152 айлын орон сууц барих төслийг "Гантулга трейд" ХХК хэрэгжүүлж, нийт 384 айлын 6 блок орон сууцны барилгыг барьж 2024 оны 1-р улиралд бүрэн ашиглалтад оруулсан. Төслийн 2-р ээлжийн 288 айл /72 айл*4 блок/-ын 9 давхар орон сууцны барилгын газар, шороо суурийн ажил хийгдсэн. Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт "Мандах наран-6" хорооллын 576 айлын 9 давхар 8 блок барилга барихаар төлөвлөлт хийгдэж, 2024 оны 10-р сарын байдлаар	90%

						288 айлын 4 блок барилгын ажил 70%-тай үргэлжилж байна. Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд "Энержи парагон" ХХК нь 288 айлын 4 блок орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэж байна. Аймгийн нутаг дэвсгэрт 2021-2024 онд 1006 айлын 33 орон сууцны барилга ашиглалтад орсон. Үүнд: 2021 онд 83 айлын 4 орон сууц, 2022 онд 239 айлын 7 орон сууц баригдаж ашиглалтад орсон. 2023 онд 404 айлын 7, 2024 онд 152 орон сууц ашиглалтад орсон.	
34		3.2.2. Барилгын үндсэн нэр төрлийн материалын орон нутгийн эрдэс, түүхий эдийг ашиглан дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар бага өртөгтэй орон сууцаар хангах бодлогыг дэмжин ажиллана.	2021 - 2025	-	Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ	Орон сууцны төсөл хэрэгжүүлж буй ААН-дэд түгээмэл тархацтай ашигт малтмалыг орон нутгаас хөнгөлөлттэй үнээр олгон ажилласан. Мөн Өргөн, Даланжаргалан сумдад үйл ажиллагаа явуулж буй "Монцемент билдинг материалс" ХХК, "МАК цемент" ХХК-ууд нь орон нутгийн бетон зуурмагийн узель болон барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд ААН-дэд барилгын гол нэр төрлийн материал цементийг тасралтгүй нийлүүлэн ажилласнаар бага өртөгтэй орон сууцны төсөл хэрэгжих боломжийг бүрдүүлсэн.	100%
35		3.2.3. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, стандартын шаардлага	2021 - 2025	-	Сорьцын тоо	Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх Барилгын материалын лабораторийн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, барилгад ашиглаж буй барилгын материалуудын чанарт тавих хяналтыг сайжруулах зорилгоор хатаах шүүгээ, усан ванн, шмидтийн алх зэрэг тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. Тус лаборатори нь 2021-2024 онд 9	90%

		хангасан материалаар барилгын ажлыг гүйцэтгүүлнэ.				нэр төрлийн 3862 ширхэг барилгын материалын дээжид сорилт шинжилгээ хийж гүйцэтгэсэн байна.	
36	3.3. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	3.3.1. Бичил бизнесийг дэмжих орчинг бүрдүүлнэ.	2021 2025	-	-	Хамрагдсан иргэдийн тоо	90%
37		3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг	2021 2025	-	7,3 тэрбум	Гүйцэтгэлийн хувь	90%

		бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.			хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд сэргээн засах, өдөр өнжүүлэх үйлчилгээ үзүүлэх “Эрүүлжин хөгжих төв”-д хүнд хэлбэрийн эмгэгтэй 9 хүүхдийг асаргааны үйлчилгээнд, 6 хүүхдийг бариа заслын үйлчилгээнд тус тус хамруулж байна. 2024 онд төвийн үйл ажиллагаа болон цалингийн зардалд орон нутгийн төсвөөс 125,0 сая төгрөг батлагдсанаас 3 дугаар улирлын байдлаар 84,4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан. Тус төвд хамрагдаж байгаа хүүхдүүдэд өдөр тутам сэргээн засах, бариа заслын үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд үйлчилгээний үр дүнд 5 хүүхдийн бие бялдар, үйл хөдлөл, сэтгэхүйн онцлогт эерэг өөрчлөлт гарч байгаагаас гадна ажил хөдөлмөр эрхлэхгүй байсан 7 асран хамгаалагчаас 4 асран хамгаалагч байнгын ажлын байртай болсон давуу талтай байна. Мөн хөдөө сумдаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн асран хамгаалагчдыг мөн адил боломжоор хангаж байна. Өрөө танхимын хүртээмжээс шалтгаалан өдрийн турш байрлуулан асрах үйлчилгээнд хүүхэд нэмэгдээгүй бөгөөд бариа заслын үйлчилгээнд 6 хүүхдийг нэмж хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд давхардсан тоогоор 81 иргэнийг хамруулсан бөгөөд аж ахуй эрхлэлтийн сургалтад 38 иргэн, 50 хувийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт 16 иргэн, мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд олгох
--	--	---	--	--	--

						танхимын сургалт болон хоол, унааны хөнгөлөлтөд давхардсан тоогоор 24 иргэнд, борлуулалтын дэмжлэг арга хэмжээнд 3 иргэнийг тус тус хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 128,8 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 3 ахмадыг хамруулан 1.9 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Мөн 28 ахмадад 208,8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, олгож нийт 31 ахмадыг байнгын болон түр ажлын байраар хангасан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 51.4%-аар нэмэгдсэн байна.	
38		3.3.3. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 2025	- -	Төсөл хөтөлбөрт хамрагдсан залуучуудын тоо Хөдөлмөр зуучлалын төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвөөр дамжуулан 6 арга хэмжээг зохион байгуулж 754 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: 1.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг 9,12 дугаар ангийн 115 сурагчдад 2. "Таймон Флоуртек" ХХК, Болд төмөр ерөө гол ХХК ажлын ярилцлагад 52 иргэн оролцсоноос 17 иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан. 3. Модуль 1, 2 сургалтад ажил хөдөлмөр эрхэлдэггүй 8 иргэн, 4. Ажилгүйдлийн тодорхойлолт 110 иргэнд, ажлын байрны мэдээллийг 383 иргэнд хүргэсэн 5. Цагийн болон өдрийн ажил хийх сонирхолтой АШУҮИС-ын Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, Политехникийн коллежийн оюутнууд, ажилгүй иргэдийн дэлгэрэнгүй судалгааг гарган мэдээллийн сан үүсгэн ажиллаж байгаа бөгөөд 26 оюутан залуусыг өдрийн ажилд зуучилсан 6. "Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх зохицуулалт, хөдөлмөрийн харилцаа"-ны сургалтыг "ИЙЗИ ОНЛАЙН ЭДҮКЭЙШН" ХХК-ын дэргэдэх сургалтын	90%

						төвтэй хамтран АШУҮИС-ын Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн болон Политехникийн коллежийн 60 төгсөгчийг хамруулан зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын сул орон тооны 40 ажлын байрыг танилцуулав. Загвар төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоог 2023 оны мөн үетэй харьцуулбал 6.4%-иар буюу 52 иргэнээр буурсан байна. Тус арга хэмжээний хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтныг авч ажиллуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө буюу орон нутгийн төсвөөс 10,1 сая төгрөгийн цалин хөлсийг санхүүжүүлж олгосон. Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнесийн хөгжүүлэх зорилгоор "Старт апп" төслийн уралдааныг зохион байгуулж нийт 38 төсөл ирснээс "Gennusis game" кафе, "Baby care" өрхөд хүрч үйлчлэх эрүүл мэндийн үйлчилгээ, "Комик" номоор дамжуулж өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр, нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох гэсэн 4 төслийг шалгаруулан тус бүр 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Уралдаанд шалгарсан төслүүдийн хэрэгжилтийн үр дүнд 10 ажлын байр шинээр бий болж 16,0 сая төгрөгийн орлого олсон.	
39	3.4. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн	3.4.1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	2021 - 2025	-	Барилгын гүйцэтгэлийн хувь Улс, аймгийн аварга шалгаруулах тэмцээн, уралдааны тоо	Аймгийн хэмжээнд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд 676 өсвөрийн болон насанд хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж давхардсан тоогоор 8961 шугаман бүжгийн сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 5314 иргэдийг хамруулсан.	90%

	тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан бүрдүүлнэ.				Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийг биеийн тамирыг хөгжүүлэх ажил, арга хэмжээнд нийт 53116 иргэн хамрагдсан. Спортын холбоодтой хамтран Сагсан бөмбөгийн Үндэсний супер лигийн бүсийн финалын тоглолт, Говийн бүсийн шагайн харваан тэмцээн, Зүүн бүсийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн, Чөлөөт бөх, жүдо, шатар, даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, волейболын өсвөрийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, Сагсан бөмбөгийн Говь гаяс лиг, Волейболын хөгжлийн лиг, Шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд тус тус зохион байгууллаа. Жюү жицүгийн холбоотой хамтран “Дорноговь опен” Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын тэмцээн нийт 81 тэмцээнд /аймгийн төвд 33, сумдад 48/ 9514 тамирчин хамрагдаж спортоор хичээллэгсдийн тоо 10-15 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд 40 спортын холбоод болон ААН-тэй хамтран ажиллаж байсан бол энэ онд 67 болж өсөөд байна. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийтийн биеийн тамирыг дэмжих зорилтын хүрээнд нийтийн шугаман бүжгийн спортын дугуйлан, алхалт, гүйлт, гар дээр суниалт, дасгал хөдөлгөөн, дугуй спортын чиглэлээр 5 удаагийн тэмцээнд 2100 тамирчдыг хамруулан, спортын үйл ажиллагаанд 25772 иргэн оролцож нийтийн биеийн тамирын ач холбогдлын талаар зөв мэдлэгтэй болсон.	
40	3.4.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын	2021 - 2025	-	Шинээр байгуулсан	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг	90%

		стандарт талбай, барилгын хүртээмжийг нэмэгдүүлнэ.			спортын талбайн тоо	барих ажлын хүрээнд Сайншанд, Замын-Үүд, Хатанбулаг, Даланжаргалан, Айраг, Хөвсгөл, Өргөн, Иххэт, Зүүнбаян багт стандарт талбайн хэмжээтэй спорт цогцолборын барилга байнгын ажиллагаатай байж, орон тооны асуудлыг шийдвэрлүүлэн ажиллаж байна. Дэлгэрэх сумын төвд Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажлыг орон нутгийн төсвийн 405.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэр баян хүлэг" ХХК гүйцэтгэсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн 707,4 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэнд шаардлагатай засвар, сүүдрэвч хийх ажлын тендерт "Энержипарагон" ХХК шалгарч, засварын ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 3-р багийн нутаг дэвсгэр төв цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн талд "Хүүхдийн парк" байгуулах ажлын тендерт "Дэлгэр баясах зам" ХХК, "Энержи парагон" ХХК, "Уртын уул" ХХК-иуд шалгаран ажлыг гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 849.5 сая төгрөгийн хөрөнгөөр Дорноговь аймгийн төв садны засвар шинэчлэлийн ажлыг "Тогоруутай нуур"ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Хүүхдийн парк, аймгийн төв саадын шинэчлэлийн ажил, тоглоомын талбай, нийтийн биеийн тамирын талбайн ажлууд ашиглалтад орсноор говь нутгийн хүүхдүүд чөлөөт цаг, амралтын өдрүүдээ сонирхолтой, үр дүнтэй өнгөрөөх боломж бүрдсэн. 2024 онд Сайншанд сургуулийн 1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайг шинэчлэх ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 137.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. Сайншанд сумын 2 дугаар сургуулийн баруун талд
--	--	--	--	--	---------------------	--

						Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажлыг орон нутгийн төсвийн 712.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар"Сутайн жинст" ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 50% явагдаж байна. Орон нутгийн төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Алтанширээ суманд Спорт заал барих ажлын тендер шалгаруулалтыг 2024 оны 05 сарын 22-ны өдөр нээж нарийвчилсан үнэлгээ хийн "Эйбол" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын каркасан хийцийн угсралтын ажил 75%, гадны өрлөгийн ажил 80%, шалны бетон цутгалтын ажил эхлэхэд бэлэн болсон ажлын явц 30%-тай явагдаж байна. Барилгын суурийн ажил 30 хувьтай.	
41		3.4.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	2021 - 2025	8.0 сая	Хичээллэгсдийн тоо	“Эрүүл монгол хүн” арга хэмжээний хүрээнд “Эрүүл орчин-Эрүүл хүүхэд”, “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх”, “Орчиндоо мод тарих аян”, “Харшилгүй монгол хүн” зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж, 532 удаагийн сургалтаар 15548 хүн хамруулж, “Нийгмийн эрүүл мэндийг- Өрх бүрт” зорилтыг дэвшүүлж, эрүүл мэндийн 24 байгууллагын 296 эмч, сувилагч нар аймгийн хэмжээний 7423 өрхийн 23406 иргэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажилласан. Мөн шугаман бүжгээр давхардсан байдлаар 5,314 иргэн хамрагдсан.“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн нээлт”, “Хийн дасгалын сургагч багш бэлтгэх сургалт”, “Эмч спорт”,бүх нийтийн гүйлт арга хэмжээ, "Хутагтын нутаг-Шамбалын орноор" явган алхалт, "Сайншанд марафон-2024", “Энэ жилдээ - Эрүүл жиндээ-2 аян”, “Осол гэмтлээс сэргийлэх”, Хүүхдийн аюулгүй байдал - Таны хариуцлагаас", “Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх” аян зэрэг 10 томоохон арга хэмжээг зохион байгуулснаар төлөвлөгөө 94.1% -тай хэрэгжиж, өмнөх оноос 2.3%-иар нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих,	90%

						дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэд байгууллагын тоо нэмэгдсэн сайн талтай байна.	
42		3.4.4. Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг дээшлүүлнэ.	2021 - 2025	-	Олон улс, улс, аймгийн тэмцээнээс авсан медалийн тоо	Спортын холбоодтой хамтран Дорноговь опен Жюү жи цүгийн олон улсын нээлттэй тэмцээн, Сагсан бөмбөгийн Үндэсний супер лигийн бүсийн финалын тоглолт, Говийн бүсийн шагайн харваан тэмцээн, Зүүн бүсийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн, Чөлөөт бөх, жүдо, шатар, даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, волейболын өсвөрийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, Сагсан бөмбөгийн Говь гаяс лиг, Волейболын хөгжлийн лиг, Шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд тус тус зохион байгууллаа. Биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, спортын төрлийг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, эрүүл бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор орон нутагтаа 12 удаагийн тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 38165 иргэн оролцсон. Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны А/171 дүгээр захирамжаар “Өсвөр үе, залуучуудын шигшээ баг”-ийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн дэмжих арга хэмжээг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулсан дасгалжуулагчдыг урамшуулан, тэдний амжилтыг ахиулах зорилгоор 2022 онд амжилт гаргасан 90 тамирчин, 10 дасгалжуулагчийг, 2023 онд амжилт гаргасан 233 тамирчин 14 дасгалжуулагчийг тус тус урамшуулсан. Тайлант онд тус болзол шалгуур хангасан тамирчдыг оны эцэст урамшуулахаар төлөвлөж байна. 10 дугаар сарын байдлаар Дорноговь аймгийн тамирчид тив, дэлхий, улсын чанартай	90%

						тэмцээн уралдаанаас 115 алт, 90 мөнгө, 93 хүрэл медаль хүртсэн байна.	
43		3.4.5. Үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх бодлогыг баримтална.	2021 - 2025	50.0 сая	Төвийн тоо	Үндэсний спортын төрлүүдийн нэг шагайн тэмцээнийг өвлөн уламжлуулах, сурталчлан, таниулах зорилгоор шагайн харвааны 3 тэмцээн, МУ-ын Даян мэргэн, спортын мастер Лүндэгийн Цэнгэл агсны нэрэмжит сурын харвааны "ДАЯН КАП-2024" тэмцээн, Хатансайханы нэрэмжит 128 бөхийн барилдаан зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж, 800 гаруй тамирчид оролцлоо. Орон нутгаас сурын харвааны тэмцээнд оролцох 40 тамирчинд 4,6 сая төгрөг, сурын харвааны тэмцээн орон нутагт зохион байгуулахад 26,4 сая төгрөг, шагайн холбоонд тэмцээнд оролцоход 1,3 сая төгрөг, үндэсний бөхийн холбоод тэмцээн зохион байгуулахад 10,0 сая төгрөгийг тус тус олгож, Үндэсний спортын хөгжлийг дэмжин ажилласан. Мөн аймгийн шагайн холбоод өсвөр, залуу үе болон ахмад тамирчдад зориулан шагай харвааны өрөө бэлдэж өгч, бэлтгэл сургуулилт явуулах таатай орчныг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд үндэсний спортын 6 дугуйланд бөхийн төрлөөр 112, шагай харваагаар 108, сурын харваагаар 31 суралцагч тогтмол хичээллэж байна. Тайлант оны байдлаар үндэсний спортын дугуйланд тогтмол 251 тамирчин хичээллэж, 10 удаагийн тэмцээн, уралдааныг зохион байгуулж, 42,3 сая төгрөгөөр зарцуулсан. Мөн аймгийн шагайн холбоод өсвөр, залуу үе болон ахмад тамирчдад зориулан шагай харвааны өрөө бэлдэж өгч, бэлтгэл сургуулилт явуулах таатай орчныг бүрдүүлсэн.	90%
44		3.4.6. Иргэдийн хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг бүх талаар	2021 - 2025	-	Сургалтын тоо Дэмжиж хамтарч ажилласан ААН,	Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд иргэдийг идэвхтэй амьдралын хэв маягт хэвшүүлж эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 12821 удаагийн аян, өдөрлөг, уралдаан тэмцээн, сургалт, сурталчилгааг зохион байгуулж, давхардсан тоогоор	90%

		нэмэгдүүлж, хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжинэ.			байгууллагын тоо	204 байгууллагын 136124 албан хаагчид, иргэд хамрагдаж, 1989 төрлийн 94221 зөвлөмж тараан, цахимд 16987 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулж, 227541 хандалт авснаар иргэдийн ЭМБ дээшилсэн. Арга хэмжээний хүрээнд жил бүр аймгийн аварга шалгаруулах “Ажлын байрны дасгал”, “Хийн дасгал”, “Эмч спорт”, “Флаш моб”, “Цахим алхалт” зэрэг тэмцээнийг зохион байгуулж сүүлийн 4 жилийн хугацаанд нийт 171 багийн 2425 тамирчин оролцсон нь жил бүр 8-12 багийн 273 тамирчин нэмэгдсний үр дүнд хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг хүний тоо 13605 болж биеийн жингээ бууруулах, дархлаагаа дэмжих иргэдийн идэвх оролцоо, хандлага нэмэгдсэн. “Төвшин сайхан” ахмадын амралтын газар 2024 оны 5 сарын 1-ээс шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж, АНЭ, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар 7 хоног бүр үзлэг хийж, 352 ахмадыг үзлэгт хамруулсан. Мөн “Томуу, томуу төст өвчин, цэгэн массаж хийх”, “Эрүүл зөв хооллолт”, Цусны даралт ихсэлт зэрэг сэдвээр 254 хүнд сургалт хийж, эрүүл мэндийн дасгал зааж өгсөн байна.	
45	3.5. Газрын харилцааны бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах	3.5.1. Иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн цахим систем, газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг орон нутагт нэвтрүүлнэ.	2021 - 2025	-	Систем нэвтрэлтийн хувь	Монгол Улсын Засгийн газраас 2021-2024 онд “Цахим үндэстэн” болох зорилт дэвшүүлсний хүрээнд ГЗБГЗЗГ-с газар зохион байгуулалтын болон газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн иргэд, олон нийтэд зориулсан цахим систем /www.egazar.gov.mn/-ийг 2021 оны 10 дугаар сарын 01-нээс албан ёсоор 100% хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг веб цахим хуудаснаас иргэд, олон нийт цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 72 төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон. Шинээр газар өмчлөх-315, эзэмших, ашиглах-529, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх-529,	90%

	нөхцөлийг бүрдүүлнэ.					газар өмчлөх эрхээ гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх-25, худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах-342, эзэмшиж, ашиглаж байгаа газрын байршил хэмжээ өөрчилсөн-27, эрх сэргээх ба дуусгавар болгосон-200, барьцаанд бүртгүүлсэн-591, хугацаа сунгах-106, бусад-10 нийт 2674 нэгж талбарыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн газартай холбоотой өөрчлөлтийг хийж баталгаажуулсан. Мөн 131 нэгж талбарыг нөхөн бүрдүүлэлтээр мэдээллийн санд бүртгэн оруулсан.	
46		3.5.2. Нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтүүдийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, тооллого хийх устсан цэг тэмдэгтийг сэргээн засварлаж, нийт нутаг дэвсгэрийн бүх төрлийн байр зүйн зургаар бүрэн хангана.	2021 2025	- 9,9	Сэргээсэн цэг тэмдэгтийн тоо	Аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдэгтийн тооллогыг 2020 онд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас зохион байгуулж, Геодези, зураг зүйн тухай хуульд зааснаар цэг тэмдэгтийг орон нутгийн үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. Дээрх тооллогын үр дүнд аймгийн хэмжээнд Айраг 53, Алтанширээ 5, Даланжаргалан 9, Дэлгэрэх 8, Замын-Үүд 9, Иххэт 13, Мандах 30, Өргөн 15, Сайхандулаан 20, Сайншанд 25, Улаанбадрах 18, Хатанбулаг 30, Эрдэнэ 11, Хөвсгөл 15 ширхэг нийт 261 ширхэг геодезийн цэг тэмдэгт устсан байна. Устсан цэг тэмдэгтийг сэргээн босгоход шаардагдах төсөв ажлын даалгаврыг боловсруулж, орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг жил бүр зохион байгуулан ажиллаж, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд Дэлгэрэх суманд 5, 2022 онд Сайншанд суманд 1, Замын-Үүд суманд 1, 2023 онд Дэлгэрэх суманд 5 цэг тэмдэгт, Сайхандулаан 10, Айраг суманд 3 цэг тэмдэгт, нийт 2021-2024 онд геодезийн 25 цэг тэмдэгтийг засварласан байна.	50%
47		3.5.3. Газар зохион байгуулалтыг иргэд болон эдийн засгийн хувьд үр	2021 2025	- -	Систем нэвтрэлтийн хувь	Улсын хэмжээнд 2021 оноос “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлэн, аймгийн ГХБХБГ, сумын газрын даамал өдөр тутмын үйл ажиллагаандаа	90%

		өгөөжтэй, экосистемийн тэнцвэрт байдлыг харгалзан оновчтой төлөвлөнө.				ашиглан ажиллаж байгаа ба аймаг, сумын 2019-2024 оны газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичгийн нийт 566 төслийг системд бүрэн оруулж, кадастр, цахим биржийн системээр дамжуулан төлөвлөлтийн дагуу газар олгох ажлыг хэрэгжүүлэн ажилласан. 2024 оны 10 сарын байдлаар газрын удирдлагын нэгдсэн системээр сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд нийт 398 саналыг иргэд олон нийтээс цахим хэлбэрээр ирүүлсэн байна. Орон нутгийн төсвийн 126.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 7 багийн нутаг дэвсгэрт 337.7 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК нь гүйцэтгэж, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.	
48		3.5.4. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.	2021 2025	- 3.0	Судалгааны ажлын гүйцэтгэл хувь	Аймгийн хэмжээнд “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлыг жил бүр тогтмол зохион байгуулж, мониторингийн хэмжилт судалгааны цэгийн тоог жилээс жилд нэмэгдүүлэх, төлөөлөх чадварыг сайжруулахаар ажиллаж 2021-2024 онд 14 сумын нутаг дэвсгэрт нийт 228 цэгт бэлчээрийн фотомониторингийн ажиглалтын хээрийн судалгааг хийж гүйцэтгэн ажлын үр дүнг үндэслэн холбогдох дүгнэлт, санал, зөвлөмж, чиглэлийг жил бүр сумдын Засаг дарга нарт хүргүүлэн ажилласан. Үр дүнд тус газраас хүргүүлсэн санал, зөвлөмжийн хүрээнд 9 сумын нутаг дэвсгэрт 4.5 сая орчим га талбайг малын хөлөөс чөлөөлөх, сэлгэн ашиглах зэргээр хамгаалсан байна.	70%
49		3.5.5. Хаягийн тэмдгийн суурилуулалтын	2021 2025	- 55.6	Хаягжуулалт хийсэн сумын тоо Мэдээлийн санд	Аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн 208,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд, Улаанбадрах сумаас бусад сумдад 9021	100%

		ажлыг зохион байгуулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд оруулж, олон нийтэд сурталчилна.			оруулсан хаягийн мэдээллийн хувь	хаягийн тэмдгийн суурилуулалтын ажил хийж, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд оруулсан. “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай”, “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2022 оны 180, 181 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталгаажуулаагүй гудамжийг баталгаажуулж, хаягийн мэдээллийн санд оруулах үүрэг, чиглэлийг өгснөөр гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын дагуу шинээр 601 нэгж талбар, барилгыг дугаарлан хаягийн мэдээллийн системд бүртгэсэн. Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 13 суманд хаягийн тэмдгийн суурилуулалтын ажил бүрэн хийгдсэн.		
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ								
50	4.1. Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн үр ашигтай, хариуцлагатай зарцуулах бодлого баримтална.	4.1.1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, татвар төлөгчдийг татварт хамруулах хүрээг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	-	Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааны цахимжуулалт	“Цахимаар татвараа төлж цагаа хэмнэе” уриан дор татвар төлөгчдөд чиглэсэн 29 төрлийн татварын үйлчилгээг 100 хувь цахимаар хүргэж, НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг сайжруулахаар "Баримтаа аваарай" сошиал аяныг зохион байгуулсан. "Нэхэмжлэлд суурилсан" татвар ногдуулалт, төлөлтийн цахим систем бий болсноор татвар төлөгч татварын алба болон банканд очих шаардлагагүй болж цахим банкаар татвараа төлж ,тайлагнах боломжийг бүрдүүлсэн. 2024 оны 10 сарын байдлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан-1261, НӨАТ-ын тайлан-6437, Суутган-7778 татвар төлөгч цахимаар тайлангаа илгээж, хамрагдалт өнгөрсөн оны мөн үеэс 4.3 хувиар өссөн. Мөн Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан, Алтанширээ, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг	100%

						сумдад татвар төлөгчийн ажлын байранд очиж явуулын посоор татвар хураах үйлчилгээг үзүүлж, давхардсан тоогоор 8519 татвар төлөгчийн 1,169.7 сая төгрөгийн татварыг хураан төсөвт төвлөрүүлсэн. Татварын газрын байранд Төрийн банкнаас 1 теллер байрлаж, банкны үйлчилгээг бэлэн болон бэлэн бусаар өдөр тутам үзүүлж байгаа нь татвар төлөгч нарт хүргэх үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлсэн.	
51		4.1.2. Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулна.	2021 2025	- -	Төсвийн зарлагын хэмнэлт	Тайлант оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсөвт 115.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 80.9 хувьтай байна. Орон нутгийн төсвийн орлогын биелэлттэй уялдуулан зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэн төрийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зардал, төсвийн байгууллагуудын халаалтын зардлыг эхний ээлжид санхүүжүүлэх эрэмбэ тогтоож 109.3 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 58.7 хувь буюу 76.8 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байна. Аймгийн Засаг даргын баталсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөө болон төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг 2021-2023 онуудад давхардсан тоогоор 114 байгууллага, тусгай санд хийж гүйцэтгэн нийт 4,409.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, санхүүгийн сахилга батыг сайжруулах зөвлөмж, арга зүйгээр хангаж ажилласан. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 18 байгууллагад төлөвлөгөөт, удирдах дээд шатны байгууллагын шийдвэрээр 3, нийт 14 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.	90%

						Шалгалтаар 2024 оны 10 сарын байдлаар 217.9 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 2 албан шаардлага бичиж, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 130 төлбөрийн акт тогтоон 160.0 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулсан.	
52		4.1.3. Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийх санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлнэ.	2021 - 2025	-	Шилэн дансны мэдээллийн хувь	2024 онд төсвийн 66 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 57 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэхээс 18 байгууллагад төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, 14 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит тус тус хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 217,9 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 130 акт тогтоон, 2 албан шаардлага бичиж, 166,0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан. Монгол Улсын “Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу 14 сумын 133 төсвийн байгууллага, аймгийн төвийн 14 байгууллага, нийт 147 байгууллагын цахим хуудсанд төсөв санхүүгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлэлсэн эсэхэд хяналт шалгалтыг жил бүр зохион байгуулсан. Цахим хуудсанд 2022 онд 6238 мэдээллийг хугацаанд нь, 128 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь байршуулвал зохих мэдээллийн 98,1 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0,2 функтээр өссөн үзүүлэлттэй байна. Дорноговь аймаг сүүлийн 3 жилд шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулбал зохих мэдээллийг 97,9-98,6 хувиар байршуулж улсын хэмжээнд эхний 3 байранд эрэмбэлэгдсэн.	100%
53	4.2. Төрийн худалдан авах ажиллагааг хариуцлагажуулан орон нутгийн аж	4.2.1. Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн	2021 - 2025	-	Худалдан авах төлөвлөгөөний дагуу цахимаар зохион байгуулсан	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 2021-2024 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 391 төсөл арга хэмжээний 211,5 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зардлаас 4 төсөл арга хэмжээний 993,0 сая төгрөг батлагдаж, улсын	100%

	ахуйн нэгж, байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.	тендер шалгаруулалт"-ын бодлого хэрэгжүүлнэ.			тендер шалгаруулалтын хувь	төсвийн хөрөнгө оруулалтаар яамдууд болон сайдын багцаас 91,7 тэрбум төгрөгийн 26 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн. Нийт батлагдсан төсвийн хүрээнд тендер шалгаруулалтыг хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулж тендерийн урилга, гарсан үр дүнг тухай бүр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад олон нийтэд нээлттэй ил тод байдлаар зарласан. Мөн байгууллагын мэдээллийн самбар болон www.shilendans.gov.mn, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудаст байршуулсан. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим засаглалын бодлогын хүрээнд тендер шалгаруулалтыг цахим систем рүү шилжүүлсэн нь төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийн хүртээмж, үйл явцын хурд, ил тод байдал, шударга өрсөлдөөнийг бий болгож, хяналт сайжирсан.	
54		4.2.2. Тендер шалгаруулалтад хуулийн дагуу давуу эрх нь тооцогдох боломж бүхий аж ахуйн нэгжүүдийн чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтална.	2021 2025	-	Давуу эрхийн зөрүү тооцсон ААНБ-ын тоо	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогч давуу эрх тооцуулах нотлох баримт бичгийг тендерт ирүүлэх бөгөөд давуу эрх олгох бол санал болгож буй үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцох тухай тендер шалгаруулалтын зааварчилгаанд тусгасан байдаг. Худалдан авах ажиллагааны газраас 2021-2024 онуудад зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 2021-2022 онд 10 аж ахуйн нэгж, 2023-2024 онд 3 аж ахуйн нэгжээс орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулсан ба дотоодод үйлдвэрлэсэн бараа материал худалдан авах хүсэлт ирж, нотлох баримтуудыг үндэслэн дотоодын	100%

						давуу эрхийн зөрүүг 2021-2024 онд нийт 1746,8 сая төгрөгөөр хийсвэрлэн тооцсон. Худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 2024 онд нийт тендерт шалгарсан компаниудаас 44% нь орон нутгийн компани шалгарсан байна. Энэ нь 2021 онтой харьцуулахад 10%-иар өссөн үзүүлэлттэй байна.	
55	4.3. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	4.3.1. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжиж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	Үйл ажиллагаа явуулсан үйлдвэрийн тоо БОМТ дүгнэсэн компанийн тоо, Хамтран ажиллах гэрээний тоо	Аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл 215, хайгуулын тусгай зөвшөөрөл нийт газар нутгийн 9.2 хувийг эзэлж байна. Аймгийн Засаг даргын 2019 оны А/938 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2021 онд 13 аж ахуйн нэгж, 2022 онд 25 аж ахуйн нэгж, 2023 онд 29 аж ахуйн нэгжийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч нийт дундаж 91 хувийн хэрэгжилттэй ажилласан. 2024 оны 10 сарын байдлаар төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 5 удаа зохион байгуулж 20 объектыг хамруулан 26 зөрчил дутагдал илрүүлж, илэрсэн зөрчил дутагдалд 17 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлж байгаль орчны эсрэг зөрчил үйлдсэн 7 иргэн, 4 ААН-д 13.0 сая төгрөгийн нөхөн төлбөр, 12.2 сая төгрөгийн торгууль оногдуулсан. Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Хариуцлагатай уул уурхайн зөвлөгөөн"-ийг 2021, 2023 онд зохион байгуулж зөвлөгөөний үеэр уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр "Хамтран ажиллах гэрээ"-г	90%

						давхардсан тоогоор 20 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулж, 80 хувийн дундаж биелэлттэйгээр хэрэгжүүлж ажилласан. Мөн хог хаягдал, ус ашиглах гэрээг давхардсан тоогоор 60 гаруй аж ахуйн нэгж байгууллагатай байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж дүгнэсэн. 2023,2024 онд Байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй 7 иргэн, 10 аж ахуйн нэгжийг 15,2 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, Байгалийн нөөцийг зөвшөөрөлгүй ашигласан 9 аж ахуйн нэгжийг нийт 45 сая төгрөгөөр торгож, 750, 9 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж барагдуулсан.	
56		4.3.2. Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барихад орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	2021 2025	-	45,0	Гүйцэтгэлийн хувь "Чойр-Сайншандын 220 кВ-ын ЦДАШ төсөл"-ийг Европын сэргээн босголтын банкны 62,8 сая ам.долларын зээл, 12,0 сая еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 256 тогтоолоор шийдвэрлэсэн. Төслийн ТЭЗҮ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг 2021 онд гүйцэтгүүлсэн. Европын сэргээн босголтын банкнаас барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2 үе шаттай тендер зарласны дагуу тенерт 1-р үе шатны тендерт техникийн санал ирүүлсэн хуулийн этгээдийн материалыг хянах ажил хийгдэж байна. 1-р үе шатны тендерт тэнцсэн хуулийн этгээдээс 2-р үе шатны санхүүгийн санал авах тендер зарлагдах юм. Орон нутгийн зүгээс 2021 онд Чойр-Сайншанд чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зориулалт бүхий 7.8 га газрыг шийдвэрлэж гэрчилгээг олгосон. 2024 оны 05-р сард төсөл хэрэгжүүлэх нэгж, болон орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл ЦДАШ барих трассын дагуу газар дээр нь ажиллаж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.	90%

57		4.3.3. Нүүрс- химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг дэмжиж эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	-	Дэд бүтцийн ажлын гүйцэтгэлээр	Алтанширээ сумын нутаг дэвсгэрт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажлыг "JMC projects India" компани гүйцэтгэж ажлын явц 98 хувийн гүйцэтгэлтэй, Улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангагдаж байна. Анхдагч процессын болон дагалдах байгууламж болон үйлдвэрийн цахилгаан станцын суурийн ажлууд хийгдэж байна. "Монголиан транс ложистик" ХХК-ийн "Алтанширээт" үйлдвэр технологийн паркийн барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй, Айраг сумын нутаг дэвсгэрт "Алтраг ахас" ХХК-ийн манган боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй, Цагаан суваргын зэс молбидены үйлдвэрийн хөвүүлэн баяжуулах үйлдвэр, бутлуурын хэсэг, тээрмийн барилгын суурийн цутгалт 70 хувь, краказ угсралтын ажлууд 20 хувийн гүйцэтгэлтэй, нийт төслийн ажил 55 хувьтай, Хөвсгөл сумын нутагт баригдаж буй "Гэрэлт говь" аж үйлдвэрийн угаах үйлдвэрийн барилгын ажил 90 хувьтай, коксийн үйлдвэрийн барилгын ажил 15 хувьтай, төмөр замын далан, гүүрэн байгууламжийн ажил 97 хувьтай нийт төслийн ажил 35 хувийн гүйцэтгэлтэйгээр ажлаа үргэлжлүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас үйлдвэрлэл технологийн паркаар зарлагдсан Алтанширээ сумын нутаг дэвсгэрт байрлах "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн паркийн 674.44 га, Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт байрлах "Гэрэлт говь" үйлдвэрлэл технологийн паркийн 264.38 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн. Орон нутагт уул уурхайн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн бодлогыг дэмжих ажлын хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2022-2023 онд Айраг, Даланжаргалан, Мандах,	90%
----	--	---	--------------	---	---	--------------------------------------	--	-----

						Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутаг дэвсгэрт 10 байршилд 3337.38 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар олголтын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн.	
58		4.3.4. Зарим сумдын дулааны болон цахилгааны эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх судалгааны ажлыг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлэн сумдын хөгжлийг дэмжинэ.	2021 - 2025	Хөвсгөл сум 166 сая, Улаанбадрах сум 130 сая төгрөг.	Гүйцэтгэлийн хувь	Иххэт сумын дулааны станцын 3-р зуухны их засварын ажлыг 100,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Эрчим дөл” ХХК-иар гүйцэтгүүлж 2022 онд ашиглалтад хүлээн авсан. Улаанбадрах суманд 2 зуух, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 565,3 сая төгрөгийн санхүүжилтээр “Ингүүмэл-Оргил” ХХК, Айраг сумын Дулааны станцын 3-р зуухыг шинэчлэх ажлыг 134,9 сая төгрөг, Өргөн сумын уурын зууханд өргөтгөл шинэчлэлт хийх ажлыг 178,0 сая төгрөг, Зүүнбаян багийн халаалтын зуухыг шинэчлэх ажлыг 239,6 сая төгрөгийн санхүүжилтээр “Бэсүжин констракшн” ХХК тус тус гүйцэтгэж 2024-2025 оны халаалтын улиралд үйл ажиллагааг хэвийн явуулахыг нөхцөлийг хангасан. Мандах, Сайхандулаан сумдын төвд халаалтын зуух, инженерийн нэгдсэн шугам сүлжээ барих ажлын зураг төсвийг 199,3 сая төгрөгийн санхүүжилтээр “Хайдро дизайн прожект” ХХК гүйцэтгүүлсэн. Уг зураг, төсвийн дагуу Мандах суманд халаалтын зуух, инженерийн нэгдсэн шугам сүлжээ байгуулах ажлыг 10769.8 сая төгрөгийн санхүүжилтээр “Одконхолдинг” ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 2024.10.30-ны өдрийн байдлаар 10%-тай байна. Гэрээний хугацаа 2025.11.01-д дуусна. Аймгийн төвийн дулааны станцын өргөтгөлийн ажлыг “Энерготех сервис” ХХК 5,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэхээр гэрээний байгуулсан. Ажлын гүйцэтгэл 10%-тай. Гэрээний хугацаа 2025.10.10 дуусна.	100%

					2021-2024 онд аймгийн хэмжээнд 23,9 км цэвэр усны шугам, 19,3 км бохир усны шугам, 20,4 км дулааны шугам буюу нийт 63,6 км шугамыг шинээр барьж ашиглалтад оруулж төвлөрсөн шугам сүлжээний хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлсэн. 14 сум нь төвийн цахилгаан эрчим хүчний нэгдсэн системд бүрэн холбогдсон. 2021-2024 онд Дэлгэрэх, Сайншанд, Хөвсгөл, Иххэт, Хатанбулаг, Даланжаргалан, Алтанширээ, Мандах сумдад орон нутгийн төсвийн 1,7 тэрбум төгрөг, улсын төсвийн 467,0 сая төгрөг, дэлхийн банкны 6,3 тэрбум төгрөг, нийт 8,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 0,4 кВ-ын 80,3 км, 10 кВ-ын 11,2 км ЦДАШ, 37 дэд станцыг шинээр барьж орон нутгийн цахилгаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.	
59	4.3.5. Эрчим хүчний салбарт хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, үргүй зардлыг багасгана.	2021 - 2025	Айраг сум 13 Сайншанд сум 5,2 2 32 Дэлхийн банкны 4,5 тэрбум төгрөг	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Айраг салбарын сүлжээний усны насос шинэчилж, давтамж хувиргуур суурилуулсан. Сайншанд сумын усны насос, нэмэлт усны насос шинэчилсэн. Дулааны эх үүсвэр 2-ын цахилгаан тоноглол бүрд давтамж хувиргуур суурилуулан, усны алдагдлыг бууруулсан. Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 481 дүгээр тогтоолын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд 2302 өрхийн 1,3сая10кВт.ц ашиглалтад 103,7 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн цахилгаан халаалтыг ашиглахад дэмжлэг үзүүлсэн. 2021-2024 онд Дэлхийн банкны 6,3 тэрбум төгрөг санхүүлжилттэй “Эрчим хүч-2 төсөл”-ийн хүрээнд Сайншанд суманд 1 фазын 6203ш, 3 фазын 817ш, Замын-Үүд суманд 1 фазын 3212 ш, 3 фазын 322ш, Нийт 10554ш ухаалаг тоолуур суурилуулсан. Эрчим хүчний хэмнэлт үр ашиг, зохистой хэрэглээний талаар хэрэглэгчдэд нөлөөлөх	90%

						чиглэлээр Сайншанд сумын төвийн 25 төсөвт байгууллагын 1500 гаруй ажилтанд, Сайншанд, Хатанбулаг, Замын-Үүд сумдын багийн иргэдийн нийтийн хуралд давхардсан тоогоор 750 гаруй иргэдэд сургалт, мэдээллийг тус тус өгсөн. Мөн аймгийн 9 сумдын ус, дулаан хангамжийн үйл ажиллааг хариуцан ажилладаг “Чандмань-Илч” ОНӨХХК нь 2021-2024 онд Эрчим хүч хэмнэх ажлын хүрээнд 20 ажилд 157,3 сая төгрөг зарцуулж 95,7 сая төгрөг буюу 469360кВт.ц эрчим хүч хэмнэсэн.		
60	4.4. санхүүгийн найдвартай байдлыг сайжруулна.	Банк,	4.4.1. Банкны үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх замаар иргэдийн хуримтлал үүсгэхэд анхаарч бэлэн бус төлбөр тооцоог дэмжинэ.	2021 2025	-	Иргэд, ААНБ-ын харилцах, хадгаламжийн үлдэгдэл	2024 оны эхний 9 сарын үлдэгдлийг 2020 оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад иргэд, байгууллагын харилцах дансны үлдэгдэл 36.0-109.4 тэрбум төгрөг болж 73.4 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн үлдэгдэл 118.9-231.9 тэрбум төгрөг болж 113.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ, хуримтлал үүсгэх ач холбогдлын талаарх мэдээлэл, зөвлөгөөг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр болон цахим сүлжээгээр тогтмол мэдээлж ажиллав. 2024 оны 09 сарын байдлаар АТМ 72, интернэт банкны хэрэглэгч 71.641, ПОС төхөөрөмж хэрэглэгч 1.906, мобайл банкны хэрэглэгч 38915 байна.	100%
61			4.4.2. Иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэн санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлнэ.	2021 2025	-	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, иргэдийн санхүүгийн дарамтаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд жил бүр “Global money week”, “Дэлхийн хуримтлалын өдөр” аяныг зохион байгуулж, ажилладаг бөгөөд 2024 онд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран "Хадгаламж өлсөхөөс эхэлдэг" номын зохиолч, лектор, коуч Г.Мөнгөнийг урин ахлах ангийн сурагчид болон эцэг эхчүүд, иргэдэд “Хэрхэн хадгаламж үүсгэх вэ?” сэдвээр сургалт зохион байгуулж, ахлах ангийн 280 сурагч, 37 иргэн, “Санхүүгийн сахилга бат” сэдвээр насан хүрэгчидтэй	90%

					өглөөний уулзалт зохион байгуулж 15 хүн тус тус хамрагдсан. Монгол Банк цагдаагийн газартай хамтран цахим залилангийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж нийт 1486 гаруй сурагчдад мэдээлэл өгсөн. АУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн оюутан болон Политехникийн нийт 180 гаруй оюутан, залууст мэдээлэл өгсөн. Дорноговь аймгийн нийт 24844 үүрэн телефон ашигладаг иргэдэд масс мессеж хүргэсэн. Дорноговь аймаг дахь Монголбанк, аймгийн Насан туршийн суралцахуйн төв, Транскапитал ББСБ хамтран богино хэмжээний видео бичлэгийн цахим уралдаан зохион байгуулж, нийт 3099 хэрэглэгчдэд мэдээлэл хүргэсэн.	
62	4.4.3. Иргэдийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд анхаарч, хугацаа хэтэрсэн зээлийг бууруулж, зээлжих чадварыг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	-	Банкны чанаргүй зээлийн үлдэгдэл 2024 оны эхний 9 сарын үлдэгдлийг 2020 оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад нийт зээлийн багц 289.5-519.9 тэрбум төгрөг болж 230.4 тэрбум төгрөгөөр өссөн, чанаргүй зээлийн үлдэгдэл 7.2 тэрбум төгрөг буюу зээлийн багцад эзлэх хувь 2.51% байсан бол тайлант хугацаанд 11.6 тэрбум төгрөг буюу зээлийн багцад эзлэх хувь 2.24% болж буурсан үзүүлэлттэй байна. Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (Ковид-19) -ын цар тахлын үед хилийн боомтын үйл ажиллагаа зогсонги байдалд орж, иргэдийн орлого буурснаас шалтгаалж, зээлийн эргэн төлөлт удаашрах, Засгийн газраас хэрэгжүүлсэн ипотекийн зээлийг хойшлуулсан зэрэг үзүүлэлтээс шалтгаалан 2022 оны 12 сарын 31-ний байдлаар аймгийн банкнуудын зээлийн багц 306.8 тэрбум, чанаргүй зээл 18.1 тэрбум байсан нь нийт багцын чанаргүй зээлийн эзлэх хувь 5.9%, Замын Үүд дэх банкны хугацаа хэтрэлт 12,2 тэрбум төгрөг болж, нийт багцад эзлэх хугацаа хэтрэлт 12,9%-д хүрч байсан	90%

						бөгөөд Замын Үүд дэх хилийн боомтын үйл ажиллагаа хэвийн явагдаж банкны багцад эзлэх хугацаа хэтрэлт 12.9-2.8% хүрч буурсан байна.	
63	4.5. Даатгалын хариуцлагын тогтолцоог сайжруулан, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	4.5.1. Албан журмын даатгалын холбоо, даатгал, хөрөнгийн үнэлгээний компаниудын хохирол барагдуулах ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.	2021 2025	-	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	90%
64		4.5.2. Даатгалын байгууллагын нөхөн төлбөр олголтыг сайжруулна.	2021 2025	-	-	Нөхөн төлбөрийн олголтын хувь	90%

65		4.5.3. Иргэдийг даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг дэмжинэ.	2021 2025	- -	Даатгалд хамруулсан иргэдийн тоо	Аймагт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа даатгалын компаниуд нь 2021-2024 онд нийт 13812 иргэн аж ахуйн нэгжтэй даатгалын гэрээ байгуулсан нь 2021 онтой харьцуулахад 4218 иргэн аж ахуйн нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. 2024 онд даатгалын хугацаа дуусаагүй 13212 гэрээ байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Өнөөгийн Ялалт" сонинд 4 удаа, аймаг дахь ДТВ, DSB телевизүүдэд 3 удаа нийтлэл, мэдээлэл нэвтрүүлэн, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.	90%
66	4.6. Хөрш болон бүс нутгийн орнуудтай эдийн засгийн болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	4.6.1. Хөрш болон өндөр хөгжилтэй орнуудтай уламжлалт харилцаагаа үргэлжлүүлж, шинээр бусад улсуудын муж, хотуудтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	2021 2025	- -	Гэрээ, санамж бичгийн тоо	Хөрш орнууд болон өндөр хөгжилтэй орнуудын хот, муж, аймгуудтай уламжлалт найрамдалт харилцааг өргөжүүлэн хөгжүүлж БНХАУ-ын 5 хот,хошуудтай (Ляонинь мужийн Жинжоу хот, Жан Жиа Коу хот, Пенжоу хот, ӨМӨЗО-ны Эрээн хот, Бугат хот, Хөх хот, Улаанцав хот, Шилийн гол, Дархан Муу мянган холбоот хошуу, Жининь хот, Дөрвөд хошуу г.м), БНСУ-ын 2 /Өмнөд Чолла, Гванжу/хоттой, Япон улсын 2 /Шизуока, Яйзү хот/ мужтай, Дорноговь аймгийн 4 сумыг ӨМӨЗО-ны хот, хошуудтай, 13 байгууллагыг холбогдох байгууллагуудтай холбоо тогтоолгон бүх талаар харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хэлэлцээр байгуулан ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд мэргэжилтэн бэлтгэх, туршлага судлуулах, суралцуулах арга хэмжээг зохион байгуулж, Япон улсын Шизуока мужид Ерөнхий боловсролын сургуулийн 62 сурагч, 9 багш, 35 төрийн албан хаагч, БНСУ-ын Сөүл хотод 12 эмч, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хот, Дархан Муу Мянган Холбоот хошуунд 15 эмч, Шилийн гол, Бугат хот, Эрээн хот, Улаанцав хот, Дархан Муу Мянган Холбоот хошуу зэрэгт 60 гаруй төрийн албан	100%

						хаагч, Тайвань хотод 3, Малайз улсад 1, Сингапур 1, БНСУ-д 14 төрийн албан хаагчийг урт богино хугацааны сургалтад хамруулсан. Мөн хамтын ажиллагааны хүрээнд 7 тэрбум гаруй төгрөгийн 10 төсөл, хөтөлбөр хэрэгжиж гадаадын хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татан ажиллаж байна. БНХАУ-ын Хунан мужийн Жан жяжие хоттой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах асуудал хэрэгжилтийн шатандаа явж байгаа бол 2024 оны байдлаар шинээр 8 санамж бичгийг байгуулсан байна.	
67		4.6.2. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудтай холбож, үр ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.	2021 2025	- -	Хамтын ажиллагаатай байгууллагын тоо	Аймгийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг гадаад харилцааны хэрэгслээр дэмжиж гадаад улс орны хот, мужууд, төрийн байгууллага, олон улсын байгууллагууд, төсөл хөтөлбөрүүд, хөрөнгө оруулагчдад аймгийг сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтоор 9 хот дүүрэг, 15 олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй харилцаа тогтоон гадаад хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Хамтын ажиллагааны хүрээнд 7.0 тэрбум гаруй төгрөгийн 10 бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжиж гадаадын хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татан ажилласан бөгөөд боловсролын бодлого, газар тариалангийн стратеги, халамжийн бодлого, спорт-биеийн тамир, хүний нөөцийн үндсэн зохицуулалт, хэвлэл мэдээлэл, ерөнхий боловсрол, аялал жуулчлал, дэд бүтэц зэрэг чиглэлээр гадаадын муж, хотууд, олон улсын байгууллагуудтай төр, хувийн хэвшлийн байгууллагуудад тулгуурлан хамтын ажиллагааг өргөжүүлсэн. Дорноговь аймаг болон Эрхүү хотын хооронд хамтран ажиллах Санамж бичгийг байгуулсантай холбогдуулан бүс нутаг, хил орчмын соёлын харилцааг өргөжүүлэх, жил бүр зохион	100%

					байгуулагддаг олон улсын түвшний соёл урлагийн фестиваль, өдөрлөг үзэсгэлэнд аймгийн уран бүтээлчдийг оролцуулах, залуу уран бүтээлчид, зураачдын үзэсгэлэнг харилцан зохион байгуулах, сонгодог бүтээл, драмын жүжиг харилцан солилцож, хүүхэлдэйн театруудын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго тавин бэлтгэл ажлыг хангаж байна. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Дорноговь аймаг, Япон Улсын Шизуока мужийн хооронд найрамдалт харилцааны нэг салбар болгож эхлүүлсэн ахлах ангийн сурагч харилцан солилцох хөтөлбөрт 17 сурагч, 3 багш хамрагдсан бөгөөд 2012 оноос хойш тус хөтөлбөрт нийт 400 гаруй сурагч 30 гаруй багш, ажилчид хамрагдсан байна. Сайншанд сумын Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах, инженер техникийн ажилчдыг чадавхжуулах зорилгоор “Жайка” Олон Улсын байгууллагатай хамтран 3 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд онол, дадлага хэлбэрээр танхимаар болон цахимаар сургалтууд 30 гаруй удаа зохион байгуулагдсан бөгөөд Чандмань-Илч ХХК-ын 15 инженер, техникийн ажилчид тус мужид сургалтад хамрагдаад ирсэн бол мужийн төлөөллүүд Дорноговь аймагт 1 удаа айлчилж, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, дадлагажуулах ажлыг зохион байгуулсан. Гадаад улс орны хот, мужууд, төрийн байгууллага, олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчидтай хамтын ажиллагааг хэрэгжүүлж гадаад улсын 9 хот, муж, 9 олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байгаа нь хамтын ажиллагаатай хот мужуудыг 3-аар, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр 3-р тус тус нэмэгдсэн.	
--	--	--	--	--	--	--

ТАВ. ЗАСАГЛАЛ

68	5.1. Төрийн тогтвортой бодлого бүхий ухаалаг засаглалыг бэхжүүлж, олон нийтийн оролцоо, хяналтыг төлөвшүүлнэ.	5.1.1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, үр дүнг дээшлүүлнэ.	2021 2025	-	-	Хэрэгжилтийн хувь	"Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/05 дугаар тогтоолоор батлан хэрэгжилтийг жил бүр тайлагнан ажиллаж байна. Уг дунд хугацааны бодлогын баримт бичгээр 114 заалт, арга хэмжээг тусган 2021 онд 88.9%, 2022 онд 89.4%, 2023 онд 89,2 %-тай хэрэгжүүлэн ажилласан. "Хөгжлийн төлөө хамтдаа-2" Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны /2020-2024/ хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/06 дугаар тогтоолоор батлуулсан. Нийт 279 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлэн хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Хот, хөдөөгийн сэргэлт"-ийн хүрээнд орон нутагт шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих цогц бодлогыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт оруулж 3 зорилт нэмсэн. Мөн хяналт, шинжилгээ, үнэлгээ, бусад шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй 6 заалтыг хасаж, 2 заалтад найруулгын өөрчлөлт оруулсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж аймгийн Засаг даргын захирамжаар батлан 2021 онд 89.1%, 2022 онд 92.2%, 2023 онд 93,6%, 2024 оны хагас жилийн байдлаар 94,6%-тай хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хугацаа буюу жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулж хэвшсэн. "Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн	90%
----	---	---	--------------	---	---	-------------------	--	-----

					төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөлтэй хамтран үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйгээр анх удаа 2024 оны хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулан аймгийн ИТХ-ын 2023 оны 14/01 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу улсын болон орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг журамд заасан хугацаанд тогтмол хүргүүлж хэвшсэн. Дээрх бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн агентлаг, сумдын дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан талуудын харилцан хүлээх үүргийг тодорхой зааж, тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, аймгийн Засаг даргын 2022 оны 675 дугаар захирамжаар үнэлж дүгнэж байна.		
69		5.1.2. Орон нутгийн бодлого шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.	2021 - 2025	-	Иргэдийн оролцооны хувь	Швейцарын хөгжлийн агентлаг, Нийгмийн эгэх хариуцлагын Дэлхийн түншлэлийн санхүүжилтээр Дэлхийн банкнаас Глоб Интернэшнл төвтэй орон нутагт хамтран хэрэгжүүлж байгаа MASAM II төслийн хүрээнд "Төсвийн хөрөнгө оруулалт" апп-ыг иргэдэд таниулах, тэдний саналыг авах талаар сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, холбогдох удирдлага, албан хаагчидтай зөвлөлдөж, санал солилцож Улсын төсвийн хөрөнгө оруулалт аппликейшн (PIMIS)-ийг гар утсандаа татаж суулган, иргэдийн оролцоо цэсээр дамжуулан 2024 онд хэрэгжих улсын төсвийн хөрөнгө	90%

					оруулалтад саналаа өгөх талаар Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Dtv телевиз, Өнөөгийн Дорноговь сонин-оор дамжуулан нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж иргэдийн оролцоог хангаж ажилласан. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд иргэд, олон нийт, агентлаг, сумдаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран зохион байгуулж, саналыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг аймгийн хэмжээнд зохион байгуулан нийт 3200 гаруй иргэдийг мэдээллээр хангаж, цаасан болон цахим хэлбэрээр хуулийн төсөлд санал авах ажлыг тус тус зохион байгуулсан. Орон нутгийн бодлого шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд тус онд “Золбин нохой, муурыг хот, суурин газарт галт зэвсэг ашиглан устгах журам”, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” хэм хэмжээний актын төсөлд иргэдээс танхимын болон цахим хэлбэрээр саналыг хуулийн хугацаанд авч ажилласан. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ард иргэдэд сурталчлан таниулах, иргэдийн санал хүсэлтийг авч бодлого шийдвэртээ уялдуулан тусгах ажлыг 2024 онд аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж “Хот айл”, “Хөршийн холбоо” арга хэмжээг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд 14 сумын нийт 65 багт ажиллаж, сумдын нийт малчин өрхийн 59,3% хувь буюу 10,333 иргэнтэй уулзалт хийж, хаваржилтын	
--	--	--	--	--	--	--

						нөхцөл байдал, малчдад тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах ажилд иргэдийн үзэл санааг тусгах хүрээнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан ажиллаж байна. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг сайжруулах хүрээнд байгууллагын цахим хаягаар дамжуулан бодлого, шийдвэр, цаг үеийн мэдээллийг тогтмол хүргэж байна.	
70	5.2. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой тодорхойлж, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллах тогтолцоог төлөвшүүлнэ.	5.2.1. Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	Шинжилгээ хийсэн байгууллагын тоо	Сайншанд, Замын-Үүд сумдын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ хийх үүрэг хүргүүлж, чиг үүргийн шинжилгээг асуулга, ажлын байрны зураг авалтын аргаар хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан ирүүлснийг үндэслэн, сумын Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагыг нэгтгэх замаар чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч ажилласан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог чиг үүргийн оновчтой хуваарилж зарчмаар шинэчилж аймгийн Засаг даргын 2023 оны А/68 дугаар захирамжаар бүтцийг шинэчлэн баталсан. Тайлант хугацаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтцийг аймгийн Засаг даргын 2023 оны А/305 дугаар захирамжаар шинэчлэн баталлаа. Орон нутгийн зарим агентлаг байгууллагуудын албан тушаал, ажлын байрны чиг үүргийг оновчтой тодорхойлж чиг үүргийн дүн шинжилгээг 2023 онд зохион байгуулж судалгаа мэдээллийн ажлын үр дүнг холбогдох байгууллагуудад хүргүүлж	70%

						ажилласан. Тус ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/08 захирамжаар Орон нутгийн өмчийн газрын зарим чиг үүргийг салгаж Худалдан авах ажиллагааны газрыг 11, Орон нутгийн өмчийн газрыг 13 орон тоотойгоор тус тус баталсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчилгээний ажилтны 2 орон тоог нэмэгдүүлж ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар болон Сайншанд сумын Захирагчийн ажлын албаны ажлын байранд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Тус ажлын хүрээнд ажлын байрны давхцал, ачааллыг тэнцвэржүүлэх зэрэг үр дүн гарсан.	
71		5.2.2. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, төр, иргэний хамтын ажиллагааны оновчтой арга хэрэгсэлийг нэвтрүүлнэ.	2021 - 2025	-	-Иргэдийн өргөдөл, гомдлын барагдуулалтын хувь -төрийн байгууллагуудын талаарх иргэдээс авсан судалгааны үр дүнг тооцсон байна . -ТББ-аар гүйцэтгүүлсэн ажлын тоо- 5	Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт 21,239 өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авснаас Засгийн газрын 11-11 төвд 625 өргөдөл утсаар, цахим хаягаар 58 өргөдөл, бичгээр 20,556 өргөдөл хүлээн авч шийдвэрлэж ажилласан. Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл мэдэгдэл 230, гомдол 515, санал 1220, байгууллагаас авах үйлчилгээ, иргэдээс гаргасан хүсэлт 19,274 бүртгэгдэж, холбогдох албан тушаалтанд хүргэгдэн шийдвэрлэж ажилласнаас 93,2 хувь буюу 19,794-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг өгсөн. Төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэхээр 4 ажилтан, 1 угтах үйлчилгээний ажилтан нийт 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр төрийн үйлчилгээний нэгдсэн “ХурДан” төвийг орон нутгийн төсвийн 121,0 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулж 2022 онд байгуулсан нь улсын хэмжээнд анхны орон нутагт “ХурДан” төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн аймаг болсон. ХурДан төв ашиглалтад оруулснаар төрийн цахим үйлчилгээ авах иргэдийн	90%

						тоо давхардсан тоогоор 41,415 болсон нь өмнөх жилүүдээсээ 2 дахин өсөлттэй байна. Мөн төрийн үйлчилгээний лавлах “call center” үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 2348 дуудлагад хариу өгч ажилласан.	
72	5.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.	5.3.1. Төрийн байгууллага хоорондын болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн солилцоог сайжруулж, төрийн үйлчилгээний цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	-	Цахим үйлчилгээний тоо Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн дагуу “албан бичиг солилцооны дундын систем” DOCX-ийг ERP системд нэвтэрсэн төрийн байгууллагуудад тус системийг бүрэн холбож ажилласан. Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 177 байгууллагыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд бүртгэсэн нь төрийн байгууллагын 98 хувьд нэвтрүүлсэн байна. Системийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр төрийн болон төрийн өмчит байгууллагуудын бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн ажилтан, хүний нөөцийн ажилтнуудад Цахим хөгжил харилцаа холбооны яам, "И-Монгол" академи УТҮГ-тай хамтран "ERP" системийн ашиглалтыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 19 удаагийн сургалтыг зохион байгуулан давхардсан тоогоор нийт 2400 албан хаагчийг хамруулсан. Төрийн 46 байгууллага албан хэрэгцээндээ лавлагаа мэдээлэл гаргах, албан бичиг цахимаар боловсруулах, төрийн сангийн нэгдсэн системд тайлан мэдээ хүргүүлэхээр 450 албан хаагч ашиглаж байна. Шинээр 41 байгууллага, 300 албан хаагч тоон гарын үсэг ашиглаж эхлэсэн нь өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн байна.	90%

					Аймгийн 15 төрийн байгууллагын 83 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлсэн. “ХурДан” төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, татварын хэлтэс, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийгмийн даатгалын газар, улсын бүртгэлийн газрууд цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг “e-mongolia.mn”, “e-halamj.mn”, “etax.mn”, “e-gazar.gov.mn,” “nd-daatgal.mn”, “burtgel.gov.mn”, “e-job.gov.mn” системээр дамжуулан төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж байна.		
73		5.3.2. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах, хянах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2025	-	Цахим хаягтай сум байгууллагын тоо	Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит нийт 57 байгууллага албан ёсны цахим хуудас ажиллуулж байгаа бөгөөд мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг тогтмол шинэчлэн олон нийтэд мэдээлсэн. Мөн нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй мэдээллийг Засгийн газрын shilen.gov.mn цахим хуудсан тогтмол байршуулж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж нээлттэй мэдээллүүдийг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлж dornogovi.gov.mn аймгийн цахим хуудас, фэйсбүүк хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нээлттэй байхаар заасан 5 төрлийн 98 заалтын дагуу цаг үе нөхцөл байдлын 63 видео мэдээг бэлтгэж 522,684 хандалт, 163 төрлийн фото мэдээг бэлтгэж 18,084 хандалт, аймгийн Засаг даргын 23 төрлийн баярын мэндчилгээг бэлтгэж 23,399 хандалт авсан.	90%

74	5.4. Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний хүртээмж, нөлөөг дээшлүүлнэ.	5.4.1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ.	2021 - 2025	-	Бэлтгэсэн хүний нөөцийн тоо	Аймгийн хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжлээр оюутан элсүүлж, сургалтын төлбөр, хөнгөлөлтийн талаар их, дээд сургуулиудтай гэрээ байгуулан хамтран ажиллалаа. СУИС-д дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж байгаа 9 оюутны сургалтын төлбөрийг төлж суралцах боломжоор ханган орон нутагт дутагдалтай байгаа боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Дээрх оюутнуудаас 1 суралцагч төгсөн ирж Сайншандын ЕБС-д дуу хөгжмийн багшаар ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2023 оны А/280 дугаар захирамжаар "Саран Хөхөө" театрын 1 хөгжимчин, 2 бүжигчнийг мэргэжил дээшлүүлэн суралцах боломжоор хангаж сургалтын төлбөрт 7,0 сая төгрөгийг зарцуулсан. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуульд энэ хичээлийн жилд шинээр элсэн орсон эх баригчийн ангийн 11, их эмчийн ангийн 3, эм найруулагчийн 16 нийт 30 оюутныг төгсөөд орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулан сургалтын төлбөр болох 23,0 сая төгрөгийг олгосон. Малын их эмчээр суралцаж байгаа оюутны судалгааг авч, Мал эмнэлгийн Их сургуулийн оюутнуудтай уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан 11 ажлын байрыг нөхсөн. Мөн Дорноговь аймгийн Нутгийн зөвлөлөөс жил бүр 2 оюутныг малын эмчээр сургадаг бөгөөд 2024 онд төгссөн 2 оюутан аймагтаа малын эмчээр ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 243 оюутныг төрийн байгууллагад дутагдалтай байгаа мэргэжлээр суралцах нөхцөл бололцоог хангаж, гэрээ байгуулан, төлбөрийг төлж, хөнгөлөлт үзүүлэн нийт 378.8 сая төгрөгийг зарцуулсан. Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон алба хаагчдыг чиглүүлэх сургалтад 48,	90%
----	---	---	-------------	---	-----------------------------	---	-----

						шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 65, дунд хугацааны давтан сургалтад 38, Мэргэжил дээшлүүлэх институтын богино хугацааны 11 удаагийн сургалтад 21, нийт 183 албан хаагчийг сургалтад хамруулж мэдлэг, мэргэшлийг дээшлүүлж ажилласан. Төрийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, ажлын байранд сургаж дадлагажуулах ажлыг тогтмол хийж нийт давхардсан тоогоор 15,343 албан хаагч хамрагдсан нь мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх үндэс болж байна.	
75		5.4.2. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг сайжруулан, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэшүүлж, чадавхжуулах тогтолцоог хөгжүүлэн хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	-	Сургалтад хамрагдсан албан хаагчийн хувь 85%, Хөтөлбөрийн тоо Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Засгийн Газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын шаардлага хангасан 31 төрийн захиргааны албан хаагчдад аймгийн Засаг даргын 2024 оны Б/39 дүгээр захирамжаар 263,2 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Аймгийн хэмжээнд 2019 оноос хойш төрийн албан хаагчийн цалин 3 удаа үе шаттайгаар нэмэгдсэн бөгөөд үндсэн цалин 568,000 төгрөгөөр, ЗГ-ын 2024 оны 82 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар олгож эхэлснээс 2,8 дахин нэмэгдсэн байна. Аймгийн Засаг даргын 2024 оны А/380 дугаар захирамжаар улсын төсвөөс санхүүждэг агентлаг байгууллагуудад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар олгож байна. Тус хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх,	100%

					цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог сайжруулах, ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр нийт давхардсан тоогоор 7,671 албан хаагчдыг хамруулж 3,3 тэрбум төгрөгийг зарцуулсан. Хөтөлбөр хэрэгжсэнээр тогтвортой төрийн алба бэхжиж, албан хаагчдын нийгмийн баталгаа тодорхой түвшнээр дээшилсэн. Орон нутгийн төсвийн 596,4 сая төгрөгөөр 14 сум, агентлаг, төрийн байгууллагуудад ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тавилга, техник хэрэгслээр хангах, стандартын шаардлага хангасан өрөө тасалгааны хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй орчинд ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн. Сайхандулаан сумын ЗДТГ-н барилгын гадаад дотоод их засварыг ОНТ-ийн 365,8 сая төгрөгийн хөрөнгөөр хийж ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 659,8 сая төгрөгөөр Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Эрдэнэ, Хөвсгөл сумдын Засаг даргын Тамгын газарт “BAIC BJ40” маркын суудлын автомашин, аймгийн Цагдаагийн газарт “Land cruiser-J200”, “BAIC BJ40” маркын автомашин, 227,5 сая төгрөгөөр багийн Засаг дарга нар болон 7 сумын хэсгийн төлөөлөгч, Сайншанд сумын 5 багийн хэсгийн байцаагч, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Даланжаргалан сумын Их нартын байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл сумын Цаг уурын станцад тус бүрт “Everst” маркын мотоцикль олгож хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, үүрэг
--	--	--	--	--	--

						гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэн үзүүлэн ажиллалаа. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт 866,1 сая төгрөгийн өртөгөөр 254 ширхэг dell маркын зөөврийн компьютер, 158,3 сая төгрөгөөр сумдад шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж олгож төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.	
76		5.4.3. Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний чанарыг ахиулж шинэ соёл төлөвшүүлнэ.	2021 - 2025	-	Албан даалгавар Сургалтын тоо	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлөөс тус хуулийн сургалтыг танхимаар 26 удаа зохион байгуулж 2,030 төрийн албан хаагч, цахимаар давхардсан тоогоор 4,060 төрийн албан хаагчдыг хамруулсан. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын дэргэдэх 107 ёс зүйн дэд хороог байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулсан бөгөөд 2024 онд ёс зүйн 3 гомдол хүлээн авч ажилласан байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр албан даалгавраар Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай чиглэлийг өгч хэрэгжилтийг жилд 2 удаа авч, дүгнэж ажиллаж байна. Албан даалгаварт 16 заалт тусгаж, жил бүр хагас жил, бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэдэг бөгөөд тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 89 агентлаг, 43 сумын хэрэгжилтийн тайланг АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүлээн авч, үнэлгээ өгч ажилласан.	50%
77	5.5. Хүний эрхийг хамгаалах чиглэлд иргэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийг	5.5.1. Бүх нийтийн оролцоог хангасан, үр нөлөөтэй, хариуцлагатай, чадварлаг бүтцийг бүх шатанд бий	2021 - 2025	- 80,0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	Аймгийн хэмжээнд нийт 647 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 96 хэрэг буюу 17.4 хувиар, 34822 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үе /25325/-тэй харьцуулахад 9497 буюу 37.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.	90%

	бэхжүүлж, оролцоог хангана.	болгож, иргэдийг аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлөөр хангана.					Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж сар бүр гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээг гаргадаг. Тус мэдээнээс үзэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн 479 буюу 26.0 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна. Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 15 ерөнхий арга хэмжээний хүрээнд 40 гаруй арга хэмжээг зохион байгуулж, гарын авлага, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлгийг нийт 33.000 гаруй ширхгийг иргэд олон нийтэд хүргэсэн. Мөн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д өөрчлөлт орсонтой холбоотойгоор архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарт өөрчлөлт орж согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг нэмэгдсэн талаар дүн шинжилгээг хийж аймгийн Засаг дарга холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрх хэмжээний хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" А/774 дүгээр захирамжийг батлан гаргаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон төрлөөр зохион байгуулах зорилгоор иргэд олон нийтэд орон нутгийн “DSB”, “DTV” телевизээр болон аймгийн Цагдаагийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд шуурхай хүргэж байна.	
78	5.6. Төрийн үйл ажиллагааны үйл ил	5.6.1. Шударга, хариуцлагатай	2021-2025	-	-	Төлөвлөсөн ажлын	Шударга, хариуцлагатай нийтийн албыг бэхжүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтныг	90%

	тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх замаар шударга ёсыг бэхжүүлнэ.	нийтийн албыг бэхжүүлж, төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, ил тод, нээлттэй байдлыг хангана.			хэрэгжилтийн хувь	авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оновчтой тодорхойлох ажлын хүрээнд агентлаг байгууллага болон сумдад сургалт, мэдээллийг тогтмол хийж хэвшсэн. Төрийн албан хаагчдад авлигын эрсдэлээс ангид байх үзлийг сурталчлах хүрээнд цахим хуудсаар дамжуулан нөлөөллийн аяныг тогтмол явуулж байна. Холбогдох хууль тогтоомжийн дагуу ХАСУМ, ХАСХОМ мэдүүлэх шаардлагатай албан хаагчдын мэдүүлгийг хугацаанд нь хүргүүлж байна. Тайлант онд авлигын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдсэн. Тус гэмт хэрэг нь авлига өгөхийг завдсан этгээдийг мэдээлснээрээ онцлог юм. Үүнээс харахад төрийн албан хаагчийн хариуцлага, ёс зүй нэмэгдсэн эерэг тал харагдаж байна.	
79		5.6.2. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021 2025	- -	Хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд аймгийн Засаг даргаас батлан гаргасан “Золбин нохой, муурыг хот, суурин газарт галт зэвсэг ашиглан устгах журам”, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар шинэчлэн тогтоох тухай” хэм хэмжээний актын төслүүдэд иргэдээс цахимаар болон танхимын хэлбэрээр санал хүсэлтийг авч ажилласан. Мөн аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавих, иргэдийн үзэл бодлыг тусгах хүрээнд иргэд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг зөвшилцлөөр оролцуулан ажиллаж байна. Иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад оролцуулснаар нийгэмд тулгамдаж буй асуудлыг төрийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөнд оновчтой тусгах сайн талтай.	90%

						Иргэдийг төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжоор хангах зорилгоор аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, агентлаг байгууллагууд цахим хуудсаараа дамжуулан үйл ажиллагаа тогтмол олон нийтэд хүргэж байна. Мөн shilen.gov.mn, tender.gov.mn, dornogovi.gov.mn зэрэг цахим хаягуудад иргэдэд шаардлагатай цахим мэдээллүүдийг тогтмол оруулж, мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж байна. Дээрх арга хэмжээний үр дүнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хандах иргэдийн итгэл нэмэгдэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх эерэг талуудтай.	
ЗУРГАА. ЗАСАГЛАЛ							
80	6.1. Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн экосистем бүхий газар нутгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	6.1.1. Аймгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, газар нутгийн хэмжээг 32 хувьд хүргэнэ.	2021 - 2025	-	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ га	Аймгийн хэмжээнд улсын тусгай хамгаалалттай нэр бүхий 15 газар 951171,03 га, нэр бүхий 117 газрыг 2720648,37 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын бүртгэлийн системд бүртгүүлсэн. Улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн 0.9 хувийг дархан цаазат газар, 53.44 хувийг байгалийн нөөц газар, 45.65 хувийг түүх соёлын дурсгалт газар тус тус эзэлж байна. Энэ онд Мандах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр “Агуйт” нэртэй газрын байгалийн нөөц газрын ангиллаар 9148.62 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал газрын тосны газарт бүртгүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 0,08 хувиар өссөн. Замын булаг, Хонгил цав, Бор өндөр, Хоёр зааны хөндий, Бор овооны тал зэрэг экологийн хувьд ач холбогдолтой газруудыг 122247 га талбайг тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн боловч ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай байна.	90%

						2019 онд тусгай хамгаалалттай 104 газар 3398861,02 га талбай, аймгийн нийт нутаг дэвсгэрийн 29,74 хувь, 2024 оны байдлаар 117 газар, 3671819,4 га талбайг аймгийн нутаг дэвсгэрийн 32.7 хувийг эзэлж байгаа нь 2019 оноос хойш тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2.51 хувиар өссөн байна.	
81	6.2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулна.	6.2.1. Хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, аж ахуйн эргэлтэд оруулна.	2021 2025	-	200,0	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь Тарьсан модны тоо, Нөхөн сэргээсэн газрын хэмжээ га, Ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох чиглэлээр 7 удаагийн сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 1745 гаруй иргэнд мэдээ мэдээлэл өгч, фэйж хуудас цахим сүлжээгээр видео шторк, постерийг 30 гаруй удаа цахим сүлжээгээр дамжуулан 16000 гаруй хүнд хүргэсэн. Нийтийн эзэмшлийн 93.01 га талбайд 12 төрлийн 220,376 ширхэг мод, 950 айл өрх, 279 аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшлийн газартаа 10 төрлийн 73,503 ширхэг модыг тарьснаар аймгийн хэмжээнд нийт 532,061 ширхэг мод, бут сөөгийг шинээр суулгаж, 545 аж ахуй нэгж, байгууллага, 5743 иргэд оролцон ногоон байгууламжийн хэмжээг 150 га талбайгаар нэмэгдүүллээ. Уг ажилд орон нутгийн төсөв болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 1,040.8 сая төгрөгийг зарцуулан 70 хувийн ургалттай байна. Аймгийн нутаг дэвсгэрт эвдэрсэн газрын тооллогын ажлыг аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Дорнын байгаль” ХХК-иар гүйцэтгүүлж, тооллогын урьдчилсан дүнгээр эвдрэлд орсон 77 байршилд 599.2 га талбай еис.mn цахим мэдээллийн санд бүртгэсэн. Тайлант онуудад нийт 143.8 га талбайд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нөхөн сэргээлт хийж ургамал сэргэн ургах боломжийг бүрдүүлсэн.	70%

						2024 онд 16 компани дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нийт 15.8 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	
82		6.2.2. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах арга хэмжээг хэрэгжүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.	2021 2025	-	18.4	Ангилж цуглуулсан хаягдлын хэмжээ, зарцуулсан хөрөнгө 22.5 тн, 18.1 сая 2022 тн, 18.4 сая	70%

Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй "Эко говь" үйлдвэртэй гэрээ байгуулан дахивар хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах чиглэлээр дэмжин нийт 55.5 сая төгрөгийн үнэ бүхий хуванцар нягтруулан шахах төхөөрөмж, гадна дотор камерын иж бүрдэл, цахилгаан жин, хуванцар хайлуулах төхөөрөмж, 40 тонны контейнер, хуванцар бутлагч төхөөрөмж зэрэг тоног төхөөрөмжүүдийг ашиглуулж байна.

Тус үйлдвэрийн гадна цахилгаан хангамжийг хүчин чадлыг нэмэгдүүлэх АТП дэд өртөө байгуулах, цахилгааны 380 вТ-д холбох ажлыг гүйцэтгүүлж улсын комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг хангасан. Үйлдвэрийн түүхий эдийн нөөц болох хог хаягдал болон дахивар ангиллын тухай ойлголт мэдээллийг ЕБС-уудын сурагчдад өгөх, сурагчдыг хогоо ангилах дадалд уриалах, хэвшүүлэх, сургууль бүрийг хогоо ангилдаг, дахивраа тушаадаг эко сургууль болоход чиглүүлэн дэмжих, сургууль тус бүрд дахивар ангиллын сав байршуулах зорилготой "Говийн эко сургууль төсөл"-ийг агаарын бохирдлыг бууруулах зардлаас 19,980,000 төгрөгөөс санхүүжүүлж, Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1, 2, 3, 5 дугаар сургуульд нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэхээр "Өгөх урлаг" НҮТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, төслийг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хүртэл үргэлжлэх хугацаатай байгуулсан.

Төслийн хүрээнд ЕБ-ын 4 сургуулийн 175 бүлэг, 6275 сурагч хамрагдсан байна. Тус үйлдвэр нь нийт 120 тн дахивар хог хаягдал цуглуулснаас 30 тн дахивар дахин боловсруулж хуванцар 125.2 тн,

						гялгар нийлэг-68тн, шил-64.5тн, цаас 50 тн, лааз 35.2тн нийт 322.9 тн дахивар хаягдлыг ангилан, цуглуулж Эко Говь үйлдвэр, Улаанбаатар хотын үйлдвэр, цехд нийлүүлсэн. Сайншанд, Замын-Үүд суманд хаягдал төмөр, лааз, зэс цайр гууль зэрэг хоёрдогч түүхий эд цуглуулдаг 8 иргэн ажиллаж хаягдал төмөр 500тн, зэс цайр, гууль, хөнгөн цагаан 50 гаруй тн нийт 550 тн хоёрдогч түүхий эдийг Улаанбаатарт тус тус нийлүүлсэн.	
83		6.2.3. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг аймгийн хэмжээнд үе шаттайгаар хийж, ашиглалтын зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 2025	-	50,0	Ургамал, амьтны тархац нөөцийн Судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ 13,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2022 онд төв суурин газрын ногоон байгууламж, Алтанширээ, Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайншанд сумын заган ойн хөнөөлт шавж тархалт, элбэгшил, баялаг, зүйлийн олон янз байдал, ойд шавжийн учруулах хөнөөл зэргийг тогтоож, шавж, модлог ургамлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах зөвлөмж боловсруулах зорилгоор “Эко бүтэц” ХХК-тай хамтран судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Судалгаагаар зарим сумын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, хамгаалалтын ойн зурвасын мод, бут, сөөглөг ургамлын талбайгаас 6 баг 23 овог 55 зүйлийн шавж илэрсэн. Шавжийн тархалт, хөнөөлийг тооцож үзэхэд навч, шилмүүсний хөнөөлийн гэмтэл 50 хувь, мод бутны төрөл зүйлээс хамаарч шавжийн тархалт ногоон байгууламж болон, хамгаалалтын ойн зурваст 10-80 хувь, таримал улиас, хайлаас модны шавжийн тархалт хамгийн өндөр 50 хувьтай гарсан. Судалгааны үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллага, сумдад хүргүүлэн 4 удаагийн зааварчилгаа өгч, энгийн механик, химийн	90%

					аргаар тэмцэж, нийт ногоон байгууламжийн 30 гаруй хувийг шавж устгалд хамруулаад байна. Хамарын хийдийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах биологийн олон янз байдлын суурь судалгааны ажлыг "Ховор амьтан судлах нийгэмлэг", "Их нартын хамгаалалтын захиргаа"-тай хамтран Хамарын хийд, Ханбаян зүрх хайрхан уул, Зоогийн хоолой, Хашаатын говь, зээгийн хөтөл нэртэй газруудад судалгааны ажлыг зохион байгуулж дууссан. Алтанширээ 1, Айраг 3, Даланжаргалан 3, Иххэт 4, Мандах 9, Өргөн 7, Сайншанд 3, Сайхандулаан 5, Улаанбадрах 8, Хатанбулаг 6, Хөвсгөл 7, Эрдэнэ суманд 6 нийт нэр бүхий 62 газрыг хамруулан уулын туруутан амьтдын судалгааны ажлыг зохион байгуулсан. Дээрх судалгаагаар 1700 гаруй аргаль хонь, 800 гаруй янгир бүртгэгдсэн.	
84	6.2.4. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог дээшлүүлнэ.	2021 - 2025	2,0	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Эрдэнэ, Өргөн сумдад "Тогтвортой зэрэгцэн оршихуй", "Биологийн олон янз байдлыг хамгаалах, хулгайн антай тэмцэх" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж 360 малчдад сургалт зохион байгуулж мэдээлэл өгсөн. Мөн "Биологийн олон янз байдлын ирээдүй сан", "Их нартын хамгаалалтын захиргаа"-тай хамтран "Байгаль программ", "Зэрлэг амьтдын судалгааны арга зүй" сэдэвт сургалтыг 14 сумын байгаль орчны мэргэжилтэн, Хатанбулаг, Хөвсгөл, Мандах, Улаанбадрах, Өргөн, Эрдэнэ сумдын Засаг даргын орлогч, цагдаагийн төлөөлөгч нарт, "Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг Монгол дах төлөөлөгчийн газар"-аас "Зэрлэг амьтдын хууль бус ан, тэдгээрийн газартай түүхий эд эрхтэн, бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх	90%

					төсөл"-ийн хүрээнд хөдөлгөөнт баг буюу Хатанбулаг,Хөвсгөл, Мандах, Улаанбадрах, Өргөн, Эрдэнэ сумдын Засаг даргын орлогч, цагдаагийн төлөөлөгч, байгаль орчны мэргэжилтэн, Сайншанд суманд байрлах хамтарсан багийн гишүүдэд хууль эрх зүй, эргүүл хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалтад давхардсан тоогоор 80 хүн зохион байгуулсан. "Саран хөхөө театр"-ын хамт олонтой хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад байгаль орчныг хамгаалах усны зүй зохистой хэрэглээг дадал болгох, экологийн боловсрол олгох зорилгоор "Чандмань эрдэнэ" сэдэвт хүүхдийн жүжиг бэлтгэж 3000 хүүхэд багачуудад толилуулсан байна. Энэ онд давхардсан тоогоор 4140 хүнд сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 93822 иргэн цахим орчинд мэдээлэл хүргэсэн байна. "Тогтвортой зэрэгцэн оршихуй", "Мод тарих, арчлан хамгаалах", "Зочлох үйлчилгээний стандарт", "Усны зохистой хэрэглээ", "1000 сургагч багш бэлтгэх" зэрэг сургалтуудад давхардсан тоогоор 700 гаруй иргэн оролцож, "Биологийн олон янз байдлыг хамгаалах, хулгайн антай тэмцэх", "Амьтны экологи эдийн засгийн үнэлгээ", "Хамарын хийд", "Их нартын байгалийн нөөц газар", "Бүрдэнэ булаг"-ийн танилцуулга зэрэг цахимд мэдээллийг 93822 хүн үзэж сонирхсон байна.		
85		6.2.5. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан	2021 - 2025	1,0	Хүргэсэн мэдээний тоо	Онцгой байдлын ерөнхий газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Хүнс хөдөө аж ахуйн газраас анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг хүлээн авч, малчид, иргэдэд шуурхай хүргэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, орон нутгийн телевиз, радио, цахим хаяг, "Масс мессеж" үйлчилгээгээр дамжуулан хүргэж, Цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг боловсруулан малчид ард	90%

		мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.				иргэдэд www.dornogovi.tsag-agaar.gov.mn , www.alarm.tsag-agaar.gov.mn цахим хуудас болон Дорноговь цаг агаар, орчны мэдээ мэдээллийн фэйсбүүк хуудсаар дамжуулан хүргэж хэвшсэн. 2024 оны 11 сарын байдлаар цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээг 16 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 25 удаа, урьдчилан сэргийлэх мэдээг 2 удаа, dornogovi.tsag-agaar.gov.mn цахим хуудсанд хагас хоног болон 1-5 хоног, хоногийн тойм мэдээг өдөр бүр байршуулан хэрэглэгчдэд хүргэж ажиллалаа. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2021 онд 10 удаа, 2022 онд 7 удаа, 2023 онд 9 удаа, 2024 онд 4 удаа зохион байгуулж зориудаар хурын усыг нэмэгдүүлсэн. 2021-2024 онуудад байгаль цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах мэдээг 62 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 88 удаа, урьдчилан сэргийлэх мэдээг 9 удаа боловсруулан ард иргэдэд шуурхай дамжуулан ажиллаж байна.		
86	6.3. Усны нөөцийн бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна.	6.3.1. Усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолоос сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.	2021 2025	-	-	Арга хэмжээний тоо	Сайншанд сумын нутаг дэвсгэрийн усан хангамжийн эх үүсвэр болох Зээгийн хөтлийн газрын доорх усны ордын тэжээгдлийн мужийг усан сан бүхий байгалийн нөөц газрын ангиллаар 5817.45 га талбайг аймгийн тусгай хамгаалалтад, Алтанширээ сумын Хайлсан шанд, Холбоогийн уул, Баянбуурал нэртэй 28476.23 га газрууд нийт 4 байршил газрын 34293.68 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлд бүртгүүлсэн. Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуй бүс, ус хангамжийн эх үүсвэрүүдийн тэжээгдлийн мужийн зааг, зураглал,	90%

						холбогдох мэдээлэл, судалгааг шинэчлэн тогтоож 13 сумдын нутагт 69 булаг, 84 нуур тойром, 1 гол ашигт малтмалын ашиглалтын 27, хайгуулын 40 тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай байгааг гаргаж Усны тухай хуулийн 22 дугаар зүйл, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хүрээнд тусгай зөвшөөрлийн талбайгаас хэсэгчлэн хасах тухай мэдэгдлийг 67 компанид хүргүүлсэн. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрт тогтоох онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Сумдад усны сан бүхий газар ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, түүний ойр орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажилд 200 ААНБ, 3500 иргэн, ажилтан, албан хаагчид оролцон 2500,0 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 29 автомашин техник хэрэгслээр 470,0 тонн хог хаягдлыг цэвэрлэж эх үүсвэрийг бохирдохоос сэргийлсэн.	
87		6.3.2. Сумдын ундны усыг чанарын шинжилгээнд хамруулж, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага	2021 - 2025	100,0	Шинжилгээнд хамруулсан худгийн тоо, Цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан худгийн тоо Усаар хангагч байгууллагын 20	Хүн амын ундны усны чанар стандартыг сайжруулах ажлын хүрээнд 2021-2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200,0 сая төгрөг, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 320,0 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 345,0 сая төгрөг, ААНБ-ын санхүүжилт 250,0 мянган төгрөг нийт 865,2 сая төгрөгийн санхүүжилтээр 14 сумдын 16 худагт ус цэвэршүүлэх төхөөрөмжтэй суурилуулснаар аймгийн хэмжээнд нийт 25 цэвэршүүлэх төхөөрөмжтэй худгаас иргэд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангагдаж байна.	90%

		хангасан ундны усаар хангана.				Дэлгэрэх суманд үйл ажиллагаа явуулдаг “Дэртийн булаг” ХХК-ийн 250,0 мянган төгрөгийн санхүүжилтээр тус сумын хүүхдийн цэцэрлэгийн 1 худагт бага оврын ус шүүх төхөөрөмж, Улаанбадрах суманд аймаг, орон нутгийн төсвийн 240,0 сая төгрөгийн хөрөнгөөр тус сумын 2 дугаар багийн Хонгор, Цэвүүн нэртэй 2 худаг, 3 дугаар багийн Наймаа, Гүнсухайт нэртэй 2 худаг нийт 4 ус хангамжийн эх үүсвэрийн худгуудад ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх, усны хатуулаг, хүнцэл бууруулах төхөөрөмж суурилуулах, худгийн барилга байгууламж барих ажлууд 426.6 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус хийгдсэн. Хүн амын ундны усны эх үүсвэрийг шинжилгээнд хамруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, усны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор 14 сумын унд ахуйн хэрэглээний давхардсан тоогоор 95 цэгээс дээж авч, Мэргэжлийн хяналтын лабораторид 82, Улаанбаатар хотын Геологийн төв лабораторид 6 дээж, Ханлаб лабораторид 7 дээжийг шинжлүүлсэн.	
88		6.3.3. Умард говийн гүвээт-Халхын дундад тал, Галба-Өөш-Долоодын говийн сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг сайжруулна.	2021 2025	-	Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг 2021 онд 4, 2022 онд 4, 2023 онд 10, 2024 онд 6 худагт шинээр тогтоож хашаажуулж, тэмдэгжүүлэх ажил хийгдэж тус ажил 100 хувийн хэрэгжилттэй байна. Эрүүл мэндийн яамны санаачилгаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр аймгийн "Ус, ариун цэврийн аюулгүй байдлыг ханган ажиллах нэгдсэн төлөвлөгөө" боловсруулж, жишиг загвар боловсруулах ажлыг Зөвлөх багийн бүрэлдэхүүн АШУУИС, ШУТИС багш нар, Хотын ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл, Ус сувгийн удирдах газар, Монголын нийтийн аж ахуйн үндэсний холбоо зэрэг байгууллагаас Зөвлөх, мэргэшсэн инженер,	90%

					төсөвчин, эрүүл ахуйч нарын 8 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж төлөвлөгөө боловсруулалт 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Өргөн, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн худгийн хамгаалалтын бүстэй 239 газар давхцалтай байгаа тул давхцалыг арилгуулах ажлыг сумдын Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумдад усны сан бүхий газар ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, түүний ойр орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажилд 200 ААНБ, 3500 иргэн, ажилтан, албан хаагчид оролцон 2500,0 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 29 автомашин техник хэрэгслээр 470,0 тонн хог хаягдлыг цэвэрлэж эх үүсвэрийг бохирдохоос сэргийлсэн.	
89	6.3.4. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах боломжийг судалж хэрэгжүүлнэ.	2021 – 2025	-	Гүйцэтгэлийн хувь	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388/3713 төсөл”-ийн хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын төвд хоногт 3000м3 чадал бүхий бохир ус цэвэрлэх байгууламжийг 6350.8 сая төгрөгийн санхүүжилтээр “Компорт импекс” ХХК гүйцэтгэж, 2022 оны 07 сард байнгын ашиглалтад оруулсан. Тус цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг нь механик, биологи, гүйцэд цэвэрлэгээний технологитойгоор хийгдэж цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой хийж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор Сайншанд хотын дэд бүтцийг хөгжүүлэх, оршин суугчдын тав тухтай амьдрах орчныг нэмэгдүүлэх, орон нутгийн байгаль орчныг сайжруулж, хөрсний	50%

						бохирдлыг бууруулах, цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах боломж бүрдсэн. Дорноговь аймаг, Япон улсын Шизүока муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд саарал усыг дахин ашиглах боломж, инженер техникийн ажилчдыг бэлтгэх, сургаж дадлагажуулах, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулж байна.		
ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ								
90	7.1. Орон нутгийн батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, нийгмийн аюулгүй байдлыг хангана.	7.1.1. Зэвсэгт хүчний жанжин штабаас өгөгдсөн хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хамруулах хяналтын тооны хувийг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	3,3	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	“Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулийн болон Политехникийн коллежийн оюутнуудыг “Цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна. Хяналтын тоог 100 хувь биелүүлсэн. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 144, 441 дүгээр тогтоолоор “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам”-ийн дагуу сумдын цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс “Залуучуудын эрүүл мэндийн өнөөгийн байдал” сэдвээр сургалтыг зохион байгуулан цэргийн насны залуучуудын эрүүлжүүлэх ажлыг 2024 оны 06 дугаар сарын 15 -аас 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсан. 2024 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний Жанжин Штабаас тогтоосон тоон даалгаврыг Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн анги салбарын хугацаат цэргийн алба хаагчаар 100% биелүүлэн ажилласан. 2024 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцсэн иргэдийн тоо 1,3 хувиар өссөн.	100%
91		7.1.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж,	2021 2025	-	3,2	Төлөвлөсөн бүрэлдэхүүний хамрагдалтын хувь	Сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоог 2023 оны 1 дүгээр сард цэргийн тоо бүртгэлтэй уялдуулан, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагатай хамтатган тодотгосон бөгөөд сумдын нууц баримт	90%

		дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.			бичиг газрын зураг, төлөвлөгөө тэдгээрийн хамгаалалтын байдалд үзлэг хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн хамгаалалтын сургалтад ашиглах материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор зөөврийн компьютер 1 ком, цахилгаан үүсгүүр зэрэг тоног төхөөрөмжөөр хангасан. Дайчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын мн/21 дүгээр тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.3.10 дахь заалт, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын стратегийн 600/02 удирдамжийн дагуу “Зэвсэгт хүчний ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах” төлөвлөгөөнд тодотгол хийж, дайчилгааны даалгавраар оногдуулан бүртгэсэн цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн нэрийн жагсаалт, тооцооны хуудсыг анги, командаар нь, авто техникийг марк, зориулалт, улсын дугаар, техник оногдуулан бүртгэх карт, жолоочийн нэрийн жагсаалтыг анги, командаар нь гарган тодотгож актыг тогтоосон хугацаанд ЗХЖШ-т хүргүүлсэн. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор орон нутгийн хамгаалалтын сургалтыг цэргийн штабын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд оруулан хэрэгжилтийг хангах зорилгоор Батлан хамгаалахын сайдын А/110 тоот тушаал, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын Н/93 тоот тушаал, аймгийн Засаг даргын А/770 дугаар захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийг 2024 оны 11 дүгээр сарын 10-аас 17-ны өдрүүдэд зохион байгуулсан.	
--	--	---	--	--	---	--

						Сургалтад аймгийн 14 сумын 100 цэргийн бэлтгэл үүрэгтэн 14 нэгж техникийг оролцуулсан. Дайчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 , 9.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.33 дахь заалтын дагуу Дорноговь аймгийн Улсын дайчилгааны төлөвлөгөөг аймгийн эдийн засаг нийгмийн 2023 оны үзүүлэлтүүдэд тулгуурлан шинэчлэн боловсруулж, Батлан хамгаалах яаманд энэ оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн.	
92	7.2. Хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилийн торон саадыг шинэчлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	7.2.1. Хилийн ангиудыг орчин үеийн техник хэрэгслээр хангах, хилийн торон саадыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2025	240.0	Хил хамаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт	Хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд тайлант онд нийт 652,0 сая төгрөгийн дэмжлэгийг хилийн цэргийн ангиудад олгосон. Хилийн 0129 дүгээр ангийн Таван толгой хилийн харуулын байрыг шинээр барих, 10 кВт -ын ЦДАШ татах, хилийн 0168 дугаар ангийн мөр хянах зурвас татах, гүний худаг гаргах, ус цэвэршүүлэгч тавих алба орон сууцанд урсгал засвар хийх, улсын хил хамгаалалтыг удирдах “Удирдлагын төв”-ийг шинээр тохижуулах, шуурхай удирдлагын төв, номын сан, алжаал тайлах өрөө, соёл амралтын танхим, хүүхэд хөгжлийн өрөөг засварлах, хилийн цэргийн салбаруудын орон сууцны засварын ажил болон 0143 дугаар салбарын хариуцсан хэсгийн 10 км газарт инженерийн торон саадыг хийх, хилийн 0108 дугаар ангийн орон сууцны барилгын их засвар хийх, 2 салбарын хилчдийн байрыг засварлах, инженерийн байгууламж, өргөст утсан хашааг сэргээн засварлах, эргэлтийн цэг тэмдэгжүүлэх зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.	90%
93		7.2.2. Хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	2021 - 2025	10,0	Дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	Хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд тайлант онд нийт 652,0 сая төгрөгийн дэмжлэгийг хилийн цэргийн ангиудад олгосон. Хилийн 0129 дүгээр ангийн Таван толгой хилийн харуулын байрыг шинээр барих, 10 кВт -ын ЦДАШ татах, хилийн 0168 дугаар ангийн мөр хянах зурвас татах, гүний худаг гаргах, ус цэвэршүүлэгч тавих	100%

						алба орон сууцанд урсгал засвар хийх, улсын хил хамгаалалтыг удирдах “Удирдлагын төв”-ийг шинээр тохижуулах, шуурхай удирдлагын төв, номын сан, алжаал тайлах өрөө, соёл амралтын танхим, хүүхэд хөгжлийн өрөөг засварлах, хилийн цэргийн салбаруудын орон сууцны засварын ажил болон 0143 дугаар салбарын хариуцсан хэсгийн 10 км газарт инженерийн торон саадыг хийх, хилийн 0108 дугаар ангийн орон сууцны барилгын их засвар хийх, 2 салбарын хилчдийн байрыг засварлах, инженерийн байгууламж, өргөст утсан хашааг сэргээн засварлах, эргэлтийн цэг тэмдэгжүүлэх зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.		
94	7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	7.3.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, бэлэн байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулна.	2021 2025	-	30,0	Гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээ хийлгэсэн сумын тоо	Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 5 удаа Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссын болон Шуурхай штабын хурлыг 78 удаа зохион байгуулж, цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан, шийдвэр, хурлын тэмдэглэл-156, аймгийн Засаг даргын захирамж-145, албан тоот-81 удаа гаргаж, гамшигтай тэмцэх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг тухай бүр авч ажилласан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 70 дугаар тогтоолоор Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, 2021-2024 оны орон нутгийн төсөвт нийт 3.1 тэрбум төгрөгийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд тусган зарцуулав. Мөн Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг 8 суманд, Команд штабын сургуулийг 5 суманд, Бэлэн байдлын үзлэгийг 7 суманд тус тус зохион байгуулж, тухайн сумдын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.	100%

						“Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”, “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль”-ийг жил бүрийн 03 дугаар сард зохион байгуулж, нийт 14 сумын 96 аж ахуй нэгж, давхардсан тоогоор 29332 ажилтан, алба хаагч, иргэнийг хамруулав. Тус аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд “Ковид-19” цар тахлын эрсдэлийн үнэлгээ-28, зудын эрсдэлийн үнэлгээ-9, шар усны болон уруйн эрсдэлийн үнэлгээ-1, үерийн эрсдэлийн үнэлгээ-6, гангийн эрсдэлийн үнэлгээ-7, нийт 45 удаа гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, онц аюултай объектод хийгдсэн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний 48 тайланд холбогдох журам, зааврын дагуу анхан шатны шинжилгээ хийж ажилласан.	
95		7.3.2. Гамшгийн эрсдэлд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын бэлэн байдлыг хангаж, оролцоог нэмэгдүүлнэ.	2021 2025	-	3,0	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо Тайлант хугацаанд Дорноговь аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг-2 удаа Зөвлөлийн гишүүдийн 90%-ийн ирцтэйгээр хуралдуулсан. Тус хурлуудаар Зөвлөлийн 2022-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Улсын хэмжээнд 2023 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан “Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” стратегийн команд штабын сургууль, мөн оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан “Эрсдэл ба стандарт” форумд тус аймгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 200 гаруй алба хаагч оролцсон. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран “Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “онц байдал”	90%

						тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулж, тус дадлага сургуульд аймгийн Засаг даргын 2023 оны "Ажиллагааны удирдлагын төв байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай" А/351 дүгээр захирамжаар байгуулагдсан, давхардсан тоогоор 103 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээр оролцож, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд байрлан, өгөгдсөн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан. “Дэлхийн зөн Монгол” ОУБ-аас хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийн хүрээнд Иххэт, Хатанбулаг, Сайншанд сумдад олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, үнэлгээнд тулгуурлан, нийт 151,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, мөнгөн дэмжлэгийг олгоод байна.	
96	7.4. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	7.4.1. Дэвшилтэт технологийн камержуулалтын нэгдсэн системийг нэмэгдүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна.	2021 - 2025	10,0	Нэмэгдүүлсэн болон засаж сэргээсэн камерийн тоо Зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 14/02 тоот тогтоолоор Сайншанд, Замын-Үүд сумдад камерын хяналт, удирдлагын нэгдсэн системийг 101 байршилд 278 камер шинээр нэвтрүүлэхээр 2,1 тэр бум төгрөгийг төсөвт тусган шийдвэрлэсэн. Энэ хүрээнд 1,3 тэрбум төгрөгөөр Сайншанд суманд 63 цэг байршилд 163 камер байршуулж, "Камерын хяналтын дэд төв"-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулахаар ажиллаж байна. Замын-Үүд суманд 38 байршилд 115 камерыг байршуулж, шилэн кабелин өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%

						2023 оны байдлаар Сайншанд суманд 39 цэгт 68 чиглэлийн камер байсан бол 2024 оны байдлаар 102 цэгт 263 чиглэлийн камер ажиллаж байна. Цагдаагийн ерөнхий газраас 2023 онд эхлүүлсэн "Ногоон бүс" аяны хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд MNS6423:2019 стандартад нийцсэн камерын системээр тоноглогдсон, барилга байгууламжийн гадна гэрэлтүүлэг нь ойр орчимд байгаа эд зүйл харагдах, камерын бичлэгт орж байхаар гадаад орчны аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Тус аяны хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 1184 аж ахуйн нэгжийг бүртгэлд судалгаанд авч Цагдаагийн ерөнхий газрын камерын мэдээллийн цахим санд бүртгэлжүүлэн ажилласан.	
97		7.4.2. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргаж, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	2021 - 2025	30,0	Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь, Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2024 оны 10 дугаар сарын байдлаар нийт бүртгэгдсэн 715 гэмт хэргийн 3.9 хувь буюу 28 нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг эзэлж байна. Харин хүүхдийн эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй боловч эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналт сул, хүүхдээ үл хайхрах, асран хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа, боловсролын байгууллагаас тэдэнд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохиодоггүй зэрэг нөхцөл байдлаас хүүхэд өртөж хохирсон болон хүүхэд холбогдсон гэмт хэрэг гарч байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт дүн шинжилгээ хийхэд ихэвчлэн согтуугаар үйлдэгдэж байх тул Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн зохицуулалт, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хосуудын харилцан ойлголцол, бат бэх байдлыг дэмжих, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлээр иргэдэд чиглэсэн 78 удаагийн	90%

						сургалт зохион байгуулж давхардсан тоогоор нийт 30.000 гаруй иргэнийг хамруулсан. Харин хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдад тухай бүр албан даалгавар, чиглэлийг хүргүүлж “Сурагчдын дотуур байр”, “Хамтдаа сэргийлье”, “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдөр”, “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”, “Хайр хязгааргүй-ялгаагүй” зэрэг соён гэгээрүүлэх 50 гаруй арга хэмжээг санаачлан зохион байгуулсан . Тус арга хэмжээнүүдийн хүрээнд 2,000 хүүхдийн санал, хүсэлтийг авч, хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж байна. Үүнээс дурдвал хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж стандартын шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүнийг хураах, устгах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлага, зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Мөн насанд хүрээгүй хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийн дээрэлхэлд, утаат болон электрон тамхины хор уршиг, цахим орчны зөв зохистой хэрэглээ, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 3600 гаруй ерөнхий боловсролын сургуулийн сурагч, 20,000 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нийт 9400 гаруй нийт иргэнд мэдээлэл хүргэж ажилласан.	
98		7.4.3. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэн,	2021 - 2025	20,0	Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь, Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Аймгийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхээр “Соёлтой жолооч” арга хэмжээг зохион явуулж, гар утасны дугаар бичигч, постер зурагтай карт, соёлтой жолооч бичиглэл хэвлэж тээврийн хэрэгслүүдийн арын салхины шилэнд, 2 төрлийн постер хэвлэж, гудамж замд анносыг байршуулсан. Энэхүү арга	70%

		замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн ослыг бууруулна.			хэмжээний хүрээнд санамж сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас 1200 ширхэг хэвлэж, жолооч зорчигч нарт тараасан. Мөн “Нэг зам-Нэг соёл” ухуулга нөлөөллийн аяныг 2023 оны 06 сарын 30-аас 08-р сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулж, жолооч зорчигч нарт 6500 ширхэг санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж тараан өгсөн. Босоо тэнхлэгийн зам дагуу нутагладаг малчдад урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, Замын цагдаагийн болон сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар 815 тооны бод малыг хүзүүвчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Сайншандаас-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто замд “НОЙР СЭРГЭЭГЧ” 3D цагаан шугамыг нийт 180 гаруй сая төгрөгөөр 12 цэгт байрлуулсан. Хяналт шалгалтын чиглэлээр “Уусан бол бүү жолоод” нэгдсэн хяналт шалгалтыг 21 удаа зохион байгуулж ажилласан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 21 байгууллагын 1200 гаруй албан хаагчдад “Зам тээврийн осол гэмт хэрэг, зөрчлийн статистик тоо мэдээ, осол хэргийн шалтгаан нөхцөл, зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар”, Аюултай ачаа тээвэрлэх журам, Тусгай дуут дохио хэрэглэх мөн “Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан. Бага насны хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцуулах дадал эзэмшүүлэх зорилгоор давхардсан тоогоор нийт 2,800 гаруй хүүхдэд сургалт, мэдээлэл өгч ажилласан.	
--	--	---	--	--	--	--

						Осол гэмтлийн өвчлөл 2024 оны эхний 10 сарын өссөн дүнгээр 2562 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 93 тохиолдлоор буюу 10000 хүн амд 357.7 болж 11.2-оор буурч, харин осол гэмтлийн шалтгаант нас баралт 65 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11 тохиолдлоор буурсан байна.	
99		7.4.4. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг эрчимжүүлнэ.	2021 2025	-	20,0	Зохион байгуулсан сургалт, хэмжээний арга тоо, хамрагдсан иргэдийн өсөлтийн хувь, Зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Мэдлэгтэй хүүхэд”, “Хүүхэд хамгаалал”, “Уусан бол бүү жолоод”, “Албаны тээврийн хэрэгсэл”, “Нэг цагдаа нэг айл өрх”, “Сургууль орчмын бүс”, “Эргүүл хяналт”, “Цахим залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Мотоцикл”, “Ослын тэмдэг”, “Айдасгүй алхам”, “Хүн бүр байгаль хамгаалагч”, “Цахим орчны эрсдэл, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Хүний эрүүл мэнд халдашгүй байдал”, “Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Архины хор уршгийн сөрөг нөлөө”, “Хүр хүйн тухай ойлголт”, “Та татгалз”, “Анзаар” зэрэг 161 удаагийн сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 172 гадагшаа чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан. Зохион байгуулсан сургалт, мэдээлэл, уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг, уралдаан тэмцээнүүдэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн 9470, хувиараа хөдөлмөр эрхлэгч 2400, малчин 2025, оюутан 1320, сурагч 7783, ажилгүй 672 иргэд хамрагдаж 171 төрийн байгууллага, 115 төрийн бус, хуулийн тэгээд 2, их дээд сургууль МСҮТ 4, ерөнхий боловсролын давхардсан тоогоор 82, цэцэрлэг 44, нийт давхардсан тоогоор 30,000 гаруй иргэн хамруулсан. Шинээр гарсан эрх зүйн актыг сурталчлах, таниулах ажлыг тогтмол зохион байгуулж төрийн албан хаагч, иргэд, олон нийтэд танхим болон цахим хэлбэрээр хүргэн ажиллаж байна.	90%

						Тайлант хугацаанд 20 гаруй хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 89,000 гаруй иргэд болон төрийн албан хаагчдыг хамруулсан байна. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд иргэдийн эрх зүйн боловсрол дээшилж, өөрт хэрэгцээ шаардлагатай хууль тогтоомжийг судлах, эрхээ хамгаалуулах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.	
100	7.5. Хууль сахиулах салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулна.	7.5.1. Салбарын барилга байгууламжийг шинээр барих, засвар шинэчлэлт хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2025	60,0	Дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	Хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор санхүүгийн дэмжлэгийг үзүүлж хилчдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн 2020 онд Цагдаагийн газарт 11 автомашин, 10 мотоцикль нийт 21 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийснээс гадна олон нийтийн цагдаа болон эргүүлийн цагдаад энгэрийн камер, зөөврийн хурд хэмжигч, богино долгионы гар станц, зөөврийн компьютер, зөөврийн принтер, согтуурлын зэрэг шалгагч багаж, GPS байршил тогтоогч төхөөрөмж зэргээр хангахад дэмжлэг үзүүлэн хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсооход дэмжлэг үзүүлэн ажилласан. Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлснээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 15/08 дугаар тогтоолоор Цагдаагийн кобаны барилгын их засварын ажилд 154.0 сая төгрөг төсөвлөсөн. Засварын ажлын сонгон шалгаруулалтад "Мунара констракшн" ХХК шалгарч гэрээ байгуулж засварын ажлыг 98 хувийн гүйцэтгэлтэй хийж байна. Мөн нэмэлтээр цэвэр, дулааны шугам солих ажил бүрэн хийгдсэн.	90%

101		7.5.2. Төрийн архивыг стандартын шаардлагад нийцсэн зориулалтын байртай болгож, үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангана.	2021 2025	-	20,0	Барилгын ажлын гүйцэтгэл Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт	“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн барилга барихтай холбогдуулан Төрийн архивын байрыг хамт байлгахаар шийдвэрлэсний дагуу 2023 оны төсөвт барилгын зураг төсөл зохиох төсвийг тусгасан. Төрийн архивт хадгалагдаж буй 53000 гаруй цаасан суурьтай баримтыг 2 хадгаламжийн санд зориулалтын нягтруулсан шүүгээнд байрлуулан хадгалж, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/47 дугаар тушаалаар батлагдсан “Архивын зориулалтын барилга” MNS 6929:1:2021 стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг. Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд мэдээлэл лавлагаанд өргөн ашигладаг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил үе шаттай хийгдэж байна. 2024 оны байдлаар 24 дансны 15 хөмрөгийн 223 хадгаламжийн нэгжийн 19840 хуудаст холболт хийж 19844 заалт 63113 хүний нэр 296 байгууллагын нэр шивж мэдээллийн сан үүсгэсэн. Мөн 30 дансны 795 хадгаламжийн нэгжийн 66530 хуудас баримтыг сканердаж фотошоп программаар засаж ашиглалтын хувь үйлдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Архиваар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор архивын ажилтнуудын өрөө, уншлагын танхимд 19,8 сая төгрөгөөр их засварын ажил хийж, төрийн архивын аюулгүй байдлыг хангах зорилгоор дохиолол хяналтын камерын систем суурилууллаа. Архивын сан хөмрөгийн болон ажилчдын өрөө, уншлагын танхимд нийт 10 ширхэг хяналтын камер, 5ш утаа мэдрэгчийг 5,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	90%
-----	--	---	--------------	---	------	--	---	-----

НАЙМ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

102	8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.	8.1.1. Сайншанд - Баруун-Урт - Хөөт, Зүүнбаян - Ханги чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	2021 2025	-	-	Арга хэмжээний тоо	Зүүнбаян - Ханги чиглэлийн 226 км төмөр замын барилга угсралтын ажил хийгдэж 2022 онд ашиглалтад орсон. Сайншанд - Баруун-Урт – Хөөт чиглэлийн 416км төмөр зам барих ажлын ТЭЗҮ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, зураг төсөв боловсруулах ажлыг “Монголын төмөр зам” ТӨХК хариуцан гүйцэтгүүлж байна. Боомтын сэргэлт төслийн хүрээнд хийгдэж буй Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашиг малтмал ашиглах зөвшөөрлийг нийт 232 байршилд аймгийн Засаг даргын 2022 оны А/204, А/369, А/624 тоот захирамжаар олгож дэмжлэг үзүүлж ажилласан.	90%
103		8.1.2. Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	Хятад Ард Улсын Засгийн газрын 201 сая юань (75 тэрбум төгрөг)-ийн буцалтгүй тусламж	Гүйцэтгэлийн хувь	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжаар Замын-Үүд боомтыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил хийгдсэн. Зорчигч тээврийн цогцолборын 30 барилга байгууламж, зам талбай, гадна инженерийн шугам сүлжээний ажлыг 2023 оны 1-р сард, ачаа тээврийн цогцолборын 28 барилга байгууламж, зам талбай, гадна шугам сүлжээний ажлыг 2023 оны 10-р сард тус тус улсын комисс ашиглалтад хүлээн авсан. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ариутгал халдваргүйтгэлийн барилга, Шатамхай бодисын агуулах, Анхны тусламжийн байр, Боомтын хяналтын бүсийн хашаа болон хаалга, Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байрны барилга, байгууламжуудыг байнгын	90%

						ашиглалтад хүлээн авах улсын комисс 2024 оны 09 дүгээр сард ажилласан. Эдгээр бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэнээр боомтын нэвтрэх чадвар нэмэгдэх боломж бүрдсэн.	
104		8.1.3. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	-	Ухаалаг технологи нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн тоо Сайншанд сумын төвийн 3 чиглэлд, Замын-Үүд сумын төвийн 3 чиглэлд тус бүр хот доторх нийтийн тээврийн үйлчилгээг өвөл, хавар, намрын улиралд үзүүлж хэвшсэн. Уг үйлчилгээнд давхардсан тоогоор Сайншанд суманд нийт 42600 гаруй, Замын-Үүд суманд нийт 12800 гаруй зорчигчид аюулгүй ая тухтай зорчих нөхцөлөөр хангасан. Сайншанд суманд нийтийн тээврийн үйлчилгээнд гарч буй 3 автобусанд GPS, түлш хэмжигч төхөөрөмж суурилуулан хяналт тавин ажиллаж байна. Мөн Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад хүрч ажиллах зорилгоор орон нутгийн төсвийн 264,9 сая төгрөгийн санхүүжилтээр 45 хүний суудалтай 6 автобусыг худалдан авч 2024 оны 11-р сарын 15-аас нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж эхэлсэн.	90%
105	8.2. Орон нутгийн онцлог бүхий байгальд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	8.2.1. Аймгийн аялал жуулчлалын төлөвлөгөөг хэрэгжүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	2021 2025	-	15,0	Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, жуулчдын тоо Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13/09 дүгээр тогтоолоор "Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө"-г батлуулж, 4 зорилт 21 үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж 70 хувийн биелэлттэй ажилласан. Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Зочлох, үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв” ТББ, “Монголын зочлох үйлчилгээний гэр холбоо” ТББ-ууд хамтран зочид буудал, зоогийн газар, дэн буудал, жуулчны баазын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад зориулж “Ковидийн дараах борлуулалтын хэв маяг” сэдэвт сургалтыг 2021 онд, 2022-2023 онд аялал жуулчлалын бизнес	70%

					эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 2 удаагийн хэлэлцүүлэг, 3 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 120 гаруй хүн хамрагдаж, сургалтын үр дүнд үйлчилгээгээ сайжруулсан. Байгаль орчныг хамгаалах, эх дэлхийтэйгээ зөв харилцах дадлыг төлөвшүүлэх зорилгоор улирал бүр зохион байгуулдаг “Лусын тамга” арилгах арга хэмжээ, “Талын салхи” мото фестиваль, Зочлох, үйлчлэх салбарын сургалт, “Манай нутгаар аялаарай” контент, “Амттай аялал” нэртэй 3 цуврал нэвтрүүлэг, “Хутагтын нутгаар-Торгон хил-2021” арга хэмжээ, “Ай Ти Эм” ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэн, “Лусын тамга”, “Сайншанд авто кросс-2023” уралдаан, “KHAMAR MONASTERY-2023” засмал замын болон уулын замын дугуйн уралдаан, “Их говийн тэмээ”-ний уралдаан, МҮОНРТ-ээр Дорноговь аймгийн түүх соёлын хосгүй үзмэрийн зэрэг олон нийтэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Аялал жуулчлалын гол бүс нутгуудын танилцуулга, дэлгэрэнгүй мэдээллийг “http://www.touristinfocenter.mn, https://joinme.mn/ цахим сайтуудад байршуулж, аяллын хөтөлбөр, үнийн болон дараа төлбөрт үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн. Говийн догшин ноён Хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтан Ханбаянзүрх хайрханы гэрэлтүүлэг зам талбайг өргөтгөж, засварлах, Шамбалын орон, Ханбаянзүрх хайрхан орчимд нийтийн бие засах газрууд, Хамарын хийдийн Шамбалын орныг 108 агуйтай холбосон автозам, зогсоол хийх ажил, Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамын засвар шинэчлэл зэрэг ажлуудыг хийж орон нутгийн төсвөөс 2 тэрбум төгрөгийг зарцуулан жуулчдыг татах, аялал
--	--	--	--	--	--

						жуулчлалын бүсэд аялагчдын ая тухтай аялах нөхцөл боломжийг бүрдүүллээ. “Хамарын хийд”, "Ханбаян зүрх хайрхан уул"-ын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын мэдээгээр дотоодын 88400, гадаадын 1661, "Их нарт"-ын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын тоогоор гадаадын 116, дотоодын 165 аялагч, нийт 90342 аялагч аялсан нь өмнөх онтой харьцуулахад 11.2 хувиар өссөн.	
106		8.2.2. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг шинэлэг байдлаар сурталчилна.	2021 2025	- -	Цахим хандалтын тоо	"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/417 дугаар захирамжийн дагуу DTV орон нутгийн телевизтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах контент бэлтгэх ажлын гэрээг байгуулан Даланжаргалан сумын Их нарт, Сайншанд сумын Хамарын хийд, Эрдэнэ сумын бүрдэнэ булаг, аймгийн байгалийн болон түүхийн есөн гайхамшгийн танилцуулга боловсруулах ажлыг хийж байна. Мөн “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд Сайншанд 7, Замын-Үүд 2 нийт 9 жуулчны бааз, Сайншанд 8, Замын-үүд 11, Айраг 3, Алтанширээ1, Дэлгэрэх 1, Даланжаргалан 5, Хөвсгөл 2, Улаанбадрах 2, Мандах 1 нийт 34 зочид буудал, 16 гэр буудал, 9 хоолны газар, 2 сувиллын газрын мэдээллийг цахимд оруулснаас 6 буудал, 2 сувилал мэдээллийг QR кодоод оруулж, орон нутгийн аялал жуулчлалын 5 минутын видео танилцуулга бэлтгэж тус газрын https://do.mne.gov.mn/, https://www.dornogovi.gov.mn/intro/ сайтад байршуулж олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн http://www.touristinfocenter.mn, https://joinme.mn/ цахим сайтуудад орон нутгийн аялал, жуулчлалын гол бүс нутгуудын танилцуулгыг оруулж 91479 гаруй хандалт авсан нь өмнөх оноос 8.2 хувиар өссөн.	90%

						Аймгийн талаарх мэдээ мэдээлэл, аймгийн онцлог, бүтээн байгуулалт, амьдрах таатай орчин, аялал жуулчлал, бизнес эрхлэх боломж, газар зохион байгуулалт, ажлын байрны зар мэдээг авах боломжийг бүрдүүлсэн гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшныг бүтээж 4200 гаруй иргэн татан ашиглаж байна. Цаашид хөгжүүлэлт хийж төлбөр тооцоо, аймгийн төрийн цахим үйлчилгээ авах, аялал жуулчлалын чиглэлийн мэдээллийг авах, санал хүсэлт, санал асуулга гэх мэт нэг дороос аймгийн талаарх үйлчилгээ, мэдээллийг авах боломжийг бүрдүүлэхээр "Цахим Дорноговь" хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
107		8.2.3. Үндэсний зан заншил, уламжлал, түүх соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	2021 2025	-	-	Уламжлал мал аж ахуйн амьдрал, түүх соёл, унаган байгал, нүүдэлчин ахуйг танилцах зорилготойгоор "Их говийн тэмээ-2023" наадам, "Лусын тамга" арилгах арга хэмжээ, "НОЁН ХУТАГТЫН ӨВ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, "Адистэд хурсан гайхамшиг" тусгай үзэсгэлэнг тус зэрэг үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж нутаг орны онцлогийг сурталчлан танилцуулсан. Мөн "Талын салхи" мото фестиваль, "Сайншанд авто кросс-2023" уралдаан, "KHAMAR MONASTERY-2023" засмал замын болон уулын замын дугуйн уралдаануудыг амжилттай зохион байгуулж, нийт 10000 гаруй иргэд үзэж сонирхохоос гадна хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Үндэсний бахархал, өв соёлыг сурталчилсан, үндэсний онцлогийг агуулсан, 130 гаруй төрлийн эд өлгийн зүйлсийг дэлгэн AR технологиор дамжуулан гар утсаараа мэдээллээ авах боломжийг олгож "Danzanravjaa museum" аппликейшныг хийлгэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Энэхүү апплейкишнээр	100%

					иргэд музейн бүх төрлийн мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн. Соёлын өвийн өвлөн уламжлагчдаар дамжуулан аймгаа сурталчлах зорилготойгоор "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль, "Ай Ти эм-2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 7 ай савын 31 өвлөн уламжлагч, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 компани, 2 байгууллага оролцож өөрийн орон нутгийн соёлын биет бус өвийн онцлогыг гадаад дотоодын 3500 гаруй жуулчдад танилцуулсан. Соёлын аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр Алтанширээ сумын Соёлын төвтэй хамтран сумын төвд ойрхон дурсгалт газрыг түшиглэж аялал жуулчлалын маршрут гарган анхны аяллыг зохион байгуулсан. Музейн дэргэд "Эвийн эгшиг" уртын дууны дугуйлан, "Увдист ятга" ятга хөгжмийн дугуйлан хичээллэж байна. Үндэсний зан заншил, түүх, соёлыг хүүхэд залуучуудад түгээн дэлгэрүүлэх зорилгоор Музейн боловсролын хөтөлбөрүүдийг шинэчлэн "Зэр зэвсэг", "Монгол гэр", "Би зураач", "Миний монгол хувцас", "Мандала" зэрэг хөтөлбөрүүдийг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхэд сурагчдад зохион байгуулж 2021-2023 онд 1516 хүүхэд, 2024 онд 905 хүүхэд хамруулсан. 2020 оноос эхлэн Сайншанд суман дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрууд, хөшөө дурсгалуудыг түшиглэн "Сити тур" хотын аяллын хөтөлбөрийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зохион байгуулж хэвшсэн. "Хамарын хийд", "Ханбаян зүрх хайрхан уул"-ын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын мэдээгээр дотоодын 88400, гадаадын 1661, "Их нарт"-ын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын
--	--	--	--	--	--

						тоогоор гадаадын 116, дотоодын 165 аялагч, нийт 90342 аялагч аялсан. Өмнөх онтой харьцуулахад 11.2 хувиар өссөн.	
108	8.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.	8.3.1. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих замаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	2021 2025	-	Үзүүлсэн дэмжлэгийн тоо Нэмэгдсэн ажлын байрны тоо	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах чиглэлээр 2021-2024 онд Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Эрдэнэ, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 20 төсөл хэрэгжүүлэгчид 608,6 сая, Засгийн газрын “Хүнсний болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” 5-6 хувийн хүүтэй зээлд мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч 4 аж ахуйн нэгж, 1 иргэнд 465,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Хүнс,хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/26 дугаар тушаалаар “Загвар хоршоо байгуулах” зээлд "Олон ширээ", "Боржигон туяа" хоршоод хамрагдан нийт 590.0 сая төгрөгийн санхүүжилт авч, арьс шир, түүхий эд боловсруулах үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. “Цагаан сүүний буян” ХХК, “Өлзийт баян мод” ХХК эрчимжсэн аж ахуй эрхлэх, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 360,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлийн байраа шинэчлэн, тоног төхөөрөмжөө нэмснээр борлуулалтын орлого нь 1.1%-р өссөн. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд нийт 213 иргэн 3,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хөдөө аж ахуй, түүхий эд бэлтгэх чиглэлээр авсан.Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд МАА гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах чиглэлээр 7 хоршоонд 520 сая төгрөгийн зээл олгосон байна. Тайлант хугацаанд дээрх эх үүсвэрүүдээс нийт 6 ААН, 9 хоршоо, 240 иргэнд 6,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулахад дэмжлэг үзүүлснээр	90%

						эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх боломжийг бүрдүүлсэн.	
109		8.3.2. Бэлчээрийн төлөв байдал, даацад тулгуурлан нөхөн сэргээх, хөдөөгийн усан хангамжийг нэмэгдүүлэн бэлчээр ашиглалтыг сайжруулна.	2021 2025	-	Шинээр гарсан, сэргээн засварласан худгийн тоо	Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу жил бүрийн 8 дугаар сард бэлчээрийн төлөв байдлын, ургац тодорхойлох судалгааны ажлыг 14 сумын 54 багийн 72 ажиглалтын цэгт гүйцэтгэсэн. Дээрх судалгааны дүгнэлтэд үндэслэн бэлчээр усжуулах, өвөлжилтийн бэлтгэл хангах, отор нүүдлийн зохион байгуулалтыг хэрэгжүүлж ирсэн. Үүнд: 2021 онд: Нийт бэлчээрийн газрын 47 хувь хүрэлцээтэй буюу нөөцтэй, 53% нь даац 1-5 дахин хэтэрсэн; 2022 онд: Нийт бэлчээрийн газрын 35.3 нь хувь хүрэлцээтэй буюу нөөцтэй, 64.7 % нь даац 1-5 дахин хэтэрсэн; 2023 онд: Нийт бэлчээрийн газрын 41.8 нь хувь хүрэлцээтэй буюу нөөцтэй, 52.8 % нь даац 1-5 дахин хэтэрсэн; 2024 онд: Нийт бэлчээрийн газрын 98.7% нь хувь хүрэлцээтэй буюу нөөцтэй, 1.3% нь даац 1-5 дахин хэтэрсэн (сумдын төвийн орчимд) болохыг тогтоосон. Тайлант хугацаанд улсын төсвийн 252,3 сая төгрөгийн хөрөнгөөр 8 инженерийн хийцтэй худаг, аймаг орон нутгийн төсвийн 342 сая төгрөгийн хөрөнгөөр 7 инженерийн хийцтэй худаг, Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Мандах, Сайхандулаан, Замын-Үүд, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ сумдын сум орон нутгийн хөгжлийн сангийн 1 тэрбум 777,6 сая төгрөгийн хөрөнгөөр 52 инженерийн хийцтэй худаг, 61 гар худгийг шинээр шинээр болон сэргээн засварлах ажил хийгдсэн. 2021-2024 онд 128 худгийг шинээр болон сэргээн засварласнаар 178 мянган га бэлчээрийг усжуулж 217.8 мянган толгой малыг услах боломж	100%

						нөхцөл бүрдүүлж, 2020 онтой харьцуулахад бэлчээр усжуулалт 2.9 хувиар өссөн.		
110		8.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ.	2021-2025	-	-	Шинээр нэмэгдүүлсэн өндөр ашиг шимт мал, Шинээр тархаан сайжруулсан хээлтүүлэгч малын тоо толгой	Малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэхээр “Дэлгэрэхийн улаан омог”-ийн ишгэн ухна 877, барга, үзэмчин үүлдрийн 322 хурган хуц, нийт 1199 толгой өсвөр хээлтүүлэгч бэлтгэн бойжуулсан. Биотехнологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн зохиомол хээлтүүлгийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд Алатау, Хар тарлан үүлдрийн 442 толгой үхэр, 3716 нутгийн монгол хонь, Дэлгэрэхийн улаан омгийн ямааны нийт 4158 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийж нутгийн малын ашиг шимийг сайжруулсан. “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас Алтанширээ, Сайншанд, Замын-Үүд, Хөвсгөл сумд мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх, эрчимжсэн аж ахуйн эрхлэх 2 иргэн, 2 аж ахуйн нэгжид 263,0 сая, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5-6 хувийн хүүтэй зээлийг арилжааны банкаар дамжуулан эрчимжсэн мал аж ахуй эрхлэх 4 аж ахуйн нэгж, 1 иргэнд 465,0 сая төгрөг, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас “Цагаан сүүний буян” ХХК, “Өлзийт баян мод” ХХК-д 360,0 сая төгрөг, “Очир баян хүү” ХХК нь 175,0 сая нийт 1263,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 6 сумын 11 хоршоо 2,7 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна. Өндөр ашиг шимт малын тоо 79506 толгойд хүрч, 5 төрөл дээрээ 1,4%-иар өссөн нь нийт мал сүргийн 2,7 хувийг эзэлж байна.	90%
111		8.3.4. Мал эмнэлгийн ажил,	2021-2025	-	24,9	Гэрчилгээний тоо,	Мал эмнэлгийн ажил үйлчилгээг сайжруулах зорилгоор 14 сумын 30, Мал эмнэлгийн	100%

		үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулж, экспортыг нэмэгдүүлнэ.		шинжилгээнд хамрагдсан малын тоо, зарцуулсан зардал	үйлчилгээний нэгж, 250 иргэнд хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг 1 удаа зохион байгуулахад 8 төрлийн зөрчил илэрсэн нь мөн оны өмнөх үеэс шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийн тоо 2,5 дахин нэмэгдэж, зөрчлийн тоо 2 дахин нэмэгдэж, зөрчлийг бүрэн арилгасан. Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах зорилгоор аймаг, сумын төвд үйл ажиллагаа явуулдаг махны 1 үйлдвэр, худалдан борлуулах төвлөрсөн 8 цэг, мах бойны 4 цэгт 1 удаа хяналт шалгалтыг хийж, 6 алдаа дутагдал илрүүлсэн. Төрлөөр нь үзвэл худалдан борлуулах цэгийн эрүүл ахуй, ажлын байрны хувцасгүй, мал эмнэлгийн гэрчилгээ аваагүй байсныг илрүүлэн холбогдох газрын мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч, зөрчлийг бүрэн арилгасан. Хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах зорилгоор Мал эмнэлгийн газрын лабораторийн ариун цэврийн шинжилгээнд 71.3 тн мах, 1.6 тн сүү, сүүн бүтээгдэхүүнийг хамруулан, 2.1 сая төгрөгийн төсөвт төвлөрүүлэн иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангасан. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, мал малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, баталгаажуулалтын 20616 ширхэг гэрчилгээ бичигдэж, нийт 5063.3 тн мах, 1641.1 тн ноос, ноолуур, 120,0 мянган ширхэг өндөг, 178858 ширхэг арьс шир, 0,5 тн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, 331218 толгой амьд малыг үзлэг, тандалтад хамруулж, бүтээгдэхүүнд шинжилгээ хийсэнд мал эмнэлгийн улсын 7 байцаагч хяналт тавьж баталгаажуулсан. Мал эмнэлгийн зөрчилтэй 97 гэрчилгээг татгалзаж, 69 гэрчилгээг шалгаж, гаднаас чиглэлтэй 31 гэрчилгээг зөвшөөрч, батлагдаагүй 130 ш,
--	--	--	--	--	--

					саатуулсан гэрчилгээ байхгүй нийт 227 ш цахим гэрчилгээ буюу 5.5 хувь нь зөрчилтэй байгааг тухай бүр хяналтад авч зөрчлийг арилгуулан ашиглалтыг сайжруулсан. Мал, мах бэлтгэн нийлүүлэхтэй холбогдуулан аймгийн Цагдаагийн газартай хамтран 4 удаагийн арга хэмжээ, өдөр бүрийн хяналтыг мал эмнэлгийн нэгдсэн системээр дамжуулан зохион байгуулж, 15 зөрчлийг илрүүлэн 1.2 сая төгрөгийн шийтгэлийг ногдуулсан. Амьд малын экспортыг нэмэгдүүлэн малчдын амьжиргааг дэмжих ажлын хүрээнд Замын-Үүд сумын “Мал эрүүлжүүлэн тусгаарлах бүс”-д нийлүүлэгдсэн 55000 мянган толгой амьд малыг 2 улсын мал эмнэлгийн хорио цээрийн шаардлагыг хангуулан БНХАУ-руу гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулсан. Мөн оны өмнөх үетэй харьцуулахад борлуулагдсан малын 3,2 дахин буурсан нь гадаад зах зээлд махны үнэ ханш буурсантай холбоотой.	
112	8.3.5. Атрын IV аяныг хэрэгжүүлж, орон нутгийн онцлогт тохирсон газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг тогтвортой өсгөнө.	2021 2025	-	364.3	Нэмэгдсэн талбайн хэмжээ /мкв, га/ “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх, хүнсний ногооны хангалтыг нэмэгдүүлэх, өрхийн тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Шинэ хөдөө” төслийг хэрэгжүүлж төслийн хүрээнд 952,5 сая төгрөгийн үнэ бүхий 4 төрлийн хэмжээст хүлэмж 350 ш, 899,2 сая төгрөгийн үнэ бүхий дугуйт трактор,анжис, роторт сийрүүлүүр, төмс суулгагч зэрэг тоног төхөөрөмж, 38,0 сая төгрөгийн үнэ бүхий 1,5 тн-ы багтаамжтай 40 ш усны нөөцийн савыг шинээр нэмэгдүүлэн 14 сумын газар тариалан эрхлэгчдэд олгосон. Мөн Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2023 оны тариалалтад 80 хувийн хөнгөлөлттэй олгосон 11 төрлийн хүнсний ногооны	100%

						үрийг 14 сумын газар тариалан эрхлэгчдэд олгон дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд 356 өрх, 30 аж ахуйн нэгж, байгууллага төмс 23 га, хүнсний ногоо 68 га, малын тэжээл 116,24 га, жимс, жимсгэнэ 9,6 га, нийт 217,3 га талбайд тариалалт хийж 590 - 600тн ургац хураан авч байна. Газарт тариалангийн салбарт бага оврын трактор 63, үрлэгч 25, ухагч 4, 38,9 га-ын дуслын усалгааны систем, 1500 м2 өвлийн хүлэмж 3 ш, 35520 м2 зуны хүлэмж 415 ширхэг, 1284 тонны багтаамж бүхий 32 зоорийг ашиглаж байна. Салбарын үйл ажиллагааг суурь түвшинтэй харьцуулбал тариалангийн талбайн хэмжээ 132,4 га-аар, зоорины хангамж 300 тонноор, техникийн хангамж 63,4%-р, хамгаалагдсан хөрсний тариалалт 26600 м2-аар тус тус нэмэгдсэн. Хүн амын төмс, хүнсний ногооны хангамж 25,34% болж 2020 оноос 14,6 хувиар нэмэгдсэн.	
113		8.3.6. Мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 2025	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Бэлчээрийн даац, төлөв байдлаас шалтгаалан 2021-2024 онд аймаг, сум, малчдын түвшинд бэлтгэвэл зохих нөөцийн хэмжээг ЗГ-ын тогтоолд тусгаснаар аймаг, сумын нөөцөд 3480 тн өвс, 2020 тн тэжээл бэлтгэх даалгавартайгаас аймаг, сумын нөөцөд 3489,7 тн өвс, 1497,2 тн тэжээл бэлтгэн 62,1-100 хувьтай хангаж ирсэн. “Гамшигт тэсвэртэй ХАА” төслийн хүрээнд 3 суманд 4 га талбайд малын тэжээлийн ургамлыг туршилтаар тариалж, бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч зэрэг 70,2 сая төгрөгийн техникийн шинэчлэл, “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Иххэт сумын “Өнгөт” малчдын бүлэгт 79,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлж дэмжлэг үзүүлснээс гадна 3 сум “Хоршоо хөгжүүлэх	100%

					сан"-аас Малын тэжээлийн ургамал тариалах 2 хоршоо, 1 ААН-д нийт 170,0 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Замын-Үүд суманд 2, Даланжаргалан, Иххэт сумдад тус бүр 1 хадлангийн салаа үйл ажиллагаа явуулан, хадлан тэжээл бэлтгэж хэвшсэн. Даланжаргалан сумын Бичигт багийн малчдын "Хөдөлмөрлөх эвт хад" хоршооны хадлангийн салаа Хэнтий аймагт хадланд гарч 80 тн өвс бэлтгэж 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэлээ базаасан. Малын тэжээлийн ургамал тариалах төлөвлөлтийн дагуу сумдын Засаг дарга нарт чиглэл өгч, ногоон тэжээл тариалах болон соёолж бэлтгэх зөвлөмжийг 14 суманд хүргүүлж ажилласнаар аймгийн хэмжээнд 8 сум 116.24 га-д малын тэжээлийн ургамал тариалж,нийт 146.6 тн ургац хураан авсан нь 2020 онтой харьцуулахад талбайн хэмжээ 106 га-аар, ургац 133,9 тн-оор тус тус нэмэгдсэн. Өвс тэжээл хадгалах, аюулгүй нөөцийг бүрдүүлэх агуулахыг Дэлгэрэх, Иххэт, Эрдэнэ сумдууд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 313,7 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр байгуулснаар аймгийн нийт сумд мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангахад өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэн хадгалах агуулахтай блсон. Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоолоор тус аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл нийт аймгийн хэмжээнд 660 тн өвс, 500 тн тэжээл бэлтгэх даалгавартайгаас одоогийн байдлаар аймгийн аюулгүйн нөөцөд 600 тн өвс, 209 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 648.9 тн өвс 268.9 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 97.8 хувьтай хангагдсан.	
--	--	--	--	--	--	--

						Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор Мобиком, Скайтел компаниудтай тус тус гэрээ байгуулан “Масс мессеж” үйлчилгээг хэрэгжүүлж, цаг агаарын болон цаг үеийн мэдээллийг давхардсан тоогоор нийт 576516 иргэн, малчинд хүргэсэн. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолоор 6 сумын нийт 108,9 га бэлчээрийн газрыг “Сум дундын отрын нөөц нутаг”-аар тогтоож, 5 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Отор нүүдлийг оновчтой зохион байгуулах ажлын хүрээнд хил хамгаалах ерөнхий газар, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн удирдлагуудад отор нүүдэл хийх санал хүргүүлж, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд сумд хил залгаа сумдтайгаа отор нүүдэл хийх гэрээ байгуулсан. Мөн Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын “Хэрлэнбаян-Улаан” отрын бүс нутгийн бэлчээр ашиглалтыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бүс зөвлөлийн хуралд оролцож уг отрын бүс нутагт Дорноговь аймгаас 10 мянган толгой малыг отроор өвөлжүүлэх зохицуулалтыг хийсэн.	
114	8.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.	8.3.7. Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлж, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.	2021 2025	-	Хяналт шалгалтад хамрагдсан ААН, иргэдийн Тохирлын үнэлгээнд хамруулсан худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, тоо	Монгол, Япон 2 улсын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Япон улсын зах зээлд "Монголын үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ"-г танилцуулах цахим форумд "Хамарын хийд"-ийн түүхэн бүтээл, “Загсгал цай”, "Орон нутгийн-Онцлох бүтээгдэхүүн" улсын арга хэмжээнд “Тарвас”, “Загсгал цай”, “Тансаг цагаан” ингэний хоормог, Монгол-Хятадын хамтарсан “Талын түнш” арга хэмжээнд 12 үйлдвэрлэл эрхлэгч тус тус оролцож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилан боруулалт хийсэн.	100%

					бүтээгдэхүүний тоо “Шинэ-Хоршоо” хөдөлгөөний нээлтийн 4 томоохон арга хэмжээнд 4, “Цагаан сар”, “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 648 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо нөхөрлөл, малчид оролцож 486.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Салбарын ерөнхий байцаагчдын баталсан 25 удирдамжийн хүрээнд давхардсан тоогоор нийт 1182 объектын хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 3790 зөрчил дутагдлыг илрүүлж 1712 буюу 45,17%-ыг арилгуулан, зөрчил ихээр илэрсэн 102 иргэн, аж ахуй нэгжид улсын байцаагчийн 103 албан шаардлага, 56 иргэн, аж ахуй нэгжид улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, 16 аж ахуй нэгжид 47,5 сая, 30 иргэнд 13,0 сая нийт 59,8 сая төгрөгийн торгууль ноогдуулж, 527 нэр төрлийн 6820 ширхэг, 14,4 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч устгалд оруулсан. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хүрээнд 417 жин хэмжүүр, хүнд даацын жин 64 авто пүү, 241 шатахуун түгээх станцын шингэн хэмжигч, айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжийн 1013 усны тоолуур, 118 ширхэг автоцистерн баталгаажуулж, нийт 1853 ширхэг хэмжих хэрэгсэлд гэрчилгээ олгосон. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд чиглэсэн 19 удаагийн сургалтад нийт 618 иргэн, 97 аж ахуйн нэгж, төрийн байгууллагын 124 төлөөллийг хамруулж, 428 стандартыг үнэ төлбөргүй олгосон. Сайншанд сумын 2-р багийн нутагт “Дорноговьд үйлдвэрлэв” төвийг байгуулж, бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг мэдээллийн нэгдсэн сан (онлайн платформ)-д байршуулан гадаад, дотоодын зах зээлд таниулан сурталчлан ажиллаж байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 176 хоршоо байгуулагдаж 1698
--	--	--	--	--	--

					малчин хоршоонд бүртгүүлэн хоршооны гишүүн 404 малчин 14,6 тэрбум төгрөгийнхөнгөлөлттэй зээлийг авсан. Дээрх хоршоодын 83% нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх чиглэлийн үйл ажиллагааг хийж байна. “Түншлэл ба хөгжил” аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд 10 хүртэлх ажилтантай, жилийн 300,0 хүртэлх борлуулалтын орлоготой бичил аж ахуйн нэгжүүдэд жилийн 3 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулалтыг зарлан нийт 69 төсөл хүлээн авч, сонгон шалгаруулалтын шатандаа байна.	
					ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	91.2%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАЙЛАН ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Н.ХОНГОРЗУЛ

У.ШИНЭЧИМЭГ

Д.ЦЭНГЭЛМАА